



ЖЕНДЭРИЙН  
ҮНДЭСНИЙ ХОРОО



# СЭТГҮҮЛ ЗҮЙН БА НИЙГМИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БОДЛОГЫН ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖИД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

2021-2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТӨЛӨВЛӨГӨӨ

---

Зөвлөх үйлчилгээний тайлан

---

Улаанбаатар хот  
2020 он

# Энэхүү зөвлөх үйлчилгээний тайланг НҮБХАС-гийн дэмжлэгтэйгээр Жендэрийн Үндэсний Хорооны ажлын албаны захиалгаар бэлтгэв.

Тайлан бэлтгэсэн: Г.Гүнжидмаа, хэвлэл мэдээллийн шинжээч

Зөвлөх: Б.Онон, Жендэрийн үндэсний шинжээч

Туслах судлаач: А.Амартүвшин, сэтгүүл зүйн багш

## **ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО**

Монгол Улс, Улаанбаатар хот, 14200-0063

Сүхбаатар дүүрэг, Нэгдсэн Үндэстний гудамж-20

Утас: (976- 70071116)

Цахим хуудас: [www.gender.gov.mn](http://www.gender.gov.mn)

## **АГУУЛГА**

### **I. ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГАЧЛАЛ**

### **II. СЭТГҮҮЛ ЗҮЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ (JOURNALISM MEDIA)-ИЙН ЖЕНДЭР, ЖСХ-ИЙН ТАЛААРХ БОДЛОГЫН ҮНЭЛГЭЭ**

- Сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн агуулга дахь жендэр, ЖСХ-ийн талаар баримтлах редакцын бодлого, ёс зүйн зарчим

- Хэвлэл мэдээллийн байгууллагуудын жендэр, ЖСХ-ийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх редакцын чадавх, бэлэн байдлын үнэлгээ

- Хэвлэл мэдээллийн байгууллагуудын жендэр, ЖСХ-ийн талаарх бодлогын хэрэгжилтийн хяналт, хариуцлага: хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт

### **III. НИЙГМИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ (SOCIAL MEDIA)-ЭЭР ЖЕНДЭР, ЖСХ-ИЙН ТАЛААР МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ ГАРГАХ БОДЛОГЫН ҮНЭЛГЭЭ**

- Нийгмийн хэвлэл мэдээлэлд редакцын жендэр, ЖСХ-ийн талаар баримтлах бодлогын үнэлгээ

- Нийгмийн хэвлэл мэдээлэлд жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх чадавх, бэлэн байдлын үнэлгээ: Монгол болон бусад улс орнуудын туршлагаас

- Нийгмийн хэвлэл мэдээлэлд жендэрийн мэдрэмжтэй байдлын хяналт, хариуцлага: эрх зүйн болон өөрийн зохицуулалт

### **IV. ЗӨВЛӨМЖ**

### **V. СЭТГҮҮЛ ЗҮЙН БА НИЙГМИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2021-2022 ОНД/**

### **VI. ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

### **VII. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖУУД**

### **VIII. ХАВСРАЛТ**

## **НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГАЧЛАЛ**

### **Үнэлгээний зорилго**

Энэхүү үнэлгээ нь сэтгүүл зүйн ба нийгмийн хэвлэл мэдээллийн бодлогын жендэрийн мэдрэмжийг үнэлж, энэ чиглэлээр 2021-2022 онд Жендэрийн үндэсний хороо (ЖҮХ)-ноос хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зорилготой.

Үнэлгээнд хэвлэл мэдээллийн байгууллагууд редакцын бодлогодоо болон нийгмийн мэдээллийн хэрэгслийг ашиглахдаа жендэр, жендэрийн эрх тэгш байдал, жендэрийн мэдрэмж, жендэрт суурилсан хүчирхийлэл (цаашид ЖСХ гэнэ) гэсэн асуудлуудыг хэрхэн тусган нэвтрүүлж, хэрэгжүүлж байгааг авч үзлээ.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд хэвлэл мэдээллийн хараат бус шинжээчид үнэлгээний дараах аргуудыг ашиглан сэтгүүл зүй ба нийгмийн мэдээллийн хэрэгслийн бодлогын жендэрийн мэдрэмжийг үнэлж, цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлыг 2020 оны арванхоёрдугаар сард гүйцэтгэв.

### **Үнэлгээний аргачлал, судалгааны аргууд**

Үнэлгээний ажлын анхдагч мэдээллийг цуглуулахдаа социологийн судалгааны дараах аргуудыг ашиглав. Үүнд:

- 1) Баримт бичиг судлах арга: ЮНЕСКО-гийн Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн А4.1-ийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг жендэр, ЖСХ-ийн талаар хийсэн тоон болон чанарын судалгааны тайлан, гарын авлага, удирдамж зэрэгт үндэслэн хийх;
- 2) Мониторингийн арга: Сэтгүүл зүйн ба нийгмийн хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлогын жендэрийн мэдрэмж болон ЖСХ-ийн асуудлыг ёс зүйтэй сурвалжлах чиглэлээрх редакцын бодлого, дүрэм журам, ёс зүйн кодын хэрэгжилтийн байдлыг тандахдаа өргөн нэвтрүүлгийн 16 телевиз, өдөр тутмын 8 сонинтой утсаар холбогдож мөн 154 цахим мэдээллийн сайтад зочлон редакцын бодлого, ёс зүйн кодтой эсэхэд мониторинг хийж тоон мэдээллийг бүрдүүлэх;
- 3) Санал асуулгын арга: Сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн байгууллагуудаас жендэр, ЖСХ-ийн талаар редакцын баримтлах бодлого, чадавхын үнэлгээг хийхдээ 30 редакцын ерөнхий редакторуудаас санал асуулга авах (Хавсралт 1), мөн ЖСХ-ийн чиглэлээр мэргэшсэн 4 сэтгүүлчидтэй нүүр тулсан ярилцлагын аргаар мэдээлэл бүрдүүлэх;
- 4) Кейс судалгааны арга: Хүний эрх, жендэрийн мэдрэмж, ЖСХ-тэй холбоотой редакцын ёс зүйн алдааны эсрэг гаргасан иргэдийн гомдол болон хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын шийдвэрүүдийг түүвэрлэж, дүн шинжилгээ хийх;

5) Бүлгийн ярилцлагын арга: ЖСХ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудаас хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хэвлэл мэдээллийн хамтын ажиллагааны сайн туршлага, саад бэрхшээлийн талаар ярилцаж, цаашдын төлөвлөгөөнд саналыг тусгах;

### **Хүлээгдэж буй үр дүн**

Дээр дурдсан таван төрлийн судалгааны аргаар бүрдүүлсэн анхдагч мэдээллүүдийг нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх замаар сэтгүүл зүйн ба нийгмийн хэвлэл мэдээллийн бодлогын жендэрийн мэдрэмжийг үнэлж, жендэр, ЖСХ-ийн чиглэлээр цаашид хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна.

Үйл ажиллагааны төлөвлөгөө нь 2021, 2022 онуудыг хамрах бөгөөд үйл ажиллагааны чиглэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, суурь болон хүрэх түвшин, хамтрагч байгууллага гэсэн хэсгүүдийг багтаасан байна.

## **ХОЁР. СЭТГҮҮЛ ЗҮЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ (JOURNALISM MEDIA)-ИЙН ЖЕНДЭР, ЖСХ-ИЙН ТАЛААРХ БОДЛОГЫН ҮНЭЛГЭЭ**

### Нэр томъёоны тайлбарын тухайд:

Улсын Дээд Шүүхийн тайлбарт “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэдгийг “Зар сурталчилгааны тухай” хуулийн 3 дугаар бүлэгт 3.1.5 дахь хэсэгт “Мэдээлэх хэрэгсэл” гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерийн сүлжээ, тусгай програм, хэвлэл болон бусад арга хэрэгсэл” гэсэн утгаар ойлгоно<sup>1</sup> гэжээ. Үүнээс өөрөөр хэвлэл мэдээллийн хэрэгслийг эрх зүйн баримт бичигт тайлбарласан тодорхойлолт одоогоор алга. Сүүлийн үед хуульч, судлаачид хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ шаардлагыг хэлэлцэх, санал боловсруулах явцдаа “хэвлэл мэдээллийн хэрэгсэл”, “сэтгүүл зүйн үйл ажиллагаа” зэрэг ойлголтыг тайлбарлах, тодорхойлох оролдлогуудыг хийж байна. Тухайлбал, тус хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 2020 оны 2-р сарын 07-ны хувилбарт “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэж сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлдэг хэвлэл мэдээллийн байгууллага мэдээллийг олон нийтэд, эсхүл тодорхой бүлэг этгээдэд хүргэх зорилгоор ашиглаж байгаа сонин, сэтгүүл, радио, телевиз, редакцтай мэдээллийн сайтыг хэлнэ хэмээн, мөн “сэтгүүл зүйн үйл ажиллагаа” гэж мэдээлэл хайх, хүлээн авах, цуглуулах, боловсруулах, нягтлах, нийтлэх, нэвтрүүлэх, түгээх ажиллагааг хэлнэ<sup>2</sup> гэсэн хувилбаруудыг санал болгосон байна. Гэвч эдгээр нь батлагдсан баримтууд биш бөгөөд зөвхөн ажлын хэсгийн хүрээнд анхны саналын хэмжээнд яригдаж буйг дурдах нь зүйтэй.

Цахим хувьсал, технологийн дэвшлийн нөлөөгөөр хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаарх ойлголт өргөн хүрээг хамарч, олон нийтийн хэвлэл мэдээлэл (Mass Media)-ийг дахин тодорхойлох оролдлогуудыг эрдэмтэн судлаачид эрэлхийлсээр байна. Сүүлийн үед өрнөдийн судлаачид “Сэтгүүл зүйн хэвлэл мэдээлэл” (Journalism Media) хэмээх нэр томъёог ашиглах болсон нь нийгмийн хэвлэл мэдээлэл (Social Media)-ээс мэргэжлийн сэтгүүл зүйн үйл ажиллагааг ялгаатайгаар авч үзэж байгаатай холбоотой юм.<sup>3</sup>

Нийгмийн мэдээллийн хэрэгслүүд болох фэйсбүүк, твиттэр, инстаграм, юүтүб зэрэг нь сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тооцогдохгүй бөгөөд сэтгүүлчид сэтгүүл зүйн үйл ажиллагаандаа ашигладаг, иргэд мэдээллээ солилцож, түгээж хуваалцдаг талбар хэмээн ойлгоно. “Мэдээллийг хурдан түгээх нь сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн тэргүүлэх чиглэл биш. Нийгмийн мэдээллийн

<sup>1</sup> “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан” Глоб Интернэшнл төв, 2017 он, УБ хот

<sup>2</sup> Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ төсөл 2020 оны 2-р сарын 17, УБ хот

<sup>3</sup> Олон нийтийн хэвлэл мэдээллийг улс төрөөс хараат бус байлгах нь: хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын жишээн дээр, КАС-ын дэмжлэгтэй бодлогын судалгаа, Г.Гүнжидмаа, 2020 он

хэрэгсэлд байгаа энгийн иргэдээс ялгарах гол ялгаа нь сэтгүүл зүйн хэвлэл мэдээлэл ёс зүйн өндөр хариуцлага хүлээдэг явдал”<sup>4</sup> хэмээн мэргэжилтнүүд тэмдэглэж байна.

Өөрөөр хэлбэл, жирийн иргэн нийгмийн мэдээллийн хэрэгсэлд юу хэлэх, хэрхэн илэрхийлэх нь тухайн хүний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний илэрхийлэл болдог бол сэтгүүлч редакцын үйл ажиллагаандаа төдийгүй нийгмийн хэвлэл мэдээллийн талбарт ч ёс зүйн хэм хэмжээнээсээ халихгүй байх мэргэжлийн үүрэг, хариуцлагыг олон нийтийн өмнө хүлээдэг. Иймээс сэтгүүл зүйн хэвлэл мэдээлэл нь дагаж мөрдөх ёс зүйн дүрэм, хариуцлага хүлээх чадвараараа нийгмийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлж буй жирийн иргэдээс эрс ялгаатай.

Гэсэн хэдий ч технологи болон алгоритмын эрин үед сэтгүүл зүйн хэвлэл мэдээлэлд нийгмийн сүлжээ (Social Network) болон нийгмийн хэвлэл мэдээлэл (Social Media) хамгийн том сорилт болж байна. Учир нь худал мэдээлэл, мушгин гуйвуулсан мэдээлэл, ялгаварлан гадуурхалт, үзэн ядсан үг хэллэг тархаж түгэхэд нийгмийн мэдээллийн хэрэгсэл ихээхэн нөлөө үзүүлдэг. Иймд улс орнууд худал мэдээлэл, үзэн ядсан үг хэллэгтэй тэмцэхдээ сэтгүүл зүйн гүйцэтгэх үүргийн тодотгож, улмаар сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлдэг хэвлэл мэдээллийн байгууллага бүр нийгмийн мэдээллийн хэрэгслийг ашиглах “редакцын бодлого”-той байхыг уриалсаар байна.

Иймээс энэхүү үнэлгээний хүрээнд сэтгүүл зүйн ба нийгмийн хэвлэл мэдээллийн бодлогын жендэрийн мэдрэмжийг үнэлэхийг зорилоо. Үүний тулд:

Нэгдүгээр бүлэгт, сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн байгууллагуудад нийтлэл, нэвтрүүлгийн агуулгадаа жендэрийн мэдрэмжтэй байх бодлого, дүрэм, журам, ёс зүйн код, гарын авлага байдаг эсэх, түүнчлэн жендэр, ЖСХ-ийн асуудлаар бичихдээ дагаж мөрдөх ёс зүйн зарчим, удирдамж бий эсэх, үүнийг хэрэгжүүлэх бэлэн байдал, хяналт мониторингийн тогтолцооны талаар тандан судална.

Хоёрдугаар бүлэгт, хэвлэл мэдээллийн байгууллагууд нийгмийн мэдээллийн хэрэгсэлд баримтлах ёс зүйн дүрэм, бодлого, удирдамж, гарын авлагатай эсэх, энэ талын чадавх болон бэлэн байдал хэр хангагдсан, улмаар жендэр, ЖСХ-ийн асуудлаар нийтлэл, нэвтрүүлэг бэлдэж, цахимаар түгээхдээ редакцын түвшинд хяналт мониторинг хийж, хүний эрх зөрчсөн, жендэрийн тэгш бус байдал, хэвшмэл ойлголтыг дэвэргэсэн агуулгыг хэрхэн зохицуулдаг дотоодын болон гадаадын туршлагыг судалж зөвлөмж боловсруулахад чиглэнэ.

---

<sup>4</sup><https://www.gartia.ge/?option=content&view=category&id=7554>

## **2.1. Сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн агуулга дахь жендэр, ЖСХ-ийн талаар баримтлах редакцын бодлого, ёс зүйн зарчим**

Монголд улсад 2020 оны эхний байдлаар 502 хэвлэл мэдээллийн байгууллага тогтвортой үйл ажиллагаа явуулж буйгаас 140 телевиз, 51 радио, 84 сонин, 73 сэтгүүл, 154 цахим мэдээллийн сайтууд ажиллаж байна.<sup>5</sup> Сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлдэг эдгээр хэвлэл мэдээллийн байгууллагуудын жендэр, ЖСХ-ийн талаарх редакцын бодлогын өнөөгийн түвшинг үнэлэхдээ хэвлэл мэдээллийн мэргэжлийн байгууллагуудаас хийсэн тоон болон чанарын судалгаа, гарын авлага, удирдамж зэрэг баримт бичгүүдийг судлахаас гадна редакцуудтай холбогдож энэ чиглэлээр баримтлах редакцын бодлоготой эсэхийг тодруулав.

Жендэр, жендэрт суурилсан хүчирхийллийн чиглэлээр 2014-2020 онд Глоб Интернэшл төв, Хэвлэлийн хүрээлэн, Хэвлэл мэдээллийн зөвлөл, Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв зэрэг мэргэжлийн байгууллагууд тодорхой судалгаа, гарын авлага, удирдамж зэргийг бэлтгэж хэвлүүлжээ. Эдгээрийг дор жагсаавал:

- 2014 онд “Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт”-ийг ЮНЕСКО-гоос Олон улсын сэтгүүлчдийн холбоотой хамтран боловсруулсаныг Глоб Интернэшл төв монгол хэлнээ хөрвүүлжээ.
- 2017 онд “Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сэтгүүлчдийн ойлголт, редакцын бодлого, сэтгүүл зүйн практик” санал асуулга, контент анализын судалгааг НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Хэвлэлийн хүрээлэн гүйцэтгэв.
- 2017 онд “Жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг хөндөх нь” сургалтын хөтөлбөрийг НҮБ-ын Хүн амын сан, Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Хэвлэлийн хүрээлэн боловсруулжээ.
- 2018 онд “Хохирогч төвтэй мэдээлэл: ажлын байрны бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийн эрэн сурвалжлах нь” сэтгүүлчид болон редакторуудад зориулсан гарын авлагыг Хүйсийн тэгш эрхийн төвийн дэмжлэгтэйгээр Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв боловсруулжээ.
- 2018 онд “Цахим сайтууд дахь үзэн ядалтын үг хэллэг” агуулгын судалгааг Хэвлэл мэдээллийн зөвлөлийн захиалгаар Фридрих-Эбертийн сангийн дэмжлэгтэйгээр хараат бус судлаачид гүйцэтгэжээ.
- 2018 онд “Нийгмийн мэдээллийн сүлжээн дэх үзэн ядах үг хэллэг” фэйсбүүк талбар дахь агуулгын судалгааг Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв Хэвлэл мэдээллийн зөвлөл, Дойче Велле Академийн дэмжлэгтэйгээр хийжээ.
- 2019 онд “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр жендэрт суурилсан хүчирхийллийг хэрхэн хөндөж байна вэ? агуулгын судалгаа, “Жендэрийн мэдрэмж ба жендэрт суурилсан хүчирхийлэл” удирдамжийг НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Хэвлэлийн хүрээлэнгээс бэлтгэжээ.

---

<sup>5</sup> Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр, МХХ, 2020 он



- 2020 онд “Цахим орчинд редакцын баримтлах бодлого” сурвалжлагч, редакторуудад зориулсан гарын авлагыг Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс санаачлан боловсруулжээ.
- 2020 онд “Сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах бодлогын баримт бичиг” сурвалжлагч, редакторуудад зориулсан гарын авлагыг Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс санаачлан боловсруулжээ.

Түүнчлэн сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн байгууллагууд болон сэтгүүлчдийн өдөр тутмын үйл ажиллагаандаа баримталдаг ёс зүйн дүрмийн талаар судлан орууллаа. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим нь нэг талаар сэтгүүлчдэд түгээж буй мэдээллээ нягтлан шалгаж, эх сурвалжуудаар баталгаажуулж, хүний эрхийн мэдрэмжтэй нийтэлж нэвтрүүлэхийг сануулдаг бол нөгөө талаар ямарваа баримт нотолгоогүйгээр хэн нэгний нэр хүндэд халдах, гутаан доромжилсон үйлдлийг хүлээн зөвшөөрдөггүй. Иймд ардчилсан чөлөөт хэвлэл бүхий улс орнуудад сэтгүүлчдийн мэргэжлийн хэм хэмжээг мөрдүүлэх, ёс зүйн зөрчлийг засаж залруулахын төлөө хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын институт буюу Хэвлэл мэдээллийн зөвлөл оршин тогтнодог.

Монгол улсад хэвлэл мэдээллийн ёс зүйн хариуцлагыг иргэний оролцоотой хэрэгжүүлдэг хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага болох Хэвлэл мэдээллийн зөвлөл 2015 оны эхээр байгуулагдсан. Тус зөвлөл нь сонин/сэтгүүл, радио/телевиз, цахим сайт, орон нутгийн хэвлэл мэдээлэл, олон нийтийн гэсэн таван салбарыг төлөөлөх 45 гишүүнтэй (зургаан жилийн хугацаатай) бөгөөд тэдгээр нь Удирдах зөвлөл, Сонин, сэтгүүл, сайтын ёс зүйн хороо, Радио, телевизийн ёс зүйн хороонд хуваагддаг.

Хэвлэл мэдээллийн зөвлөл нь хэвлэн нийтлэгч эзэд болон сэтгүүлчдийн тэгш тооны оролцоо, төлөөлөлтэйгөө бүрэлдэн бий болсон бөгөөд эдгээр гол оролцогч талууд сэтгүүл зүйн үйл ажиллагаандаа баримтлах “Ёс зүйн зарчим” дээрээ нэгдэж, үүний хэрэгжилтийг хангадаг өөрийн зохицуулалтын тогтолцоог хүлээн зөвшөөрч дэмжсэн байдаг.

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015.04.14-ний өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралтаар “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ыг баталсан. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын удиртгалд “Монгол Улсын Үндсэн хуульд заасан үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хамгаалан бататгаж, Монголын сэтгүүл зүйн хэм хэмжээ нь хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний олон улсын хэм хэмжээг сахин мөрдөж буйг энэхүү ёс зүйн зарчмаар илэрхийлж байна” хэмээн заасан байдаг. Энэхүү ёс зүйн зарчмыг Монголын нийт хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид өдөр тутмын үйл ажиллагаандаа мэргэжлийн чиг баримжаа, ёс зүйн “жанжин шугам” болгон баримталдаг.

“Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим” нь 10 бүлэг 24 заалттай.<sup>6</sup> Тодруулбал дараах нийтлэг 10 зарчимтай.

Ёс зүйн зарчим 1. Олон түмэнд үнэнд нийцсэн мэдээлэл хүргэх, хүнлэг ёс, хүн чанарыг эрхэмлэх нь сэтгүүл зүйн эрхэм дээд үнэт зүйл мөн. Мэдээллийг нягтлах нь сэтгүүл зүйн нягт, нямбай үйл ажиллагааны үндсэн зарчим болно.

Ёс зүйн зарчим 2. Мэдээллийг шударга бус аргаар олж авахгүй.

Ёс зүйн зарчим 3. Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй.

Ёс зүйн зарчим 4. Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана.

Ёс зүйн зарчим 5. Мэдээллийг мушгин гуйвуулах, бусдыг гүтгэх, доромжлох, мэргэжлийн давуу байдлаа урвуулан мэдээллийг хувийн зорилгод ашиглахгүй. Мөн мэдээлэх, эс мэдээлэхийн тулд аливаа хэлбэрийн авилга авахаас татгалзана.

Ёс зүйн зарчим 6. Хувийн нууцад хүндэтгэлтэй хандана.

Ёс зүйн зарчим 7. Бусдын уй гашуу, зовлон шаналалд хүндэтгэлтэй хандана.

Ёс зүйн зарчим 8. Мэдээллийн нууц эх сурвалжаа чандлан хамгаална.

Ёс зүйн зарчим 9. Төлбөрт нийтлэл, нэвтрүүлгийг тусгай тэмдэг, тэмдэглэгээгээр ялгана.

Ёс зүйн зарчим 10. Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэр дэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ.

Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд мэдээллийг нягтлан шалгах, баталгаажуулах, мэдээллийг шударга аргаар олж авах, хэнийг ч ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй байх, аливаа мэдээллийг дуулиан шуугиантайгаар нийтлэхээс татгалзах, хувийн нууцад хүндэтгэлтэй хандах зэрэг чухал зарчмуудыг тусгасан байдаг. Гэвч хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлэг нь жендэрийн мэдрэмжтэй байх, хэвлэл мэдээлэлд эх сурвалжуудын дуу хоолойг илэрхийлэхдээ жендэрийн тэгш байдлын хангах, жендэр болон ЖСХ-ийн талаар нийтэлж нэвтрүүлэхдээ тодорхой зарчмуудыг баримтлах тухай нарийвчилсан, тусгайлсан заалт байхгүй байна.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд ХМЗ-өөс баталсан ёс зүйн зарчмыг мөрдлөг болгохоос гадна тухайн редакц нийтлэл, нэвтрүүлгийнхээ онцлогоос хамааран дотоод дүрэм журам, бодлоготой, мөн ёс зүйн нарийвчилсан удирдамжтай байх тохиолдол бий. Иймээс энэхүү үнэлгээний хүрээнд өргөн

<sup>6</sup> Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим, <https://www.mediacouncil.mn/p/7>

нэвтрүүлгийн 20 телевиз, өдөр тутмын сонины долоон редакцтай утсаар холбогдон “Редакцын бодлогын баримт бичиг бий эсэх, тийм бол жендэр, ЖСХ-ийн талаар тусгасан эсэх”-ийг тодруулсан юм.

Өдөр тутмын долоон сониноос Монголын мэдээ сонин редакцын бодлого байхгүй гэсэн бол бусад нь (Өнөөдөр, Өдрийн сонин, Өглөөний сонин, Зууны мэдээ, Монголын үнэн, Үндэсний шуудан) буюу 86% нь Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд тулгуурласан редакцын бодлоготой гэжээ.

Ингэхэд, 9 телевиз буюу 56% (МҮОНРТ, UBS, ТВ5, ТВ8, С1, NTV телевиз, Ийгл ТВ, Стар ТВ, ETV), өдөр тутмын 5 сонин буюу 62% (Өнөөдөр сонин, Өнөөдөр, Үндэсний шуудан, Монголын үнэн, Өглөөний сонин) нь редакцын бодлоготой, мөн Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг редакцын бодлогодоо баримтлан ажилладаг гэжээ.

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (2019)-ийн 5 дугаар зүйлд “Өргөн нэвтрүүлгийн бодлого, зохицуулалт болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн баримтлах зарчим”-ыг тусгасан байдаг. Тодруулбал, 5.1.6-т хариуцлагатай, мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлж, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөнө хэмээн заасан. Түүнчлэн тус хуулийн 31 дүгээр зүйл “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүрэг”-ийн 31.2.3-т радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчид ёс зүйн өөрийн зохицуулалт хийнэ хэмээн заажээ.

2020 оны эхний байдлаар өргөн нэвтрүүлгийн 20 суваг Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 12 өргөн нэвтрүүлгийн телевиз (60%) нь редакцын бодлого, зарчмыг дотооддоо боловсруулсан хэмээн үнэлгээний ярилцлагад мэдэгджээ. Эдгээрт МҮОНРТ, UBS телевиз, ТВ5 телевиз, SBN телевиз, ТВ8 телевиз, С1 телевиз, ТВ9 телевиз, NTV телевиз, Ийгл ньюс ТВ, Стар телевиз, ETV телевиз багтаж байна. Харин Монгол ТВ нь редакцын бодлогоо тусгайлан цогцоор боловсруулсан боловч хараахан батлаагүй байна гэжээ.

*Эшлэл 1. ТВ 8 телевизийн захирал М.Одгэрэл “Манайх жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөтэй хамт редакцын бодлого, зарчмаа шинэчилж байдаг. Дотоод бичиг баримт тул олон нийтэд ил нийтэлдэггүй.”*

*Эшлэл 2. ТВ 9 телевизийн мэдээний албаны дарга Б.Аринтуяа “Редакцын бодлого бий, хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг бид баримталдаг. Гэхдээ редакцын бодлогоо шинэчлэн боловсруулах эрмэлзэлтэй байна.”*

Өргөн нэвтрүүлгийн Сүлд телевиз, Малчин телевиз, VTV, Эх орон телевиз, ТМ телевиз, 25 дугаар суваг телевиз, Боловсрол суваг гэсэн 7 телевиз нь дотооддоо редакцын бодлого, зарчим байхгүй гэжээ.

Өдөр тутмын сонинууд болон өргөн нэвтрүүлгийн телевизүүд редакцын бодлого, зарчимдаа жендэрийн тэгш эрх, ЖСХ-ийн талаар нарийвчлан тусгаагүй байна.

Үнэлгээний хүрээнд 154 мэдээллийн сайтын цахим талбарт зочилж, редакцын бодлогоо олон нийтэд нээлттэй байршуулсан эсэх, хэрэв тийм бол ямар агуулгыг тусгасан талаар мониторинг хийлээ. Мониторингийн дүнгээр, 18 цахим мэдээллийн сайт буюу 12% нь цахим талбартаа редакцын бодлого, ёс зүйн зарчмаа байршуулжээ.

**Хүснэгт 1. Редакцын бодлого, ёс зүйн дүрмээ цахим талбартаа байршуулсан хэвлэл мэдээллийн сайтууд /2020 оны 12 дугаар сарын байдлаар**

№	Хэвлэл мэдээллийн цахим сайтууд	Байгуулагдсан он	Редакцын бодлоготой эсэх	Редакцын бодлогодоо жендэр, ЖСХ-ийн чиглэлийг тусгасан эсэх
1	Саакnews.mn	2006	Редакцын бодлого	байхгүй
2	gogo.mn	2007	Редакцын ёс зүйн дүрэм	байхгүй
3	iKon.mn	2013	Редакцын бодлого	байхгүй
4	Ontsloh.mn	2013	Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим	байхгүй
5	Zaluu.mn	2014	Редакцын бодлого	байхгүй
6	Yolo.mn	2016	Редакцын зарчим, Олон нийтийн стандарт	байхгүй
7	Today.mn	2017	Ёс зүйн зарчим	байхгүй
8	Ekhsurvalj.mn	2017	Редакцын бодлого	байхгүй
9	Maamuu.mn	2017	Редакцын зарчим, Олон нийтийн стандарт	байхгүй
10	Tug.mn	2018	Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим	байхгүй
11	Todnews.mn	2018	Редакцын бодлого	байхгүй
12	Ulsturch.mn	2018	Редакцын бодлого	байхгүй
13	Dornod.today	2018	Редакцын бодлого	байхгүй
14	N24.mn	2018	Редакцын бодлого	байхгүй
15	Urug.mn	2019	Редакцын бодлого	байхгүй
16	Factcheck.mn	2019	Редакцын бодлого	байхгүй
17	Livetv.mn	2019	Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим	байхгүй
18	Tsahiur.mn	2020	Редакцын бодлого	байхгүй

Өдөр тутмын сонинууд болон цахим мэдээллийн сайтуудын редакцын бодлого харилцан адилгүй агуулга, хэмжээтэй боловч ихэвчлэн ХМЗ-өөс баталсан “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ыг бүтнээр нь авах, эсвэл үндсэн заалтуудад тулгуурлан өөрийн редакцын онцлогийг тусгасан байна. Зарим редакц “Сэтгүүлч бүр энэхүү ёс зүйн зарчмаа хүлээн зөвшөөрч баримтлан ажиллана” хэмээн үүрэг болгожээ. Мөн цөөнгүй редакц өөрсдийн нийтлэлийн онцлогоо тодорхойлж, редакцын бодлогоороо дамжуулан хэвлэл мэдээллийн зах зээлд ялгарлыг бий болгож буйг энд тэмдэглэх нь зүйтэй. Жишээлбэл;

Монгол контент ХХК-аас эрхлэн гаргадаг өсвөр насныханд зориулсан төрөлжсөн сайт болох [Yolo.mn](http://Yolo.mn) сайт, бага насныхан болон тэдгээрийн эцэг эхчүүдэд зориулсан [Maamuu.mn](http://Maamuu.mn) сайтууд редакцын бодлогодоо дараах дөрвөн зарчмыг тусгаснаараа бусдаас онцлогтой бөгөөд дэвшилттэй байв. Үүнд: 1) Мэдээ мэдээллийн зарчим, 2) Олон нийтийн сүлжээнд хандах зарчим, 3) Нууцлалын бодлого, 4) Олон нийтийн зарчим хэмээн тусгайлан боловсруулжээ.

[Ekhsurvalj.mn](http://Ekhsurvalj.mn) мэдээллийн сайт редакцын бодлогодоо “хүүхдийг хамгаалах”, “ярилцлагын зочинтой үнэнчээр харилцах”, “нийгмийн эсрэг болон гэмт хэргийн шинжтэй үйлдлийг дагах дуурайх сэдэл төрүүлэхээс зайлсхийх” зэрэг онцлогтой заалтуудыг тусгажээ.

[Todnews.mn](http://Todnews.mn) сайт редакцын бодлогодоо “эрдэм шинжилгээ, инженерчлэл, мэдээлэл харилцаа холбоо, технологи, шинжлэх ухааны бодит дэвшил оюунлаг мэдээллийн ТОД хөтөч байна” хэмээн тусгажээ.

[Urug.mn](http://Urug.mn) сайтын редакцын бодлогодоо: 1) эерэг, сайн сайхан бүхнийг түгээнэ, 2) бүтээнэ, шүгэл үлээгч нарыг дэмжинэ, 3) шүгэл ч үлээнэ, баримт дэлгэнэ, 4) нийгмийн цөөнхийн нүд, чих болно, 5) ус, агаар мэт үгүйлэгдээд буй ёс зүйн кодоо ягштал мөрдөнө, 6) хэрэглэгчдээ олон эрэн баннераар “хүчирхийлэхгүй”, 7) бүх төрлийн бүх мэдээлэл багтаах гэж “халтуурдахгүй”, 8) хаанаас ч, хэн ч, хэзээ ч, юунаас ч хэрэглэж болохуйц тохиромжтой хэмжээгээр контент, мэдээгээ хүргэнэ, 9) Баабар нарын дараагийн үеийн нийтлэлч нарын шинэ талбар байна, 10) сайтын бүтээлүүд телевиз, цахим хэрэгслүүдээр цацагдана, контент, мэдээнүүддээ график дүрслэл ашиглаж, судалгаа, баримтад тулгуурлана хэмээн тусгажээ.

Гэвч дээр нэр дурдсан хэвлэл мэдээллийн байгууллагуудын редакцын бодлогод жендэрийн эрх тэгш байдал, жендэрийн мэдрэмжтэй байдал, ЖСХ-ийн талаар тусгайлан дурдаагүй, мөн ийм төрлийн дагнасан бодлогын баримт бичиг, гарын авлага, дүрэм, журам байхгүй байна.

Харин 2019 онд Хэвлэлийн хүрээлэнгээс “Жендэрийн мэдрэмж ба жендэрт суурилсан хүчирхийлэл” редакцад зориулсан удирдамжийг боловсруулсан бол 2020 онд Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс “Сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах бодлогын баримт бичиг”-ийн 4 дэх хэсэгт “Тэгш байдлыг хангах” тухай зөвлөмжийг багтаажээ. Үүнд сонгуулийн үеийн нийтлэл, ярилцлага, сурвалжлага зэрэгт жендэрийн эрх тэгш байдлыг хангах, сонгуульд нэр дэвшигчдийн тухай нийтэлж нэвтрүүлэхдээ жендэрийн мэдрэмжтэй хандах тухай зөвлөсөн байна.

ЮНЕСКО-гоос Олон улсын сэтгүүлчдийн холбоотой хамтран 2014 онд “Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт”-ийг боловсруулж, улс орнуудыг хэвлэл мэдээллийн агуулга, үйл ажиллагаан дахь жендэрийн мэдрэмжтэй байдлыг хэмжих үзүүлэлтүүдийг нэгтгэн тодорхойлсон байдаг. Уг баримт бичиг нь а) Хэвлэл мэдээллийн байгууллага дахь жендэрийн тэгш байдлыг дэмжих үйл ажиллагаа, б) Хэвлэл мэдээллийн агуулга дахь жендэрийн дүр

төрх гэсэн хоёр бүлэгтэй бөгөөд үүнийг Глоб Интернэшнл төвөөс 2014 онд монгол хэлнээ хөрвүүлжээ.

“Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт”-ийн А4-т “Хэвлэл мэдээллийн байгууллагууд хэвлэл мэдээллийн агуулга дахь жендэрийн тэгш байдалд тустай ёс зүйн код, редакцын бодлогыг хөхүүлэн дэмждэг” хэмээн тусгасан. Улмаар А4.1-Стратегийн зорилт 1: Хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүний агуулга боловсруулахад оролцогч жендэрийн ухамсартай сэтгүүлчид, бусад уран бүтээлч, техникийн ажилтнуудыг урамшуулан дэмжих бодлого боловсруулах, санаачилга гаргах замаар хэвлэл мэдээллийн практикт жендэрийн төлөвшил бүрдүүлэх хэмээн заажээ.

Монгол улс одоогоор тус шалгуур үзүүлэлтийн дагуу нэг бүрчилсэн нарийвчилсан үнэлгээг тусгайлан хийгээгүй байна. Харин 2017 онд НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Хэвлэлийн хүрээлэнгээс хэрэгжүүлсэн “Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сэтгүүлчдийн ойлголт, редакцын бодлого, сэтгүүл зүйн практик” санал асуулгыг явуулахдаа энэхүү шалгуур үзүүлэлтэд түшиглэжээ. Тус судалгааны зорилго нь сэтгүүлчдийн жендэрийн тэгш байдал, жендэрийн мэдрэмж, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт, энэ талаар баримталж буй хэвлэл мэдээллийн бодлогыг тандаж зөвлөмж боловсруулахад чиглэсэн байна. Тус судалгаанд хэвлэл мэдээллийн 50 байгууллагын 250 сэтгүүлчийг хамруулж жендэрийн тэгш байдал, жендэрийн мэдрэмж, ЖСХ-ийн талаарх ойлголтыг тандахаас гадна тухайн байгууллагад жендэр, ЖСХ-ийн талаар баримтлах дүрэм, журам, стандарт бий эсэх, мөн энэ чиглэлээр тогтмол мониторинг хийдэг эсэхийг тодруулж тоон үзүүлэлтээр дүгнэжээ.

2020 оны 12 дугаар сард энэхүү үнэлгээний зөвлөх багаас нийслэл болон орон нутагт үйл ажиллагаа явуулдаг, хэрэглэгчдийн тоо, хүртээмжээрээ тэргүүлэх байр суурь бүхий 30 редакцын ерөнхий редакторуудаас “Жендэр, ЖСХ – редакцын бодлогод хэрхэн туссан бэ?” бичил санал асуулгыг авсан.

Дээрх судалгааны үр дүнгүүдэд түшиглэн ЮНЕСКО-гийн шалгуур үзүүлэлтүүдээс хэвлэл мэдээллийн байгууллагын практик үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдал, жендэрийн мэдрэмжтэй байдал, ЖСХ-ийн талаар нийтлэл, нэвтрүүлэгтээ баримтлах бодлого, дүрэм журам бий эсэх мөн удирдах ажилтнуудын энэ талын мэдлэг ойлголт, хүлээн зөвшөөрөх байдлыг үнэлэхийг хичээлээ.

Ингэхдээ 14 шалгуур үзүүлэлтээс холбогдох дөрвөн (1, 2, 4, 5) шалгуур үзүүлэлтийг тусгайлан авч өнөөгийн нөхцөл байдлыг судалгааны тайлангууд болон санал асуулгын үр дүнд түшиглэн хэрэгжилтийг үнэлэхийг зорьсон юм. (Хүснэгт 2)

№	ЮНЕСКО-ийн шалгуур үзүүлэлт	Нөхцөл байдлын үнэлгээ /дүгнэлт
---	-----------------------------	---------------------------------

1.	<p>Хэвлэл мэдээллийн практик үйл ажиллагааны (эх сурвалж зэрэг) талаарх тусгай заалт бүхий жендэрийн бодлого хэрэгждэг.</p>	<p>2017 онд хийгдсэн “Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сэтгүүлчдийн ойлголт, редакцын бодлого, сэтгүүл зүйн практик” санал асуулгаас харахад, редакцияд “жендэрийн тэгш байдлыг нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, бичлэгт хангах, санамсаргүй алдаанаас сэргийлэхэд тус болох зорилго бүхий удирдамж, гарын авлага, санамж” тухайн байгууллагад байхгүй хэмээн 70% хариулжээ. Орон нутгийн редакцуудад огт байхгүй гэсэн бол нийслэлд үйл ажиллагаа явуулдаг редакцуудаас 68% байхгүй, 17% мэдэхгүй гэжээ.</p> <p>2020 онд энэхүү үнэлгээний хүрээнд 30 редакцын ерөнхий редакторуудаас “Жендэрийн эрх тэгш байдал, ЖСХ-ийн талаар мэдрэмжтэй бөгөөд ёс зүйтэй бичих” тухай бодлогын баримт бичиг бий юу гэсэн асуултад 25 редакц буюу 83,3% нь үгүй/байхгүй хэмээн хариулжээ.</p> <p>Үнэлгээ: Иймээс редакцуудыг энэ төрлийн бодлогын баримт бичигтэй болох, ийм төрлийн бодлогын баримт бичгүүдийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглээнд оруулах шаардлагатай.</p>
2.	<p>Хүйсийн төлөөллийн талаарх заалт бүхий (бичгээр үйлдсэн) ёс зүйн код мөрддөг</p>	<p>Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015 оны 4-р сарын 14-ний нэгдсэн хуралдаанаар Монголын сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн дүрмийг хэлэлцэн баталсан. Энэхүү хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим нь 10 бүлэг, 24 заалт бүхий сэтгүүлчдийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгох зарчмуудыг тусгасан байдаг. Үүнд хүний эрхийг хүндэтгэх, хохирогчийг хамгаалах, ялгаварлан гадуурхалт болон хэвшмэл хандлагаас ангид байх, хувийн нууц болон зовлон шаналалд хүндэтгэлтэй хандах зэрэг заалтууд багтсан. Гэвч жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн мэдрэмжтэй нийтэлж нэвтрүүлэх, хүйсийн төлөөллийн талаарх тусгайлсан заалт байхгүй.</p> <p>Энэхүү үнэлгээний хүрээнд 30 редакцияас авсан санал асуулгад зөвхөн МҮОНРТ редакция “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, ЖСХ, жендэрийн хэвшмэл ойлголтыг дэвэргэхгүй байх тухай редакцын бодлого” бий гэжээ.</p> <p>Үнэлгээ: Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд жендэрийн эрх тэгш байдал, хүйсийн төлөөллийн талаар нарийвчилсан заалт тусгагдаагүй тул үүнийг цаашид анхааралдаа авах нь зүйтэй.</p>
4	<p>Мэргэжлийн баг, тэр дундаа ерөнхий редактор жендэрийн ба олон талт бодлого, жендэрийн болон олон талт</p>	<p>2017 онд хийгдсэн “Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сэтгүүлчдийн ойлголт, редакцын бодлого, сэтгүүл зүйн практик” санал асуулгаас харахад, Жендэрийн тэгш байдал гэдэгт “эрэгтэй, эмэгтэй хүмүүс бүх зүйлд ижил тэгш байх” хэмээн 42%, “нийгмийн бүхий л харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижил тэгш оролцох боломжоор хангагдах” хэмээн 14% хариулжээ.</p>

	<p>мэдрэмжтэй ёс зүйн код, гарын авлага, хөгчийн талаар ойлголттой бөгөөд тэдгээрийг хүлээн зөвшөөрдөг.</p>	<p>Судалгаанд оролцогсдын 35% нь уг асуултад хариулахаас татгалзсан нь энэ талаар ойлголт мэдлэггүй байна гэж болно. Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 19%, удирдах ажилтнуудын 32% нь жендэрийн тэгш байдал нь нийгмийн бүхий л харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүс ажил тэгш оролцох боломжтой байх явдал хэмээн үзжээ.</p> <p>2020 онд энэхүү үнэлгээний хүрээнд 30 редактораас “жендэр, ЖСХ-ийн талаар таны болон танай редакцынхны ойлголт мэдлэг хэр хангалттай байна вэ? гэсэн асуултад 3 редактор маш сайн, хангалттай мэдээлэлтэй гэсэн бол 14 редактор хангалттай боловч сайжруулах шаардлагатай, 10 редактор дундаж мэдээлэлтэй, 4 редактор хангалттай бөгөөд мэдлэг байхгүй хэмээн хариулжээ.</p> <p>Үнэлгээ: Редакторуудын түвшинд жендэр ба жендэрийн олон талт бодлогыг таниулан сурталчлах, жендэрийн мэдрэмжтэй ёс зүйн код, гарын авлагын хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглээг улам идэвхжүүлэх шаардлагатай байна.</p>
5	<p>Удирдах ажилтнууд, тэр дундаа удирдах зөвлөл, ахлах менежерүүд жендэрийн ба олон талт бодлого, жендэрийн болон олон талт мэдрэмжтэй ёс зүйн код, гарын авлага, хөгчийн талаар ойлголттой бөгөөд тэдгээрийг хүлээн зөвшөөрдөг.</p>	<p>“Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сэтгүүлчдийн ойлголт, редакцын бодлого, сэтгүүл зүйн практик” санал асуулгаас харахад, судалгаанд оролцогчдын 44% нь хэвлэл мэдээллээр цацаж буй мэдээллийн агуулга жендэрийн мэдрэмжгүй хэмээн дүгнэсэн бөгөөд удирдах ажилтнууд сэтгүүлчдээс илүүтэй “хэвлэл мэдээллийн агуулга жендэрийн мэдрэмжтэй” гэх хариултыг давамгайлж өгсөн байна. Түүнчлэн судалгааны оролцогчдын 73% нь ЖСХ-ийн тухай зөв ойлголттой байжээ. Улмаар танай байгууллагад нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, бодлогод жендэрийн тэгш байдлыг хангах, үг, өнгө аясаар санаатай болон санамсаргүйгээр хүйсээр ялгаварлахгүй байх бодлого, хэм хэмжээ, дүрэм, стандарт бий юу? гэсэн асуултад хоёр оролцогч тутмын нэг (53%) нь тийм гэжээ. Ингэхдээ тэд бидэнд өдөр тутмын үйл ажиллагаандаа баримталдаг ямар нэгэн хэм хэмжээ бий хэдий ч жендэрийн тэгш байдлыг хангаж ажиллах удирдамж, гарын авлага байдаггүй хэмээн олонх нь хариулжээ.</p> <p>2020 онд энэхүү үнэлгээний хүрээнд 30 редакторууд өдөр тутмын үйл ажиллагаандаа Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг мөрдөж ажилладаг бөгөөд жендэр, ЖСХ-ийн талаар нийтлэх, нэвтрүүлэхдээ хувийн нууцад хүндэтгэлтэй хандах (26 редактор), эх сурвалжийн эрх тэгш оролцоог хангах (15 редактор), хохирогчийг хамгаалахад (14 редактор) анхаардаг хэмээн хариулжээ.</p> <p>Үнэлгээ: Хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлгийн агуулгыг жендэрийн мэдрэмжтэй байдлыг сайжруулах онцгой шаардлагатай бөгөөд үүнд чиглэсэн редакцын бодлогыг</p>



		<p>боловсруулж, ХМБ-уудад санал болгох, хэрэглээнд нэвтрүүлэхэд нь мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Судалгаануудаас харахад редакцууд нийтлэл, нэвтрүүлгийн бодлогодоо жендэрийн эрх тэгш байдал, жендэрийн мэдрэмжтэй байдлыг нэвтрүүлэхээс илүүтэй ЖСХ-ийн талаар нийтлэл нэвтрүүлэг бэлдэхэд анхаарч энэ талын мэдлэг ойлголт нь илүүтэй хөгжсөн байна.</p>
--	--	---

### Хэсгийн дүгнэлт:

- Хэвлэл мэдээллийн байгууллагуудаас өдөр тутмын сонинуудын 86 хувь, өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн 60 хувь редакцын бодлого, ёс зүйн дүрэмтэй гэсэн бол мэдээллийн цахим сайтуудын 12% нь ийм төрлийн бодлогын баримт бичгээ сайтдаа байршуулжээ. Харин эдгээр хэвлэл мэдээллийн байгууллагуудад жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг дэмжих, ЖСХ-ийн талаар нийтэлж нэвтрүүлэхдээ баримтлах тусгайлсан редакцын бодлого байхгүй байна.

- Монголын хэвлэл мэдээллийн байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагаандаа Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг баримталдаг. ХМЗ-өөс 2015 онд баталсан ёс зүйн зарчим нь 10 бүлэг, 24 заалттай бөгөөд сэтгүүл зүйн мэргэжлийн стандартыг мөрдөх, хүний эрхийг хамгаалах, хувийн нууцад хүндэтгэлтэй хандах, ялгаварлан гадуурхалт, хэвшмэл хандлагыг дэвэргэхгүй байх зэргийг зохицуулжээ. Гэвч тус зарчимд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрт суурилсан хүчирхийллийн талаар тусгайлсан заалт байхгүй.

- Хэвлэлийн хүрээлэн, Глоб Интернэшнл төв, Хэвлэл мэдээллийн зөвлөл, Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв зэрэг мэргэжлийн байгууллагуудаас хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлтүүд, жендэр, жендэрт суурилсан хүчирхийлэл, цахим сайтууд болон нийгмийн хэвлэл мэдээлэл дэх үзэн ядах үг хэллэг, цахим орчинд редакцын баримтлах бодлого зэрэг сэдвийн хүрээнд гарын авлага, удирдамж, судалгааны тайлангуудыг эрхлэн гаргажээ. Эдгээр нь жендэр, жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлаар редакцын бодлогыг хөгжүүлэх, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийг чадавхжуулахад суурь мэдээлэл, удирдамж болохуйц ач холбогдолтой болжээ.

- Жендэр, ЖСХ-ийн тухай хэвлэл мэдээллийн байгууллагууд хэрхэн нийтэлж, нэвтрүүлж буй талаарх агуулгын судалгааны тайлангууд, үнэлгээний хүрээнд сэтгүүлчидтэй хийсэн ярилцлагаас харахад хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчид жендэр, ЖСХ-ийн асуудлыг хөндөж буй нь сайшаалтай ч редакцын нийтлэл, нэвтрүүлгийн бодлогодоо жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг хөгжүүлэх талаар бодлого, үйл ажиллагаа дутмаг байна. Мөн жендэр, ЖСХ-ийг редакцын бодлогод

нэвтрүүлэхэд удирдах түвшний ажилтан (редактор, албаны дарга, захирал)-уудын хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, дэмжих шаардлагатай аж.

## 2.2. Сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн байгууллагын жендэр, ЖСХ-ийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх чадавх, бэлэн байдлын үнэлгээ

Хэвлэл мэдээллийн байгууллагын жендэрийн мэдрэмжийг дээшлүүлэх, хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлгээр дамжуулан жендэрийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх, ЖСХ-тэй тэмцэхэд мэргэжлийн редакцуудын үүрэг, оролцоо улам бүр нэмэгдэж байна.

Тиймээс 1) мэргэжлийн хэвлэл мэдээллийн байгууллагууд жендэр, ЖСХ-ийн талаар баримтлах бодлоготой эсэх, 2) жендэрийн мэдрэмжтэй редакцын бодлогыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл болон бэлэн байдал, 3) жендэр, ЖСХ-ийн чиглэлээр сэтгүүлчдийн мэргэшсэн байдал зэргийг харгалзан үзэх нь зүйтэй.

Эн тэргүүнд, ЮНЕСКО-гийн жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн 14 шалгуур үзүүлэлтээс холбогдох хоёр (6, 7) шалгуур үзүүлэлтийг тусгайлан авч судалгааны тайлан, санал асуулга, бүлгийн ярилцлагын үр дүнд түшиглэн хэрэгжилтийг үнэлэхийг зорьлоо. (Хүснэгт 3)

№	ЮНЕСКО-ийн шалгуур үзүүлэлт	Нөхцөл байдлын үнэлгээ /дүгнэлт
6	Жендэрийн бодлого, жендэрийн мэдрэмжтэй ёс зүйн код, гарын авлага, хөтөч зэрэг холбогдох нөөцийг мэргэжлийн баг, хамт олонд таниулан сурталчилж, хэвлэл мэдээллийн практикт жендэрийн төлөвшлийг бүрдүүлэх зорилгоор сургалт, семинар зохион байгуулж, дэмжлэг үзүүлдэг.	<p>Монгол Улсын хэмжээнд 2020 оны эхний байдлаар 4749 хүн хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буйгаас 2086 (44%) сэтгүүл зүйн бүтээлч ажилтан буюу сэтгүүлч, сурвалжлагч, редактор, найруулагч байдаг.<sup>7</sup></p> <p>Хэвлэлийн хүрээлэнгээс НҮБ-ийн Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр “Жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг хөндөх нь” 9 модуль бүхий сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Мөн 2017 онд сэтгүүлчдэд зориулсан “Жендэрт суурилсан хүчирхийллийг хэрхэн сурвалжлах арга зүйн сургалт”- зохион байгуулжээ.</p> <p>Сургалтын модулийн агуулгад ЖСХ-ийн тухай 5 багц сэдвийг багтаасан бөгөөд Модуль 5. Жендэрт суурилсан хүчирхийллийн тухай үндсэн ойлголт, Модуль 6. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэж буй байдал, Модуль 7. Жендэрт суурилсан хүчирхийллийн сэдвийг бичих зарчмууд, Модуль 8. Хохирогчтой ярилцлага хийх ур чадвар, Модуль 9. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүрэг гэсэн сэдвүүд байна.</p> <p>2018 онд Хүйсийн эрх тэгш төв, Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв хамтран “Хохирогч төвтэй мэдээлэх” нь эрэн сурвалжлах арга зүй, ёс зүйн чиглэлээр сургалтын гарын авлага бэлтгэн 20 эмэгтэй сэтгүүлч, 20</p>

<sup>7</sup> “Монголын хэвлэл мэдээлэл-Өнөөдөр” 2020 оны тайлан, Хэвлэлийн хүрээлэн

		<p>эмэгтэй өмгөөлөгчийн багт сургалт, нөлөөллийн ажил хийсэн. Уг гарын авлагын 2 дугаар бүлэгт: сэтгүүлчдийн гаргадаг нийтлэг алдаа, эрэн сурвалжлах бүтээлийг мэдээлэх ёс зүй, “хохилогч төв”-тэй мэдээлэх арга зүй, хохирогчтой ярилцлага хийх ур чадвар зэргийг багтаажээ.</p> <p>2019 онд НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Хэвлэлийн хүрээлэнгээс “Жендэрийн мэдрэмж ба жендэрт суурилсан хүчирхийлэл” редакцуудад зориулсан практик зөвлөмж, удирдамжийг боловсруулжээ. Үүний 1-р бүлэгт: Жендэрийн мэдрэмжтэй нийтлэл, нэвтрүүлгийн бодлогын удирдамж, 2-р бүлэгт: ЖСХ-ийн талаар нийтэлж, нэвтрүүлэхэд баримтлах зарчим багтсан байна.</p> <p>2020 онд Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс редакцын бодлогын баримт бичгүүдийг цувралаар гаргаж эхэлсэн бөгөөд 1/ Цахим орчинд редакцуудын баримтлах бодлого, 2/ Сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах тухай бодлогын баримт бичгүүд бөгөөд эдгээрийг эмхэтгэн тус бүр 500 хувь хэвлүүлэн, хэвлэл мэдээллийн байгууллага бүрт хүргүүлжээ. Ингэснээр редактор болон сэтгүүлч сурвалжлагчдад гарын дор баримтлах ёс зүйн дүрмүүдийг нарийвчлан хүргэж байна.</p> <p>Үнэлгээ: Одоогоор Хэвлэлийн хүрээлэн, Хэвлэл мэдээллийн зөвлөл, Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төвөөс энэ чиглэлийн гарын авлага боловсруулах, сургалт хийх ажлуудыг хийж байгаа хэдий ч 2086 сэтгүүл зүйн бүтээлч ажилтны хэчнээн хувьд нь жендэр, ЖСХ-ийн сургалтад хамруулсан тухай нээлттэй мэдээлэл байхгүй. Цаашид сургалтын цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, агуулгыг улам баяжуулах хэрэгцээ шаардлага хэвээр байна.</p>
7.	<p>Жендэрийн бодлого, жендэрийн мэдрэмжтэй ёс зүйн код, гарын авлага, хөтөч, сургалт семинар зэрэг арга хэмжээний үр нөлөөг үнэлэх, үр дүнг үнэлэх зорилгоор хэвлэл мэдээллийн агуулгад үе шаттай, тогтмол дотоод хяналт шинжилгээ хийдэг</p>	<p>2017 оны судалгаагаар нийт редакцуудын 18% нь сэтгүүлчдийнхээ бэлтгэсэн нийтлэл, нэвтрүүлгийг жендэрийн тэгш байдлын өнцгөөс тогтмол хянаж, мониторинг хийдэг гэсэн байна. Эдгээр нь УБ хотод үйл ажиллагаа явуулдаг 1 радио, 3 телевиз, 2 мэдээллийн сайт, 2 сонин багтаж байна. Ихэвчлэн удирдах ажилтнууд тийм гэсэн хариултыг өгчээ.</p> <p>Үнэлгээ: Редакцууд дотооддоо болон хэвлэл мэдээллийн мэргэжлийн байгууллагуудаас жендэрийн бодлого, жендэрийн мэдрэмжтэй ёс зүйн кодын талаар мониторинг хийдэг туршлага байхгүй тул үүнийг нэвтрүүлж хэрэгжүүлэх шаардлагатай.</p>

--	--	--


Энэхүү үнэлгээний хүрээнд зөвлөх багийнхан жендэр, ЖСХ-ийн чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай, сэтгүүлчидтэй хамтран ажилладаг, тэдний гол эх сурвалж болдог хүний эрх, хүчирхийлэл, хүүхэд хамгаалал, хохирогчийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудтай бүлгийн ярилцлагыг 2020 оны 12 дугаар сарын 19-22-нд зохион байгуулсан.

Бүлгийн ярилцлагын зорилго нь тэдгээр байгууллагуудын жендэр, ЖСХ-ийн агуулгыг нийгэмд хүргэх, нөлөөлөх чиглэлээр хэвлэл мэдээлэлтэй харилцаж ирсэн сайн туршлага, саад бэрхшээлийг тодруулахад чиглэсэн юм. Уг ярилцлагад “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв”, “Хүйсийн эрх тэгш төв”, “Хөөрхөн зүрх” болон “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” ТББ-уудын төлөөлөл оролцлоо.

Бүлгийн ярилцлагад оролцсон иргэний нийгмийн төлөөллүүд хэвлэл мэдээлэл болон сэтгүүлчидтэй хамтын ажиллагаагаа сайжруулах талаар дараах саналыг дэвшүүллээ. Үүнд:

- Иргэний нийгмийн байгууллага бүр хэвлэл мэдээлэл, сэтгүүлчидтэй хамтран ажиллах өөрийн гэсэн арга барил, туршлагатай ажээ. Улмаар тэд сэтгүүлчдийг жендэр, ЖСХ-ийн чиглэлээр мэргэшүүлж хөгжүүлэхэд цаашид ч хамтран ажиллахад бэлэн гэдгээ илэрхийлэв.
- Жендэр, ЖСХ-ийн тухай мэдлэг, мэдээллийг сэтгүүлчдэд өгөхдөө хэнийг ч орхигдуулахгүй байх нь чухал. Хэвлэл мэдээллийн салбартаа манлайлан ажилладаг, редакцын ёс зүйн дүрэмтэй хэвлэл мэдээллийн байгууллагууд нь нийтлэл, нэвтрүүлэгтээ жендэрийн мэдрэмжтэй байхыг эрмэлзэж, ЖСХ-ийн тухай сурвалжлахдаа ёс зүйн дүрмээ чанд мөрдөж ажилладаг. Иймээс тэд мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргах нь ховор. Харин шинэ тутам хөгжиж байгаа, туршлага бага редакцуудын сэтгүүлчдийг жендэрийн мэдрэмжтэй байдалд сургах, тэднийг мэргэшүүлэхэд онцгой анхаарч, бодлогын гадуур орхигдуулахгүй байх нь чухал гэв.
- Сэтгүүлчдийг жендэр, ЖСХ-ийн чиглэлээр мэргэшүүлж сургах нь цаг ямагт ач холбогдолтой хэвээр байна. Цаашид зөвхөн сэтгүүлчдийг биш редакцын бодлого, үйл ажиллагааг тодорхойлдог, шийдвэр гаргадаг ерөнхий редактор, албаны дарга нарт жендэрийн эрх тэгш байдал, ЖСХ-ийн тухай ойлголт өгч, хамтын ажиллагааг шинэ шатанд хөгжүүлэх, өргөжүүлэх шаардлагатай.
- Ярилцлага хийсэн байгууллагуудаас Хүчирхийллийн эсрэг үндэсний төв хэвлэл мэдээлэлтэй харилцах бодлоготой бол бусад гурван байгууллагад ийм төрлийн бичгэн бодлого, баримт бичиг байхгүй аж. Иймээс жендэрийн эрх тэгш байдлыг хангах, ЖСХ-ийн асуудлыг нийгмийн анхааралд зөв зохистой хүргэхэд хэвлэл мэдээлэлтэй үр дүнтэй харилцах стратеги төлөвлөгөө хэрэгтэй байдаг тухай онцолж байв.

Түүнчлэн 2020 оны 12 дугаар сарын 15-25-нд үнэлгээний зөвлөх багийнхан сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлдэг хэвлэл мэдээллийн байгууллагуудаас 30 редакцыг түүвэрлэн авч ерөнхий редакторуудаас бичил санал асуулга авсан. Үүний хүрээнд “Танай редакцад жендэр, ЖСХ-ийн асуудлаар мэргэшсэн сэтгүүлч бий юу? гэсэн асуултад 8 редакц “байгаа” гэж хариулсан бол 20 редакц “байхгүй”, тиймээс сэтгүүлчдээ мэргэшүүлэх шаардлагатай гэж үзжээ.



“Сэтгүүлчдээ хамгийн сүүлд хэзээ жендэр, ЖСХ-ийн мэргэшүүлэх сургалтад хамруулсан бэ?” гэсэн асуултад 16 редакц огт хамруулаагүй гэсэн бол 4 редакц сүүлийн улиралд хамруулсан гэжээ. Тиймээс сэтгүүлчдийг жендэр, ЖСХ-ийг чиглэлээр мэргэшүүлэх хэрэгцээ шаардлага өндөр хэвээр байна.



Редакторууд хэлэхдээ “сэтгүүлчид санаатай гэхээсээ илүү санамсаргүйгээр алдаа гаргах нь түгээмэл учраас жендэр, ЖСХ-ийн тухай ойлголт, мэдлэг өгөх сургалтууд шаардлагатай. Мөн хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 3-т “Хэвлэл мэдээллийнхэн нийгэмд оршиж байгаа хэвшмэл

ойлголтуудыг улам дэвэргэхээс зайлсхийнэ” хэмээн заасан байдаг. Энэ мэтчилэн ёс зүйн зарчмын тайлбарыг илүү тодорхой болгох хэрэгтэй байна. Учир нь ёс зүйн зарчим нь тэднийг алдаа гаргахаас сэргийлж чаддаг хамгаалалт юм” гэдгийг онцолж байв.

Улмаар сэтгүүлчдийг жендэр, ЖСХ-ийн чиглэлээр мэргэшүүлэх богино хугацааны сургалтууд хэрэгтэй, сургалтыг онол, дадлага хосолсон байдлаар явуулбал илүү үр дүнтэй, энэ чиглэлийн тогтмол сургалтууд байдаг бол редакцууд сэтгүүлчдээ хамруулж үе шаттайгаар мэргэшүүлэхэд бэлэн, сэтгүүлчид хүний эрхийн талаар мэдлэг, хандлагаа сайжруулах шаардлагатай, ЖСХ далд хэлбэрээр явагддаг тул эх сурвалжийг хамгаалах нь онцгой ач холбогдолтой тул сэтгүүлч болон хохирогчийг хамгаалах эрх зүйн орчин таатай байх, улмаар сэтгүүлч өөрийгөө хамгаалах мэдлэгтэй байх хэрэгтэй, ялангуяа орон нутгийн сэтгүүлчдэд онцгой мэдлэг мэдрэмж шаардлагатай, хүчирхийллийн асуудлыг хөндөхдөө мэргэжлийн болон сэтгэл зүйн ур чадваруудаа хөгжүүлэх нь зүйтэй, нийгэмд буй хэвшмэл ойлголтуудыг засаж залруулахад хэвлэл мэдээллийн үүрэг онцгой чухал гэсэн санаануудыг ерөнхий редакторууд нэмж хэлжээ.

2018 онд Хүйсийн тэгш эрхийн төвийн дэмжлэгтэйгээр Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв “Хохирогч төвтэй мэдээлэл: ажлын байрны бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийн эрэн сурвалжлах нь” сэтгүүлчид болон редакторуудад зориулсан гарын авлагыг боловсруулжээ.

Уг гарын авлагын 2 дугаар бүлэгт: сэтгүүлчдийн гаргадаг нийтлэг алдаа, эрэн сурвалжлах бүтээлийг мэдээлэх ёс зүй, “хохирогч төв”-тэй арга зүйн зарчмууд, эрэн сурвалжлах сэтгүүл зүй ба хамтын ажиллагаа, хохирогчтой ярилцлага хийх ур чадвар зэргийг агуулжээ. Мөн гарын авлагад Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг хавсаргасан байна.

Энэхүү гарын авлагад түшиглэн 2018 онд Хүйсийн эрх тэгш төв, Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв хамтран “Хохирогч төвтэй мэдээлэх” нь сургалтыг 20 эмэгтэй сэтгүүлч, 20 эмэгтэй өмгөөлөгчийн багт хийсэн аж. Энэ талаараа Хүйсийн эрх тэгш төвийн тэргүүн Г.Ганбаясах “Хүн худалдаалах гэмт хэргийн тухай сэтгүүлчдэд ойлголт өгөх зорилгоор гурван жилийн хугацаатайгаар нийт 38 сэтгүүлчтэй баг үүсгэж хамтарсан нь хэвлэл мэдээлэлтэй ажилласан анхны туршлага байлаа. Улмаар 20&20 буюу 20 эмэгтэй сэтгүүлч, 20 эмэгтэй өмгөөлөгчтэй хамтарсан цуврал сургалтуудыг хийсэн. Сургалтын үр дүнд сэтгүүлчид хэвлэл мэдээллийн хэрэгслээр жендэрийн мэдрэмжтэй, чанартай бүтээлүүд гаргаж чадсан. Энэ нь Азийн шилдэг хамтын ажиллагааны загвараар шалгарч байсан түүхтэй” хэмээн бүлгийн ярилцлагын үеэр онцлов.

Тухайн үед хамтарч байсан сэтгүүлчид өнөөдрийг хүртэл бусдаасаа илүү жендэрийн мэдрэмжтэйгээр ажиллаж байдаг нь бидний хамтын ажиллагааны гол үр дүн. Мөн хохирогчийг буруутгах хандлагыг бууруулах зорилгоор ХЗДХЯ-тай хамтран сэтгүүлчдэд эрх зүйн сургалтууд хийж байсан. Үүний дараагаас хэвлэл мэдээллээр хохирогчийг буруутгасан бүтээлийн тоо багассан хэмээн Г.Ганбаясах нэмж хэлсэн.

“Хөөрхөн зүрх” ТББ-ын ерөнхий зохицуулагч Б.Оюундарь “Хэвлэл мэдээллийн байгууллага нь хүний эрхийн мэдрэмжтэй, жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг системтэй цогц байдлаар ойлгодог, хохирогчийг буруутгадаггүй байх нь маш чухал бөгөөд ойлголт, мэдлэгээ нэгтгэх уулзалт, хэлэлцүүлгүүд чухал байдаг. Манай байгууллага хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг хүний эрхийн зөрчил гэж үздэг тул энэ чиглэлээр мэргэшсэн сэтгүүлчдийг бий болгохыг зорьж байгаа” хэмээн ярьсан. Тэрээр хэвлэл мэдээллийн байгууллага нь хүүхэд хамгааллын бодлоготой, мөн жендэрийн мэдрэмж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлоготой байвал хамтарч ажиллахад илүү тус дөхөмтэй байх болно. Улмаар энэхүү бодлого нь тухайн редакцын ялгарал, нэр хүнд, итгэл үнэмшилтэй байдалд илүү тустай байх болно гэдгийг онцолж байв.

2019 онд НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Хэвлэлийн хүрээлэнгээс “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр жендэрт суурилсан хүчирхийллийг хэрхэн хөндөж байна вэ?” агуулгын судалгаа хийжээ. Уг агуулгын судалгааны тайлангийн зорилго нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр жендэрт суурилсан хүчирхийллийн тухай мэдээллийг хэрхэн нийтэлж, нэвтрүүлж буйг тодруулж, сэтгүүлчдэд зориулсан удирдамж боловсруулахад чиглэсэн байна. Ингэхдээ хэвлэмэл сонин, өргөн нэвтрүүлгийн телевиз, радио, цахим мэдээллийн сайтаас тус бүр хоёрыг сонгож, нийт найман төрлийн хэвлэл мэдээллийг хэрэгслийг судалгаанд хамруулсан байна.

Уг судалгааны дүгнэлтээр хэвлэл мэдээллийн редакцууд “ЖСХ-ийн олон янз хэлбэрээс нүдэнд ил буюу бэлгийн хүчирхийлэл болон бие махбодийн хүчирхийллийн тухай мэдээг илүү хөндөж, харин сэтгэл санааны, эдийн засгийн хүчирхийллийн сэдвийг үндсэндээ орхигдуулж байна” гэжээ. Улмаар сэтгүүлчид хохирогчийн шууд болон шууд бусаар буруутгах хандлагатай бөгөөд нийтлэл, нэвтрүүлэгтээ “хохирогчийн дүр” бүтээхэд голлон анхаарч байна. Ингэснээр тухайн хохирогчийг нийгмийн эрх тэгш нэгэн гишүүн, өөрийн гэсэн хувийн орон зай, дүр төрхтэй хүн гэдгийг харуулсан бүтээлүүд үгүйлэгдэж буйг анхааруулжээ. Мөн хүчирхийлэл үйлдэгчийн тухай бичихдээ нийгэмд тогтсон хэвшмэл ойлголтууд болох гэмт хэрэгтэн этгээд, танхай балмад этгээд гэх зэргээр тодорхойлж, зарим тохиолдолд нэр, албан тушаалаар нь шууд нэрлэж зааж байв. Иймээс сэтгүүлчид ЖСХ-ийн талаар зөв талаас нь мэдээлж, нийгмийн энэхүү асуудалтай холбоотой хуучирсан хэвшмэл ойлголт, хандлагыг засаж залруулахад хэвлэл мэдээлэл чухал үүрэгтэйг онцолсон байна.

Дээр дурдсан агуулгын судалгаанд тулгуурлан Хэвлэлийн хүрээлэнгээс 2019 онд “Жендэрийн мэдрэмж ба жендэрт суурилсан хүчирхийлэл” редакцуудад зориулсан практик зөвлөмжийг боловсруулжээ. Уг практик зөвлөмжид жендэрийн тухай нэр томъёоны тайлбаруудыг оруулж өгсний зэрэгцээ 1) Жендэрийн мэдрэмжтэй нийтлэл, нэвтрүүлгийн бодлогын удирдамж; 2) Жендэрт суурилсан хүчирхийллийн талаар нийтэлж, нэвтрүүлэхэд баримтлах зарчим гэсэн хоёр бүлэгт асуудлыг багцлан боловсруулсан байна.

Эндээс редакторууд нийтлэл нэвтрүүлгийнхээ бодлогын цар хүрээ, чанарыг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг удирдамжаа болгохоос гадна сэтгүүлчид жендэрийн мэдрэмжтэй бичих



зарчим ба аргуудаас суралцахад тус болохуйц болжээ. Энэхүү удирдамжаас редактор болон сэтгүүлчид нэгж мэдээ, нийтлэл бэлтгэхдээ гарчиг, эх сурвалж, хэл найруулга, дүрс зэрэгт жендэрийн мэдрэмжтэй хандсан эсэхээ тодорхой шалгуур үзүүлэлтээр нягтлах боломжтой аж. Түүнчлэн ЖСХ-ийн талаарх түгээмэл буруу ойлголтыг залруулж, ЖСХ-ийн асуудлыг мэдээлж, сурвалжлахдаа баримтлах зарчмуудыг тусгасан байна.

Үнэлгээний хүрээнд жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйгээр мэргэшиж, ЖСХ-ийн асуудлаар 3-аас 6 жилийн турш тогтвортой, тууштай нийтэлж, нэвтрүүлж буй өдөр тутмын сонин, орон нутгийн хэвлэл мэдээлэл, мэдээллийн сайтын сэтгүүлчдээс тус бүр нэг мөн чөлөөт сэтгүүлчтэй ганцаарчилсан ярилцлагыг 12 дугаар сарын сүүлийн долоо хоногт хийлээ. Жендэр, ЖСХ-ийн чиглэлээр мэргэшиж буй сэтгүүлчид хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлэгт жендэрийн мэдрэмжтэй байдлыг нэмэгдүүлэх, ЖСХ-ийг ёс зүйтэй бичихэд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал:

- ✓ Мэргэшсэн сэтгүүлчид өөрийн хүсэл зорилгоор ЖСХ-ийн асуудлыг сурвалжилдаг бөгөөд хүний эрхийн мэдрэмжтэй ажиллаж, хохирогчийг буруутгахгүй байхад онцгой анхаарах шаардлагатай.
- ✓ Байгууллагын эрхлэгч, ерөнхий редактор, албаны дарга нар хүний эрхийн мэдрэмжтэй, мэдлэгтэй байх нь маш чухал.
- ✓ Зарим хэвлэл мэдээллийн байгууллага нь өндөр хандалт авах зорилгоор хэт дуулиан шуугиан хөөдөг, жендэрийн болоод ёс зүйн мэдрэмжгүй байдалд шүүмжлэлтэй ханддаг.
- ✓ Редакцууд хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг баримталж ажилладаг хэдий ч жендэр, ЖСХ-ийн асуудлыг хэрхэн бичих тухай бодлогын бичиг баримт, удирдамж байхгүй байна. Энэ чиглэлээр бичдэг сэтгүүлчдийн хувьд сургалтаас олж авсан мэдлэг, туршлагадаа тулгуурлан ЖСХ-ийн асуудлыг бичдэг бөгөөд гарын дор байх гарын авлага, удирдамж үгүйлэгддэг.
- ✓ Олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын судалгаа, тайлан, цагдаагийн байгууллагын тоо баримт, хүний эрхийн мэргэжилтнүүд сэтгүүлчдийн хувьд гол эх сурвалж болдог. Гэвч аливаа судалгаа, тайланд маш их мэдээлэл бий ч тэр бүр эргэлтэд орж, олон нийтэд хүрдэггүй. Хэвлэл мэдээлэлтэй хамтран ажиллаж, мэдээллийг олон нийтэд хүргэх хэрэгтэй.
- ✓ Жендэр, ЖСХ-ийн чиглэлээр бичдэг сэтгүүлчдийн бүтээлийг урамшуулдаг, тэдний үйл ажиллагааг дэмждэг байх нь чухал байна. Тухайлбал, бүтээлийн уралдаан, тэтгэлгийг сэтгүүлчдийн дунд идэвхжүүлэх нь нийгмийн эмзэг асуудлыг хөндөж, нөлөөлөл үзүүлэхийн төлөө ажиллаж буй тэдэнд бодит дэмжлэг болно.
- ✓ Жендэр, ЖСХ-ийн чиглэлээр мэргэшиж буй сэтгүүлчдэд тогтмол уулзах, санал солилцох, туршлагаа хуваалцах орчин, платформ үгүйлэгддэг бөгөөд тэднийг тогтмол сэдэлжүүлж, идэвхжүүлж байх нь алсдаа нийгэмд үр нөлөөгөө илүү өгнө. Үүний нэг хэлбэр нь сайн дурын клубийн бүтэц зохион байгуулалт байж болно.

### **Хэсгийн дүгнэлт:**

- Монгол Улсын хэмжээнд 2086 сэтгүүл зүйн бүтээлч ажилтан буюу сэтгүүлч, сурвалжлагч, редактор, найруулагч тогтвортой ажиллаж буй боловч тэдгээрийн хэчнээн хувь нь жендэр, ЖСХ-ийн чиглэлээрх сургалтад хамрагдсан тоо байхгүй.

- Өнгөрсөн хугацаанд Хэвлэлийн хүрээлэн, Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төвөөс жендэр, ЖСХ-ийн сэдвээр сэтгүүлчдэд зориулсан сургалтууд хийсэн боловч эдгээр нь тогтмол давтамжтай биш байна. Тухайлбал, ХХ-ээс 2017, 2019 онд сэтгүүлчдэд зориулсан жендэрийн сургалтууд хийсэн бол ЭССТТ-өөс 2018 онд нэг удаа хийжээ.
- Судалгаа, мониторингийн дүнгээс харахад редакцуудад жендэрийн эрх тэгш байдал, сэтгүүл зүйн бүтээлийн жендэрийн мэдрэмжтэй байдлыг тогтмол хэмжих шалгуур үзүүлэлт, дотоод хяналт мониторинг хийх чадавх, нөөц, туршлага байхгүй байна.
- Редакторууд болон сурвалжлагчдын түвшинд жендэр, ЖСХ-ийн чиглэлээр редакцын бодлогоо бэхжүүлэх, энэ чиглэлээр суралцах, чадавхжих улмаар хүний эрхийн мэдрэмжтэй, ёс зүйтэйгээр нийтэлж нэвтрүүлэх хүсэл сонирхол, эрмэлзэл байна. Харин энэ чиглэлээр мэргэшсэн сэтгүүлчид ховор бөгөөд энэ чиглэлээр бичиж буй сэтгүүлчид редакцын бодлогын дагуу гэхээс илүүтэй өөрсдийн хүсэл сонирхол, эрмэлзлээр ажиллаж байна.
- Цаашид жендэр, ЖСХ-ийн чиглэлээр сэтгүүлчдийг мэргэшүүлэхдээ редаксаас бодлогын түвшинд дэмжих, эдийн засгийн хувьд хөшүүрэг хэрэгтэй байгаа нь ажиглагдлаа. Ялангуяа орон нутагт мэргэшсэн сэтгүүлч байхгүй байгаа нь энэ чиглэлээр бичихэд ихээхэн саад бэрхшээл тулгардаг болохыг онцгойлон анхаарах шаардлагатай аж.
- Редакторуудын хувьд жендэр, ЖСХ-ийн чиглэлээр сэтгүүлчдээ мэргэшүүлэх, давтан сургах, энэ чиглэлээр баримтлах бодлоготой болохыг дэмжиж байна. Түүнчлэн ёс зүйн тайлбар, гарын авлагууд, нэр томъёо, хууль эрх зүйн тайлбар, мэдлэг мэдээлэл сэтгүүлчдийг мэргэшүүлэхэд шаардлагатай гэж тэд үзэж байна.
- ЖСХ-ийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд сэтгүүлчидтэй хамтран ажиллах хүсэл эрмэлзэлтэй бөгөөд цаашид мэргэшсэн сэтгүүлчидтэй ажиллахаас гадна жендэрийн мэдрэмж, соёл сул хэсэгт хүрч ажиллахыг чухалчилж байна.

### **2.3. Хэвлэл мэдээллийн байгууллагын жендэр, ЖСХ-ийн талаарх бодлогын хэрэгжилтийн хяналт, хариуцлага: хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт**

Дижитал эрин үед сэтгүүл зүйн үйл ажиллагаа улам нарийсаж, мэдээлэл хайх, олж авах, нягтлан шалгах, боловсруулах, түгээх, хуваалцах талбар, суваг өргөжин тэлэхийн сацуу сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд хэрэглэгчдийнхээ өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа улам чамбайруулах шаардлага тулгарч байна.

Олон улсын хэмжээнд албан ёсны өөрийн зохицуулалтын байгууллага болох Хэвлэлийн зөвлөл (*Press Council*), Хэвлэл мэдээллийн зөвлөл (*Media Council*)-ийг улс төрийн түвшиндээ хүлээн зөвшөөрч, эрх зүйн хүрээнд ч баталгаажуулсан туршлагууд бий. Сайн дурын үүсгэл санаачилга

бүхий хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага нь сэтгүүл зүйн мэргэжлийн ба ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэх, хараат бус, шударга байдлыг хангах үүрэг хүлээдэг. Үүний тулд тухайн улс орондоо нийтээр дагаж мөрдөх Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг батлан мөрдөж, иргэдийн санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг жишиг туршлагууд нэгэнт бий болж хөгжжээ.

1920-оод оноос дэлхийн томоохон хэвлэл мэдээллийн байгууллагууд ёс зүйн дүрэмтэй болж үүнийгээ уншигч, сонсогч, үзэгчдээ ил тод байршуулж эхэлсэн нь хэвлэл мэдээллийн ёс зүйн хариуцлагыг сахиулдаг Хэвлэл мэдээллийн зөвлөлүүд хөгжих суурь болжээ. Одоогоор дэлхийн 100 гаруй улс оронд хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага болох Хэвлэлийн зөвлөл, Хэвлэл мэдээллийн зөвлөлүүд үйл ажиллагаагаа явуулж байна. 1916 онд Шведэд анхны хэвлэлийн консул байгуулагдсан<sup>8</sup> бол 1960-аад оноос Баруун хойд Европт (Их Британид 1954, Германд 1956, Нидерландад 1960, Данид 1964, Финляндад 1968, Швейцарт 1973 онд), түүнчлэн АНУ (1970), Канад (1972), Австрали (1976) зэрэг улс орнуудад хэвлэлийн зөвлөлүүд ээлж дараалан байгуулагджээ.

1990-ээд онд Зөвлөлт Холбоот Улс задарснаар Зүүн Европ, Балканы хойгийн посткоммунист орнууд хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг хийж эхэлсэн бол Азид хожуу буюу 2000 оноос ижил зорилготой консулууд байгуулагдаж эхэлсэн. Азийн анхны хэвлэлийн зөвлөлд Энэтхэг, Шри Ланка, Тайланд, Пакистаны өөрийн зохицуулалтын байгууллагууд багтаж байгаа бөгөөд Монгол Улс 2015 онд хэвлэл мэдээллийн зөвлөлийг албан ёсоор байгуулсан түүхтэй.<sup>9</sup>

Ингэснээр Монгол улсад хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад ёс зүйн зөрчил байна гэж үзсэн иргэд гомдлоо гаргах, шүүмжээ илэрхийлэх талбар бий болж, хариуцлага хяналтын тогтолцоо бүрэлдэн төлөвшиж байна хэмээн дүгнэж болно.

Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөл нь сэтгүүлч, ажил олгогч, хэвлэл мэдээллийн салбарын эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын санаачилга, амжилттай хамтын ажиллагааны үр дүнд байгуулагдсан хэвлэмэл, цахим, радио, телевизийн хараат бус өөрийн зохицуулалтын байгууллага юм.<sup>10</sup>

ЮНЕСКО-гоос боловсруулсан “Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлтийн А4.1- Стратегийн зорилт 1-т хэвлэл мэдээллийн ёс зүйн хариуцлага тооцдог дотоод механизм бий эсэх, жендэр, ЖСХ-тэй холбоотой сэтгүүл зүйн агуулгын талаар уншигч, сонсогч, үзэгчид гомдол гаргах, санал шүүмжээ илэрхийлэх боломжтой, үүнийг нь олон нийт мэддэг эсэх талаарх шалгуур үзүүлэлтийг оруулсан байдаг.

---

<sup>8</sup><https://medieombudsmannen.se/about-the-media-ombudsman/how-self-regulation-works/>

<sup>9</sup> Олон нийтийн хэвлэл мэдээллийн улс төрөөс хараат бус байдлыг хангах нь: хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын жишээн дээр, бодлогын судалгааны тайлан, Г.Гүнжидмаа, 2020 он, УБ

<sup>10</sup> Хэвлэл мэдээллийн зөвлөлийн таницлуулга <https://www.mediacouncil.mn/p/4>

ЮНЕСКО-гийн жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн 14 шалгуур үзүүлэлтээс холбогдох гурван (8, 9, 11) шалгуур үзүүлэлтийг тусгайлан авч хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын туршлага, тоон статистик мэдээлэлд түшиглэн хэрэгжилтийг үнэлэхийг зорилоо. (Хүснэгт 4)

№	ЮНЕСКО-ийн шалгуур үзүүлэлт	Нөхцөл байдлын үнэлгээ /дүгнэлт
8	Омбудсмен, уншигчийн булан хөтлөгч, хэвлэлийн консул зэрэг хэлбэрээр агуулга дахь жендэрийн тэгш байдлын асуудлаар санал шүүмжлэл хэлэлцэх боломжийг олон нийтэд олгох дотоод механизмтай бөгөөд үүний талаар олон нийтэд мэдээлдэг	<p>Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага болох Хэвлэл мэдээллийн зөвлөл НҮТББ нь сайн дурын санаачилгаар хэвлэл мэдээллийн эзэд/эрхлэн гаргагчид болон сэтгүүлчдийн тэгш оролцоон дор 2015 оны эхээр байгуулагдсан. Тус зөвлөл нь иргэний үнэнийг мэдэх эрхийг хангах, иргэний нэр төр, алдар хүндийг хамгаалах нөгөө талаар сэтгүүлчдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх замаар цагдаа, шүүхийн байгууллагаар шалгагдах, торгууль шийтгэл оногдуулахаас урьдчилан сэргийлэх зорилготой.</p> <p>Тус зөвлөл нь 2015-2020 оны зургаан жилийн хугацаанд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас сэтгүүл зүйн ёс зүйн зарчмыг зөрчсөн гэж үзсэн нийт 383 гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн. Үүний 125 (32.6%) нь жендэрийн эрх тэгш байдал, жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийлэл, хүний эрхийн зөрчил, хохирогчийг хамгаалаагүй зэрэгтэй холбоотой байна. ХМЗ-ийн үйл ажиллагаа болон өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй байдаг.</p> <p>Үнэлгээ: Иргэний санал гомдол, шүүмжлэлийг хүлээн авч хэлэлцэн шийдвэрлэдэг хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын сайн дурын хараат бус тогтолцоог улам бэхжүүлэн хөгжүүлэх шаардлагатай. Өнөөг хүртэл бүрдүүлсэн туршлагыг баяжуулан бэхжүүлж, үр ашгийг дээшлүүлэх бүрэн боломжтой.</p>
9	Жендэрийн бодлогыг ил тодорхой болгож, олон нийтэд жендэрт чиглэсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаарх санал хүсэлт, ойлголтод	2017 онд ХХ-гээс 50 хэвлэл мэдээллийн байгууллагын 250 сэтгүүлчийг хамруулсан судалгаа хийхэд хоёр сэтгүүлч тутмын нэг нь өөрийн ажиллаж буй байгууллага нь жендэрийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалтын талаар ямар нэгэн санал, шүүмжлэлийг үзэгч, уншигч, сонсогчдоос хүлээн авдаг гэсэн бөгөөд

	<p>үзүүлсэн хариу үйлдлийн талаар тогтмол мэдээлдэг</p>	<p>ихэвчлэн фэйсбүүкээр дамжуулан авдаг хэмээн хариулжээ.</p> <p>ХМЗ нь иргэдийн сэтгүүл зүйн бүтээл нь ёс зүйн зарчим зөрчсөн гэж үзсэн иргэн, аж ахуйн нэгжийн гомдлыг биечлэн болон дараах холбоосоор цахимаар хүлээн авдаг. Холбоос: <a href="https://www.mediacouncil.mn/signin">https://www.mediacouncil.mn/signin</a></p>
11	<p>Хараат бус байгууллага нь хэвлэл мэдээллийн агуулгын талаар олон нийтийн санал хүсэлт илэрхийлэх, шүүмжлэл өрнүүлэх талбар бүхий хөндлөнгийн механизм хэмээн тооцогддог бөгөөд олон нийтэд уг механизмын талаар таниулан сурталчилдаг</p>	<p>Сэтгүүл зүйн ёс зүйн зарчмыг зөрчсөн гэсэн аливаа бүтээлд гомдол гаргах эрх нь иргэн бүрт нээлттэй бөгөөд энэхүү механизмыг хэрэгжүүлдэг Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг редакцууд болон олон нийтэд таниулан сурталчлах ажлыг ХМЗ-өөс идэвхтэй хийдэг.</p> <p>ХМЗ-ийн үйл ажиллагааны тайлангууд сайтад нь нээлттэй байршдаг. Холбоос: <a href="https://www.mediacouncil.mn/p/5">https://www.mediacouncil.mn/p/5</a></p> <p>Үнэлгээ: одоо бий болсон туршлагыг бэхжүүлэх, олон нийтэд таниулах ажлыг идэвхжүүлэх нь зүйтэй.</p>

Жендэр, ЖСХ-ийн талаар хэвлэл мэдээллийнхэн нийтэлж, нэвтрүүлэхдээ Ёс зүйн зарчмын 2, 3, 4, 6, 7 дахь кодуудыг зөрчихгүй байхад онцгой анхаарч ажиллах шаардлагатай болдог. Ингэснээр сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага “хувийн нууцад хүндэтгэлтэй хандах”, “хохирогчийг хамгаалах”, “бусдыг ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй байх”, “хүүхдийн эрхийг зөрчихгүй байх” зэрэг зөрчлийг гаргахгүй байхад тустай. Хэрэв иргэнээс эдгээр болон бусад ёс зүйн заалтыг редакц нийтлэл, нэвтрүүлэгтээ зөрчсөн хэмээн Хэвлэл мэдээллийн зөвлөлд гомдол гаргавал тус зөвлөл шүүхээс өмнөх шатанд бие даан шийдвэрлэх боломжтой юм.

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Гомдол хүлээн авах, барагдуулах журмын 1.2-т зааснаар Зөвлөл нь зөвхөн хэвлэмэл болон онлайн хэвлэл, радио, телевизийн сэтгүүлчийн бэлтгэж түгээсэн аливаа сэтгүүл зүйн бүтээл болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн албан ёсны сошиал хуудсаар түгээгдсэн сэтгүүл зүйн бүтээлтэй холбоотой гомдлыг хүлээн авч хэлэлцэнэ.<sup>11</sup>

Харин 2019 онд Хэвлэл мэдээллийн зөвлөл нийт 106 өргөдөл гомдлыг хүлээн авч 75 гомдлыг ёс зүйн хороогоор хэлэлцсэнээс 36 (48%) редакцыг ёс зүйн зөрчил гаргасан, 2020 онд 50 өргөдөл гомдол хүлээн авснаас 20 гомдлыг ёс зүйн хороо хэлэлцэж, тэдгээрээс 8 (40%) редакцыг ёс зүйн зөрчил гаргасан хэмээн олон нийтэд мэдэгджээ.

<sup>11</sup> ХМЗ-ийн Гомдол хүлээн авах, барагдуулах журам <https://www.mediacouncil.mn/p/12>

ХМЗ сүүлийн зургаан жилийн хугацаанд буюу 2015-2020 онд нийт 383 гомдол хүлээн авсан байна. Үүнээс 125 өргөдөл гомдол буюу нийт гомдлын 32,6 хувь нь ялгаварлан гадуурхалт, хэвшмэл хандлагыг дэвэргэсэн, хохирогчийг хамгаалаагүй, хувийн нууцад хүндэтгэлтэй хандаагүй, хүүхдийн эрхийг хэвлэл мэдээлэлд зөрчсөн зэрэг ёс зүйн алдаа гаргасан хэмээн иргэдийн үзсэн гомдлууд байв.

Тухайлбал:

- 2015 онд ЛГБТөөс ХМЗ-д 2 удаа гомдол гаргахдаа нэр бүхий хэвлэл мэдээллийн хэрэгслээр ижил хүйстэн, биеэ үнэлэгч зэргээр ЛГБТ хүмүүсийг доромжилсон үг хэллэг ашиглаж ташаа мэдээлэл түгээсэн гэжээ. Ёс зүйн хороо эдгээр гомдлыг хэлэлцээд редакцыг Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 1.1, 3.2, 4 дэх заалтуудыг зөрчсөн хэмээн дүгнэсэн.
- 2017 онд нэр бүхий хоёр иргэнээс ХМЗ-д нэр бүхий 20 цахим сайтад хаягласан гомдлыг ирүүлсэн. Гомдлын агуулга нь хүний нэр төрд халдсан, хувийн нууцыг задалсан, жендэрийн мэдрэмжгүй нийтлэл гаргасан гэжээ. Ингээд ёс зүйн хороо редакцуудыг ёс зүйн зарчмын 1.1, 1.2, 1.3, 4.2, 6.2 дахь заалтуудыг зөрчсөн хэмээн шийдсэн.
- 2017 онд нэр бүхий хоёр цахим сайтад нэгэн дасгалжуулагчийг эмэгтэй тамирчиндаа бэлгийн дарамт үзүүлдэг тухай нийтлэл гарсан бөгөөд нэр дурдагдсан эрэгтэй үүнийг үндэслэлгүй хэмээн ХМЗ-д гомдол гаргасан. Тэрээр эдгээр сайтууд ор үндэсгүй худал мэдээлэл түгээж намайг гутаан доромжилж, сэтгэл санааны хүнд дарамтад оруулж, нэр хүндэд нь халдлаа хэмээгээд ёс зүйн зарчмын 1.8 буюу буруутгагдаж буй этгээдээс тайлбар авна гэсэн ёс зүйн заалтыг зөрчсөн хэмээн үзжээ. Ёс зүйн хороо редакц нь хэн нэгнийг ноцтой зүйлд буруутгаж, нэр төрд нь халдаж байгаа нөхцөлд заавал тухайн хүнээс тайлбарыг сонсох учиртай хэмээн үзээд ёс зүйн зарчмын 1.8-ийг зөрчсөн гэж үзжээ.
- 2018 онд нэгэн гадаад эмэгтэйгээс ХМЗ-д гомдол гаргасан бөгөөд тэрээр Монголын нэгэн цахим мэдээллийн сайтыг жендэрийн мэдрэмжгүй байдлаар нийтлэл гаргахдаа ёс зүйн зарчмын 1, 2.4 -ийг зөрчсөн гэж үзсэн бөгөөд хороо түүний гомдлыг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн.
- 2018 онд нэгэн иргэнээс ХМЗ-д 51 цахим сайтын эсрэг гомдол гаргасан.
- 2019 онд нэр бүхий төрийн албан хаагчаас 10 цахим сайтад хаягласан гомдлыг ХМЗ-д ирүүлсэн байна. Гомдол гаргагч эдгээр сайтыг хохирогчийн тухай мэдээлж нийтлэхдээ ЖСХ-тэй холбосон бөгөөд ингэхдээ ёс зүйн зарчмын 6.2, 6.5, 6.8 дахь заалтуудыг зөрчсөн гэж үзсэн. Гэвч редакцууд гомдлын дагуу ХМЗ-д хариу тайлбар өгөхдөө хохирогч хүүхдийн тухай мэдээлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргаснаа хүлээн зөвшөөрч, гомдол гаргагч болон олон нийтээс уучлал гуйсан.
- 2020 онд нэгэн эмэгтэйгээс нэр бүхий 13 цахим сайтад хаягласан гомдлыг ХМЗ-д ирүүлсэн бөгөөд агуулга нь тус эмэгтэйг “гэр бүл үймүүлэгч” хэмээн нэрлээд хувийн архиваас нь “нүцгэн” зургийг нь авч сайтууд захиалгаар тавьж олон нийтэд дэлгэсэнд гомдолтой байгаагаа илэрхийлсэн. Гэвч ХМЗ-ийн ГХАБЖ-ийн 2.1-т заасны дагуу 90 хоногоос өмнөх нийтлэл байсан тул журмын дагуу хороо хэлэлцээгүй.

• 2020 онд нэгэн холбооноос холбооноос эрэн сурвалжлах сэтгүүлчдийн багийн бэлтгэж түгээсэн охидод бэлгийн дарамт үзүүлж буй талаар буруутгасан нэвтрүүлэг хийсэн. Гомдол гаргагч энэ явдлыг үгүйсгэж, редакцыг байгууллагын болон хувь хүний нэр хүндэд үндэслэлгүйгээр халдлаа хэмээн үзэж ХМЗ болон шүүхэд гомдол гаргасан. ХМЗ-ийн ёс зүйн хороо гомдлыг хэлэлцээд үндэслэлтэй гэж үзсэн бөгөөд редакцыг ёс зүйн зарчим зөрчөөгүй гэсэн дүгнэлтийг гаргажээ.

Дээр дурдсан ХМЗ-ийн ёс зүйн хороогоор хэлэлцэн шийдвэрлэсэн иргэдийн гомдол гаргасан бүтээлүүдийг “Жендэрт суурилсан хүчирхийллийн талаар нийтэлж, нэвтрүүлэхэд баримтлах зарчим”-ын дагуу үнэлж үзэхэд дараах мэргэжлийн алдааг сэтгүүлчид гаргасан нь ажиглагдаж байна. Тодруулбал:

- Хохирогчийн дүр төрхийг тодорхойлж, үнэлж дүгнэсэн үг хэллэг ашигласан
- Бэлгийн чиг баримжаагаар нь ялгаварлан гадуурхаж, гутаан доромжилсон
- Хохирогч болон түүний ойр орчмын хүмүүсийг эрсдэлд оруулах, түүний нөхцөл байдлыг дордуулах нарийвчилсан мэдээллийг дэлгэсэн
- ЖСХ-ийн хохирогчийг хамгаалах үйлчилгээ, тусламж үзүүлдэг байгууллагын аюулгүй байдлыг хангаагүй, эрсдэлд оруулах мэдээлэл нийтэлсэн
- Хувийн нууцад хүндэтгэлтэй хандаагүй, хувь хүний зураг, хувийн мэдээллийг нийтэд ямар ч шүүлтүүргүй ил тод зарласан

Тус зөвлөлийн хүлээн авч, хэлэлцэн шийдвэрлэсэн жендэрийн эрх тэгш байдал, жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сэдэвтэй хамаарах хоёр тохиолдлыг дэлгэрэнгүйгээр орууллаа.

ХМЗ-ийн Ёс зүйн хороодын дүгнэлтээс дараах хоёр шийдвэрийг онцлон энд орууллаа.<sup>12</sup>

Тохиолдол I. Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс “хохирогчид хүндэтгэлтэй хандах” зөрчил гаргасан эсэх асуудлыг шийдвэрлэсэн нь

*Монгол улс даяар өдөр тутмын есөн сонин, 127 телевиз, 48 радио, 71 сэтгүүл, 100 гаруй цахим сайт мэдээлэл түгээж байна. Сэтгүүлчид чиглэл чиглэлээрээ өдөр тутам хэдэн зуун мэдээ бэлтгэн түгээдэг. Харин энэ хэдэн зуун мэдээнээс хүмүүсийн хамгийн сонирхон уншдаг мэдээний нэг нь гэмт хэрэг болон ямар нэг хохирогчтой мэдээ байдаг. Гэвч сэтгүүлчид энэ чиглэлийн мэдээг бэлтгэхэд онцгой анхаарах ёс зүйн зарчмууд бий. Монголын сэтгүүлчдийн Ёс зүйн зарчмын 6 буюу “Хувийн нууцад хүндэтгэлтэй хандана”, 7 буюу “Бусдын уй гашуу, зовлон шаналалд хүндэтгэлтэй хандана” гэж заасан байдаг.*

<sup>12</sup> “Сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн эрх зүйн зохицуулалт ба ёс зүй” мониторинг, ХМЗ, 2020 он

*Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Сонин, сэтгүүл, сайтын Ёс зүйн хорооны 2019 оны хоёрдугаар улирлын ээлжит хурлаар эдгээр заалтад хамаарах гомдлуудыг хэлэлцлээ. Хурал 2019 оны зургадугаар сарын 13-ны өдөр болсон юм.*

*Сонин, сэтгүүл, сайтын Ёс зүйн хороо ээлжит хурлаараа нийт 10 гомдлыг авч хэлэлцсэний долоо нь нэг үйл явдалтай холбоотой байлаа. Тодруулбал, 2019 оны дөрөвдүгээр сард Сэлэнгэ аймагт алга болсон охины тухай мэдээлэл юм. Алга болсон охины талаарх мэдээллийг нэр бүхий долоо сайт нийтлэхдээ хохирогчийн нэр, нас, гэрэл зураг, амьдардаг хаашааны зургуудыг нийтэлсэн нь Ёс зүйн зарчмын Зургадугаар буюу “Хувийн нууцад хүндэтгэлтэй хандана” гэсэн заалтын 6.2-т заасан “Зөвхөн олон нийтийн тусын тулд хүний нэр, зураг болон бусад хувийн мэдээллийг нийтэд ил болгоно”, 6.5-д заасан “Гэмт хэрэг, ослын хохирогчид нэр, нас, албан тушаал болон бусад хувийн мэдээллээ хамгаалуулах эрхтэй”, 6.8-д заасан “Тухайн мэдээлэлтэй шууд холбоотой биш л бол гэмт хэргийн сэжигтэн, золиос, хүчирхийлэл, осол гамшигт өртөгсдийн гэр бүл, ойр дотны хүмүүсийн овог нэр, ажил, албан тушаал, гэрэл зураг, дүрсийг тэдний зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхгүй” гэснийг тус тус зөрчсөн гэсэн гомдол ирсэн юм.*

*Долоон сайтын мэдээний мэдээлэл, гарчиг өөр өөр байсан ч хохирогчийн нэр, насыг дурдаж, гэрэл зургийг танигдахаар нийтэлсэн түгээмэл алдааг сайтууд гаргасан байсан.*

*Хэвлэл мэдээллийн зөвлөл Гомдол барагдуулах журмын дагуу гомдол ирсэн сайт бүрийн редакц руу тайлбар хүссэн албан бичгийг явуулсан бөгөөд долоон сайтаас тав нь хариу тайлбарыг ирүүлж, гаргасан алдаагаа залруулж, уучлал хүсч буйгаа илэрхийлсэн. Харин хоёр сайт редакцын тайлбарыг ирүүлээгүй нь 24tsag.mn, boov.mn сайт юм.*

*Гомдол барагдуулах журмын дагуу алдаагаа залруулаагүй тохиолдолд редакцын нэрийг нийтэд илээр зарладаг юм.*

*Хохирогчид хүндэтгэлтэй хандаагүй энэ гомдол нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагуудад сургамж болохоор тохиолдол байлаа.*

*Эх сурвалж: <https://www.mediacouncil.mn/a/118>*



Тохиолдол 2. Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс “хохирогчийг хамгаалах” зөрчил гаргасан эсэхийг шийдвэрлэсэн нь

2018 оны тавдугаар сарын 17-ны өдөр “Эко” телевизээр нэвтэрсэн “Хаалттай хаалганы цаана” нэвтрүүлэгт “Талита Ази” ТББ гомдол гаргасан. “Талита Ази” нь тухайн нэвтрүүлгээр хөндсөн асуудлын гол эх сурвалж юм. Энэ нэвтрүүлгээр “Талита Ази” байгууллагын Монголд хийж байгаа үйл ажиллагаа нь хууль бус байж болох юм гэсэн санааг батлахыг оролдож, охид, эмэгтэйчүүдийг хамгаалж байгаа эсэхийг эрэн сурвалжлахыг “Эко” телевизийн редакц зорьжээ.

“Талита Ази” ТББ нь 2013 оноос Шведийн вант улс дахь “Талита” олон улсын байгууллагын Ази дахь төлөөлөл болон тэдний тусламж дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотод ажиллаж байгаа бөгөөд бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэг болон биеэ үнэлэх явдлын хохирогч болсон эмэгтэйчүүд, охидод удаан хугацааны сэтгэл зүйн болон нийгмийн үйлчилгээг үзүүлдэг. “Эко” телевиз нь “Хаалттай хаалганы цаана” нэвтрүүлгээрээ үнэнд нийцээгүй, нийтдээ мушгин гуйвуулсан, мэргэжлийн давуу байдлаа урвуулан ашигласан, хувийн нууцад хүндэтгэлгүй хандсан шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар ялгаварлан гадуурхсан, бусдын уй гишуу, зовлон шаналалд хүндэтгэлтэй хандаагүй гэсэн гомдлыг ирүүлсэн юм.

Ес зүйн хороо гомдлыг хэлэлцээд “Эко” телевиз нь Ес зүйн зарчмын 1, 2, 3, 4.4, 6 дугаар заалтуудыг зөрчсөн гэж үзлээ.

Тухайлбал, хоорондоо хамааралгүй хоёр байгууллагын үйл ажиллагааг үндэслэлгүйгээр хамаатуулан, үнэнд үл нийцсэн мэдээлэл олон нийтэд хүргэсэн, “Талита Ази” ямар нэг алан хядагч байгууллагатай холбоотой гэдгийг нэвтрүүлгийн аль ч хэсэгт нотлон харуулж чадаагүй, ингэснээрээ олон нийтийг төөрөгдүүлж, гомдол гаргагчид ноцтой хохирол учруулах нөхцөлийг бүрдүүлсэн, “Талита Ази”-ийн төлөөлөгчдийг телевизийн редакцид ирэхэд зургийг нууцаар авсан, мөн нууц камер, аудио бичлэгээр зарим байгууллагын ажилтнуудын дүрс, дууг авч нэвтрүүлэгт ашигласан, ингэж нууцаар олж авсан мэдээлэл нь тухайн үйл явдлыг ойлгоход онцгой чухал мэдээлэл болохыг тайлбарлаж чадаагүй, энэ мэдээллийг редакц өөр аргаар олох ямар ч боломжгүй байсан, тиймээс нууцаар олж авсан гэдгээ хэвлэлийн зөвлөлд нотолж чадаагүй, “Талита Ази”-ийг алан хядах байгууллагатай холбосноороо ялгаварлан гадуурхсан үр дагаврыг бий болгосон, “Талита Ази” байгууллагын хохирогчдыг хамгаалдаг байр хаана байрлаж байгааг мэдэх боломжтой мэдээллүүдийг олон нийтэд өгсөн, ингэснээрээ тэнд байрлаж байгаа хамгаалуулах ёстой хүмүүст аюул учруулсан гэсэн дүгнэлтийг гаргалаа.

“Эко” телевизийн зүгээс нэвтрүүлэгт хөндсөн сэдвийг эрэн сурвалжлахдаа эх сурвалжийн бүрэн бүтэн байдал, хууль эрх зүйн зохих тайлбар зэргийг мэргэжлийн ёс зүйн хүрээнд бүрэн дүүрэн шингээсэн учраас Ёс зүйн зарчмыг зөрчөөгүй гэсэн тайлбар ирүүлсэн юм.

**Тайлбар:**

-“Эко” телевизийн “Хаалттай хаалганы цаана” нэвтрүүлэг эрэн сурвалжлах сэтгүүл зүйн арга барилаар хийгдсэн сайшаалтай. Гэсэн ч аливаа зүйлд ялгаварлалгүй тэгш хандах, асуудлыг дэвэргэх, буруутай гэж нотлохыг улайрсан зэрэг алдаа гаргасан гэдгийг хорооны гишүүд гомдлыг хэлэлцэх үеэр хэлсэн. Хүний наймаа, бэлгийн

*хүчирхийлэл, алан хядах үйл ажиллагаатай холбоотой гаднын байгууллага Монголд орж ирсэн байх гэсэн сэжүүрээр сэтгүүлчид эрэн сурвалжлага хийсэн ч уг сэжүүрээ нэвтрүүлгээрээ нотолж чадаагүй учраас “Эко” телевиз нь Ёс зүйн зарчмыг зөрчсөн гэсэн дүгнэлтийг гаргасан юм.*

Эх сурвалж: <https://www.mediacouncil.mn/a/84>

### **Хэсгийн дүгнэлт:**

- Монгол улсад хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад ёс зүйн зөрчил байна гэж үзсэн иргэд гомдлоо гаргах, шүүмжээ илэрхийлэх талбар бий болж, хариуцлага хяналтын тогтолцоо бүрэлдэн төлөвшиж буйг хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага болох Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үүсэл хөгжил, үйл ажиллагаанаас харж болно.

- Хэвлэл мэдээллийн зөвлөл нь сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлгийн агуулга нь хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг зөрчсөн хэмээн үзсэн иргэн, аж ахуйн нэгжийн гомдлыг хүлээн авдаг. 2019 оноос редакцын албан ёсны нийгмийн хэвлэл мэдээлэл (фэйсбүүк, твиттер, юүтүб гм) -ээр түгээгдсэн мэдээлэлд мөн гомдол авдаг болжээ.

- Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим нь 10 бүлэг 24 заалттай бөгөөд үүний нэлээд хэсэг нь сэтгүүл зүйн бүтээлд хүний эрхийг дээдлэх, хохирогчийг хамгаалах, хүүхдийн эрхийг зөрчихгүй байх, бусдыг ялгаварлан гадуурхахгүй, гутаан доромжлохгүй байх, хувийн нууцыг хүндэтгэх зэрэг заалтуудыг тусгасан нь сэтгүүл зүйн хэвлэл мэдээлэлд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн мэдрэмжтэй байдлыг бий болгох суурь зарчмууд болж байна.

- Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд жендэрийн эрх тэгш байдал, жендэрийн мэдрэмжтэй байдлыг хангах нарийвчилсан заалтууд байхгүй байгаа нь гомдол гаргагчид жендэрийн талаар мэдрэмжтэй нийтлэхийг ёс зүйн зөрчилд тооцож гомдол гаргах, шүүмжээ илэрхийлэх иргэдийн оролцоо, хяналтыг дэмжихгүй байна.

- 2017 онд ХХ-гийн судалгаанд хамрагдсан 250 сэтгүүлчийн тал нь жендэрийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалтын талаар санал шүүмжийг ихэвчлэн фэйсбүүкээр дамжуулан хэрэглэгчдээсээ хүлээн авдаг гэжээ.

- ХМЗ өнгөрсөн зургаан жилд нийт 383 гомдол хүлээж авсаны 32,6 хувь нь ялгаварлан гадуурхалт, хэвшмэл хандлагыг дэвэргэсэн, хохирогчийг хамгаалаагүй, хувийн нууцад хүндэтгэлтэй хандаагүй, хүүхдийн эрхийг хэвлэл мэдээлэлд зөрчсөн ёс зүйн алдаа хэмээн иргэд үзэж гомдлоо гаргасан байв.

- ХМЗ-ийн ёс зүйн хорооны шийдвэрүүдээс харахад, сэтгүүл зүйн бүтээлд хохирогчийн дүр төрхийг тодорхойлж, үнэлж дүгнэсэн үг хэллэг ашигласан, бэлгийн чиг баримжаагаар нь ялгаварлан гадуурхаж, гутаан доромжилсон, хохирогч болон түүний ойр орчмын хүмүүсийг эрсдэлд оруулах, түүний нөхцөл байдлыг дордуулах нарийвчилсан мэдээллийг дэлгэсэн, ЖСХ-ийн хохирогчийн хувийн нууцад хүндэтгэлтэй хандаагүй зэрэг зөрчлүүд нийтлэг байна.

## Гурав. НИЙГМИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ (SOCIAL MEDIA)-ЭЭР ЖЕНДЭР, ЖСХ-ИЙН ТАЛААР МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ ГАРГАХ БОДЛОГЫН ҮНЭЛГЭЭ

### Нийгмийн мэдээллийн хэрэгсэл – тоон хэлээр

Интернетийн хэрэглээ өсөхийн хэрээр, нийгмийн мэдээллийн хэрэгслийн хэрэглэгчдийн тоо тогтмол өссөөр байна. Монгол улсын хүн амын тоо 2020 оны байдлаар 3,3 орчим саяд хүрээд байна. Гэтэл нийгмийн хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийн тоо 2.2 саяд хүрч, Ази тивд фэйсбүүк (*Facebook*) хэрэглэгчдийн тоогоороо тэргүүлэгч орнуудын нэг болсон байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн мэдээллийн хэрэгсэл ашиглагчдын дийлэнх олонх буюу 2,1 сая (95%) нь фэйсбүүк хэрэглэгч бөгөөд үүний 52 % нь эмэгтэйчүүд байна.<sup>13</sup> Үүнээс 25-34 насны хэрэглэгчид хамгийн олон буюу 770 мянга байна. Үүний дараагаар 18-24 болон 35-44 насныхан багтжээ.<sup>14</sup>

Монголчуудын мэдээлэл хүлээн авдаг гол эх сурвалжуудын нэгдүгээрт телевиз 85%-ийн хэрэглээтэйгээр орсон бол удаах байрт нийгмийн мэдээллийн хэрэгсэл (*Social Media*) 68%-ийн хэрэглээтэйгээр жагсжээ. Нийгмийн мэдээллийн хэрэгслийн хэрэглэгчдийг газар зүйн байршлаар авч үзвэл, орон нутгийн оршин суугчдын 74%, нийслэлд оршин суугчдын 64% нь фэйсбүүк, твиттер, ютүб, инстаграм зэрэг нийгмийн мэдээллийн хэрэгслээр дамжуулж мэдээ мэдээлэл авдаг гэжээ.<sup>15</sup>

Түүнчлэн дижитал эрин үед сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь албан ёсны нийгмийн мэдээллийн хэрэгслийн аккаунтуудыг хөгжүүлж буй нь фэйсбүүк, ютүб, твиттерийн албан ёсны хаягуудыг нээж мэдээ мэдээллээ илүү олон хэрэглэгчдэд хүргэхэд түгээмэл ашиглаж байна. Ялангуяа телевизүүдийн мэдээллийн хөтөлбөр, зарим контент нь фэйсбүүк хуудсанд нь тогтмол байршиж байна. Нийгэмд болж өрнөж буй үйл явдал, засгийн газрын хуралдаан зэргийг мэдээллийн сайтууд фэйсбүүк хуудсаараа шууд дамжуулан үзүүлж хэвшлээ. Улмаар нийгмийн мэдээллийн хэрэгслээр дамжин хүрдэг цахим ТВ-үүд ч бий болж байна. Жишээ нь: Зариг ТВ, Лайв ТВ гэх мэт.

Сэтгүүл зүйн үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс хамгийн олон хэрэглэгчтэй фэйсбүүк хуудсуудыг (*Facebook page*) нэрлэвэл, Монгол ТВ, Боловсрол суваг телевиз, ТВ5 телевиз, ТВ9 телевиз, ikon.mn, gogo.mn, zarig.mn, NTV телевиз багтжээ.<sup>16</sup>

Интернетэд суурилсан мэдээлэл харилцааны хэрэгсэл болох нийгмийн мэдээллийн сүлжээ нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэл түгээх гол хэлбэрийн нэг болсон бөгөөд 2017 оны эхний

<sup>13</sup> <https://datareportal.com/reports/digital-2020-mongolia>

<sup>14</sup> <https://napoleoncat.com/stats/facebook-users-in-mongolia/2019/09>


<sup>15</sup> Хэвлэл мэдээллийн хэрэгслээр жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг хэрхэн хөндөж байна вэ? судалгааны тайлан, НҮБХАС, ХХ, 2019 он

<sup>16</sup> <https://www.socialbakers.com/statistics/facebook/pages/total/mongolia/media/page-1-2>

байдлаар уламжлалт мэдээллийн хэрэгслүүдийн 47 хувь нь өөрийн гэсэн веб сайт, 64 хувь нь Фэйсбүүкээр дамжуулан өөрсдийн мэдээллийг цахим орчинд түгээж байна.<sup>17</sup>

Сүүлийн жилүүдэд монголын залуучуудын дунд нийгмийн мэдээллийн хэрэгслийн нэг төрөл болох инстаграм (Instagram)-ын хэрэглээ эрс өсчээ. Монголчуудаас 640 мянган хэрэглэгч инстаграмд бүртгэлтэй байгаагаас 18-24 насны хэрэглэгч хамгийн олон буюу 270 мянган залуучууд бүртгэлтэй бол удаах байранд 25-34 насныхан 207 мянган хэрэглэгчийн тоогоороо жагсжээ.<sup>18</sup> Эдгээр инстаграм хэрэглэгчдийн 60% нь мөн эмэгтэйчүүд байна.

2020 оны байдлаар Монголчуудаас инстаграмын тэргүүлэх нөлөөлөгч (influencer)-дийг урлаг, соёлын залуу зүтгэлтнүүд тэргүүлж буйгаас комедиан Б.Идэр-Одын @idercomedian хуудас 395,500 дагагчтайгаар нэгдүгээрт жагсжээ.<sup>19</sup> Тэрээр Ideree's podcast ярилцлагын нэвтрүүлгийг бэлтгэж өөрийн юүтүб (YouTube) сувгаар олон нийтэд хүргэдэг юм. Түүний дараа ШҮҮДЭРХЭН @Shuuderheen 363.7К, Ч.Уранхолбоо @urankholboo 363.5К, Ganchimeg Altanginj @ganchimegaltan\_ganuukhai 362.5К дагагчтайгаар тус тус жагссан байна.



Rank	Name	Handle	Country	Category	Follower Count	Engagement Rate
1	Ider-Od Bat-Erdene	@iderodcomedian	Mongolia	Modeling Fashion	393.5K	2.10%
2	ШҮҮДЭРХЭН SHUUDERHEN	@shuuderheen	Mongolia	Modeling Music	363.7K	1.00%
3	Ч.Уранхолбоо	@urankholboo	Mongolia	Moms Modeling	363.5K	0.30%
4	Ganchimeg Altanginj	@ganchimegaltan_ganuukhai	Mongolia		362.5K	0.90%
5	Dulguun Positive Mongolians	@dulguun_positiv emongolians	Mongolia		345.5K	2.60%

Монгол улсын хэмжээнд 52 мянган твиттер (Twitter) хэрэглэгч<sup>20</sup> байгаагаас топ арван жиргээчид дунд улс төрчид болон нийтлэлчид багтаж байна. Тухайлбал, Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга, Ерөнхийлөгч асан Цахиагийн Элбэгдорж, УИХ-ын дарга асан Зандаахүүгийн Энхболд нараас гадна нийтлэлч Баабар, Д.Энхбат, Д.Жаргалсайхан нарыг нэрлэж болно.<sup>21</sup>










<sup>17</sup> Хэвлэл мэдээллийн хэрэгслээр жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг хэрхэн хөндөж байна вэ? агуулгын судалгаа, ХХ, НҮБХС, 2019 он

<sup>18</sup> <https://napoleoncat.com/stats/instagram-users-in-mongolia/2020/11>

<sup>19</sup> <https://stargage.com/app/global/influencer/ranking/mongolia>

<sup>20</sup> <https://datareportal.com/reports/digital-2020-mongolia>

<sup>21</sup> <https://www.socialbakers.com/statistics/twitter/profiles/mongolia>

2	 Battulga Khaltmaa (@BattulgaKh)	11 442	310 926
3	 Asashoryu第68代横綱朝青龍MNP (@Asashoryu)	1 655	297 964
4	 Mongolia (@Mongolia976)	0	242 239
5	 Цахиагийн Элбэгдорж (@elbegdorj)	3 384	238 193
6	 Jargal Dambadarjaa (@jargal_defacto)	364	236 460
7	 Zandaakhuu Enkhbold (@enkhboldz)	474	229 622
8	 Baabar (@Baabarniitleich)	610	215 517
9	 Enkhbat Dangaasuren (@enkhbat)	849	199 289
10	 Ganhuu Ch. Hutagt (@ganhuuyag)	227	193 121

Д.Жаргалсайхан нь VTV телевизээр долоо хоног бүр De Facto ярилцлагын нэвтрүүлэг, Jargal Defacto юүтүб сувгаар нийгэм, эдийн засгийн тойм, “The Defacto Gazette” долоо хоног тутмын улс төр, эдийн засгийн онлайн сонинг англи, монгол, япон, орос хэлээр эрхлэн гаргадаг билээ.

### Нэр томъёоны тайлбарын тухайд

Нийгмийн хэвлэл мэдээлэл (Social Media) нь агуулгад төвлөрсөн, өргөн хүрээнд нэвтрүүлэх буюу өргөн хүрээний уншигч, сонсогч, үзэгчдэд мэдээлэл түгээх, дамжуулахад төвлөрдөг харилцаа холбооны суваг юм.

Нийгмийн сүлжээ (Social Network) нь харилцаа, харилцан ярианд тулгуурласан, бусдыг хооронд нь холбоход ашиглагддаг хэрэгсэл бөгөөд ашиг сонирхол нэгтэй хүмүүсийг нэгтгэж, хүй олноор (community) дамжуулан харилцаа тогтооход чиглэнэ.

Энгийнээр тайлбарлавал, нийгмийн сүлжээ нь танихгүй хүнтэй ч шууд харилцаа тогтоох боломжтой тодорхой цахим хуудсуудыг хэлж байна. Харин нийгмийн хэвлэл мэдээлэл нь дүрс бичлэг, дуу, зураг, нийтлэл гэх мэт агуулгыг нийгмийн сүлжээний хүрээнд түгээх систем юм.<sup>22</sup>

### **3.1. Нийгмийн хэвлэл мэдээлэлд редакцын жендэр, ЖСХ-ийн талаар баримтлах бодлого, ёс зүйн дүрэм**

Монголын хэвлэл мэдээллийн орчинд редакцын дотоод дүрэм журмаа боловсруулж, мөрдөж хэвших үйл явц эхлэл төдий боловч редакцууд энэ талаар хичээл зүтгэл гаргаж буй нь үнэлгээний тайлангийн эхний хэсэгт дэлгэрэнгүй туссан. Түүнчлэн сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн редакцын

<sup>22</sup> “Нийгмийн хэвлэл мэдээллийн зохицуулалт” судалгааны тайлан, ГИТ, ННХ, 2019 он

бодлогод жендэр, ЖСХ-ийн талаар тодорхой заалт тусаагүй, ийм оролдлого хараахан хийгдэж эхлээгүй байгааг мөн тэнд тэмдэглэсэн.

Энэ байдал нийгмийн хэвлэл мэдээллийн бодлогод ч нэгэн ижил бөгөөд цаашид редакцууд бодлогын баримт бичигтээ нийгмийн мэдээллийн хэрэгсэлтэй хэрхэн харьцах тухайгаа зайлшгүй тусгах хэрэгцээ шаардлагыг илтгэж байна. Энэхүү үнэлгээний хүрээнд, нийт 154 мэдээллийн сайтын редакцын бодлогод анализ хийхэд хүүхэд залуучуудад зориулсан [Yolo.mn](#), [Maamuu.mn](#) болон [ulsturch.mn](#), [ikon.mn](#) мэдээллийн сайтууд нийгмийн мэдээллийн хэрэгсэлд хэрхэн ажиллах зарчмаа редакцын бодлогодоо тусгасныг сайшаалтай.

Эдгээр дөрвөн редакцын сэтгүүлчид редакцын үйл ажиллагаандаа төдийгүй олон нийтийн сүлжээнд ажиллахдаа мэргэжлийн ёс зүйн дүрмээ мөрдлөг болгох ёстойг тус зарчимдаа сануулжээ. Өөрөөр хэлбэл, сэтгүүлчид олон нийтийн сүлжээнд ёс зүйн дүрмээ даган ажиллах нь жендэрийн тэгш байдлыг хангах ЖСХ-ийн асуудлыг хүний эрхэд суурилсан хандлагад тулгуурлан сурвалжлахад дэмжлэг болох юм.

Эндээс харахад, Монголын хэвлэл мэдээллийн байгууллагуудын олонход нийгмийн мэдээллийн хэрэгслийг хэрхэн үр ашигтай, ёс зүйтэй ашиглах, хэрэглэгчидтэйгээ харилцах болон хяналт тавих тухай зааварчилгаа, удирдамж, дүрэм, журам байхгүй байна.

Дэлхий нийтээрээ цахим орчны аюулгүй, зохистой хэрэглээний талаар иргэдээ соён гэгээрүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэдээллийг нягтлан шалгах замаар хуурамч мэдээлэлтэй тэмцэх, иргэдийн хэвлэл мэдээлэлтэй харилцах суурь боловсролыг бүх шатандаа дэмжих, сэтгүүл зүйн ба нийгмийн хэвлэл мэдээлэлд баримтлах бодлого гаргах, хэвлэл мэдээллийн болон нийгмийн мэдээллийн хэрэгслийн өөрийн зохицуулалтыг хийхийг уриалж, энэ чиглэлд олон төрлийн үйл ажиллагаануудыг идэвхтэй хэрэгжүүлсээр байна.

2012 оны 6 дугаар сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл “Хүний оффлайн орчин дахь эрхүүд, тэр дундаа үзэл бодлоо илэрхийлэх эрх онлайн орчинд нэгэн адил хангагдах учиртай” хэмээн тэмдэглэсэн. Мөн энэ талаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2013 оны 11 дүгээр сард баталгаажуулж, хүний оффлайн орчин дахь эрхүүд, тэр дундаа халдашгүй байх, нууцлалтай байх эрх онлайн орчинд ч нэгэн адил хамгаалагдах ёстой” хэмээн улс орнуудад анхааруулжээ.<sup>23</sup>

Монгол улсын хувьд ч цахим орчинд хүний эрхийг хангах, хүүхдийг бүхий л талаар хамгаалах, цахим гэмт хэрэг, худал хуурмаг мэдээлэлтэй тэмцэх, худал мэдээллийн улмаас нийгэмд эмх замбараагүй, үймээн самуун дэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой алхмуудыг авч хэрэгжүүлж байна. Гэвч цахим орчинд хүний эрх, нэр төр, алдар хүндийг хамгаалахдаа хүний суурь эрх, эрх чөлөө болох үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдахгүй

---

<sup>23</sup> “Нийгмийн хэвлэл мэдээллийн зохицуулалт” судалгаа, Глоб интернэшнл төв, ННХ, 2019

байхыг олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудаас манай улсад өгсөн зөвлөмждөө тусгасан байдаг.

Түүнчлэн оффлайн орчинд мөрдөгдөж буй эрх зүйн болон ёс зүйн зохицуулалт нь онлайнд орчинд ч нэгэн ижил мөрдөгдөх учиртай. Цахим орчин дахь хүний эрх, жендэрийн тэгш бус байдал, ЖСХ зэрэг нь технологийн асуудал биш, харин нийгмийн асуудал гэдэгтэй оролцогч талууд санал нэгдэж байна. Иймээс нийгмийн мэдээллийн хэрэгслийн компаниуд хэрэглэгчдийн дагаж мөрдөх бодлогын баримт бичгийг боловсруулж өөрийн талбартаа байршуулаад байна. Тухайлбал, фэйсбүүк хэрэглэгчдийн дагаж мөрдөх хэм хэмжээ<sup>24</sup> болон твиттер, инстаграмын хэрэглэгчдийн баримтлах удирдамж гэж бий. Эдгээр бодлогын баримт бичгүүд нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хөхүүлэн дэмжихийн зэрэгцээ аюулгүй орчинг бий болгох зорилготой бөгөөд бүхий л бүс нутаг, хэл, соёлд нийцсэн тэгш, шударга байдлыг багтаадаг.

Эдгээр бодлогын баримт бичгүүдэд нийгмийн мэдээллийн хэрэгслийн хэрэглэгчид юуны тухай, ямар мэдээлэл, контентыг нийтэлж болох, мөн болохгүйг нарийвчлан тусгасан байдгаараа онцлогтой. Тодруулбал, аливаа хэлбэрийн заналхийлэл, хүүхдийг нүцгэлэх ба хүүхдийн бэлгийн мөлжлөг, хүний наймаа, бусдын биеийг үнэлүүлэхтэй холбоотой ямар ч хэлбэрийн мэдээлэл, контентыг нийгмийн мэдээллийн хэрэгсэлд нийтлэхийг хориглож, улмаар ийм агуулга бүхий контентыг фэйсбүүк болон твиттер компаниудаас устгахаа мэдэгдсэн. Үл зөвшөөрөгдөх агуулгад үзэн ядах үг хэллэг, хүчирхийлэл, насанд хүрэгчдийн нүцгэн байдал, сексийн үйл ажиллагаа, сексийн өдөөн хатгалт, худал мэдээлэл зэргийг багтаажээ.

Фэйсбүүк компанийн аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн Саутворт “Бид платформоо эмэгтэйчүүдэд илүү аюулгүй талбар болгохын тулд цогц бодлого баримталж, эхний ээлжинд хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд туслах тодорхой бодлого, дэвшилтэт технологийг боловсруулж байна”<sup>25</sup> хэмээн олон нийтэд зориулсан мэдэгдэлдээ онцлон тэмдэглэжээ.

Цахим орчин тэр дундаа нийгмийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг зохицуулахдаа улс орнууд эрх зүйн болон өөрийн зохицуулалтыг хослуулан ашиглаж байна. Энэ талаар 2019 онд Глоб Интернэшнл төвөөс Нээлттэй нийгэм хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр “Нийгмийн хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт”<sup>26</sup> судалгааны ажлыг хийж, тайланг эмхэтгэн гаргасан нь цаг үеэ мэдэрсэн, ач холбогдол бүхий мэдээлэл, туршлага болжээ.

Уг судалгааны тайлан нь хоёр бүлэгтэй бөгөөд нэгдүгээр бүлэгт, нийгмийн мэдээллийн хэрэгслийг хууль тогтоомжоор зохицуулж буй байдал: бусад улс орны туршлага, хоёрдугаар бүлэгт, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын туршлага хэмээн ангилжээ. Хоёрдугаар бүлэгт, дэлхийн нэр хүндтэй хэвлэл мэдээллийн байгууллагууд нийгмийн мэдээллийн хэрэгслийг ашиглахдаа

<sup>24</sup> [https://www.gic.mn/public/docs/publications/FB\\_community\\_standards\\_final\\_190803.pdf](https://www.gic.mn/public/docs/publications/FB_community_standards_final_190803.pdf)

<sup>25</sup> <https://about.fb.com/news/2019/10/inside-feed-womens-safety/>

<sup>26</sup> [survey\\_result\\_social\\_media\\_regulation\\_191024.pdf \(gic.mn\)](https://www.gic.mn/public/docs/publications/Survey_result_social_media_regulation_191024.pdf)

редакцын бодлогодоо юуг хэрхэн тусгаж буй туршлагыг оруулж, Монголд хэвлэл мэдээллийн байгууллагуудын энэ чиглэлийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гүйцэтгэх үүргийг онцлон тэмдэглэжээ.

Улмаар уг тайлангийн зөвлөмж хэсэгт а) нийгмийн хэвлэл мэдээллийг хууль тогтоомжоор зохицуулж буй байдал, б) нийгмийн сүлжээний орчин дахь хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тухай тусгасан байна.

Зөвлөмжөөс харахад, цахим орчинд хуулийн зохицуулалт хийхдээ улс орнууд цахим агуулгын төрөл, хэлбэрийг харилцан адилгүй байдлаар, ихэвчлэн өргөн хүрээнд тодорхойлж буй нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тодорхойгүй байдал бий болгох, цахим орчны хэрэглэгчийн эрх, эрх чөлөөнд хөндлөнгөөс зохисгүй байдлаар халдах эрсдэл бий болгож байгааг онцлон тэмдэглэжээ. Иймээс улс орнууд цахим орчинд сэтгүүл зүйн ба нийгмийн мэдээллийн хэрэгслийн өөрийн зохицуулалт хийхийг урьтач нөхцөл хэмээн уриалж байна.

Олон улсын нийтлэг сайн туршлагаас харахад, нийгэмдээ нэр хүндтэй, хэрэглэгчдийнхээ итгэл үнэмшлийг дааж явах хүсэл эрмэлзэлтэй хэвлэл мэдээллийн байгууллагууд өөрийн зохицуулалтын зарчим, хэм хэмжээг дотооддоо боловсруулан нийгмийн хэвлэл мэдээлэлтэй харилцах удирдамжаа батлан мөрдөж байна. Тус удирдамж нь тухайн редакцын байр суурийг илтгэхээс гадна сэтгүүлч, сурвалжлагчдаа цахим орчинд үүсэж болох аливаа эрсдэлээс хамгаалахад тустай аж. Ийнхүү редакцуудын дотоод зохицуулалтын бодлогын баримт бичгүүдийг бий болгох, мөрдүүлж хэвшүүлэх, нийгмийн мэдээллийн хэрэгсэлтэй харилцах удирдамжтай болоход улс орнуудын хараат бус Хэвлэл мэдээллийн зөвлөлүүдийн үүрэг, манлайлал онцгой чухал байна.

Иймээс “Нийгмийн мэдээллийн хэрэгслийн өөрийн зохицуулалт” тайлангийн зөвлөмжид Глоб Интернэшнл төвөөс дараах чиглэлүүдийг хэрэгжүүлэхийг санал болгожээ. Үүнд:

- ✓ Сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлдэг хэвлэл мэдээллийн байгууллага бүр “Нийгмийн хэвлэл мэдээллийн суваг ашиглах удирдамж” боловсруулж батлах, мөрдөх;
- ✓ Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс санаачлан бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран нийгмийн мэдээллийн хэрэгслийг ашиглах үлгэрчилсэн удирдамж гаргаж, редакцуудад санал болгох;
- ✓ Мэргэжлийн эвсэл, холбоод, төрийн бус байгууллагууд дангаараа болон хамтран энэ чиглэлээр сэтгүүлчдийг давтан сургалтад хамруулах, хэрэгцээ шаардлагын талаар хэлэлцүүлэг өрнүүлэх;
- ✓ Ийм бодлого, дүрэм, журамтай дотоодын хэвлэл мэдээллийн байгууллагуудын туршлагаас хуваалцах, ач холбогдлыг нь бусдад ухамсарлуулан ойлгуулах;
- ✓ Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хорооноос энэ чиглэлийн хэвлэл мэдээллийн ТББ-уудыг дэмжиж хамтран ажиллах;



Иймээс ГИТ-ийн тайлангийн зөвлөмжид дурдсанчлан нийгмийн мэдээллийн хэрэгсэлтэй харьцах, ашиглах дүрэм боловсруулах, хэлэлцэх, таниулах, сургах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх нь ЖҮХ болон иргэний нийгмийн байгууллагуудын хувьд чухал зорилт болж байна.

Нийгмийн мэдээллийн хэрэгсэл нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах, ЖСХ-ийн асуудлыг олон нийтийн анхаарлын төвд байлгах, үүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход нөлөөллийн чухал ач холбогдолтой хэрэгсэл болохыг үгүйсгэхгүй. Гэвч энэхүү цахим талбарт ёс зүйгүй, зүй зохисгүй хэрэглээнээс үүдэн цахим орчин дахь гэмт хэргийн тоо нэмэгдэж, бусдын нэр хүндэд халдах, гутаан доромжлох замаар ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг үзэн ядалт, ялгаварлан гадуурхалтын золиос болгох тохиолдол цөөнгүй гарах болсныг эрх бүхий хууль хяналтын байгууллагуудын тайлангуудаас харж болно.

Хэвлэл мэдээллийн орчинд цахим гадуурхалт, цахим үзэн ядалт, цахим халдлагын хохирогч ч нь эмэгтэй сэтгүүлчид илүүтэй болох эрсдэлтэйг Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс Монголын хуульчдын холбоо, Глоб Интернэшнл төвтэй 2018 онд хамтран хэрэгжүүлсэн “Сэтгүүлчийн аюулгүй байдлын түвшинг тодорхойлох судалгаа”-ны тайлан харуулдаг. Мөн Хэвлэл мэдээллийн зөвлөлийн санаачилгаар ФЭС-гийн дэмжлэгтэй хэрэгжүүлсэн “Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг” агуулгын судалгааны тайлангаас цахим сайтуудын нийтлэлийн агуулгын хэсгээс илүүтэй хэрэглэгчдийн сэтгэгдэл бичих хэсэгт үзэн ядах, ялгаварлан гадуурхах, гутаан доромжилсон үг хэллэг түгээмэл буйг олж тогтоосон.

Иймээс Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2020 онд редакцуудад зориулсан цуврал бодлогын баримт бичгүүд боловсруулан нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд буй бөгөөд анхных нь “Цахим орчинд хэвлэл мэдээллийн редакцын баримтлах бодлого” байв. Энэхүү бодлогын баримт бичигт “тухайн редакцын нийтлэлийн доорх сэтгэгдлийн хэсэг нь ч танай талбар тул ёс зүйгүй, зохисгүй агуулга бүхий сэтгэгдлүүдэд шүүлтүүртэй хандах, тогтмол модератор хийж байх”-ыг зөвлөсөн. Улмаар “тухайн редакцын сэтгүүлч нийгмийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл түгээхдээ хувийн үзэл бодол болон редакцын байр суурийг ялгаж, “хоёр нүүр” гаргахгүй байх явдал чухал”<sup>27</sup> хэмээн онцлон тэмдэглэжээ. Учир нь сэтгүүлч хүн бол олон нийтийн сонирхлыг тээгч, олон нийтийн эрх ашгийн үүднээс мэдээллийг түгээдэг тул хэрэглэгчдийнхээ өмнө онцгой үүрэг хариуцлага хүлээж, мөн тэр хэрээр итгэл үнэмшлийг тээж явдаг. Иймд сэтгүүлчийн редакцдаа баримталдаг “ёс зүйн зарчим” нь түүний ашигладаг нийгмийн хэвлэл мэдээлэлд ч хүчин төгөлдөр үйлчлэх учиртай хэмээн үздэг.

---

<sup>27</sup> “Цахим орчинд хэвлэл мэдээллийн редакцын баримтлах бодлого” сэтгүүлч редакторуудад зориулсан зөвлөмж, Хэвлэл мэдээллийн зөвлөл, 2020 он

## **Хэсгийн дүгнэлт:**

○ Монголын хэвлэл мэдээллийн байгууллагуудад нийгмийн мэдээллийн хэрэгслийг хэрхэн үр дүнтэй бөгөөд ёс зүйтэй ашиглах, хэрэглэгчидтэйгээ харилцах болон хяналт тавих тухай зааварчилгаа, удирдамж, дүрэм, журам байхгүй байна. Харин Монгол контент ХХК-аас эрхлэн явуулдаг өсвөр үеийнхэн болон хүүхдэд зориулсан цахим сайтууд болон Ийгл ТВ энэ санаачилгыг эхлүүлсэн байгаа нь сайшаалтай.

○ Улмаар жендэр, ЖСХ-ийн тухай бичих, нийтлэх, нэвтрүүлэх, редакцаас боловсруулсан мэдээллийг нийгмийн хэвлэл мэдээллээр дамжуулан хэрэглэгчдэд хүргэх, түгээхдээ баримтлах бодлогын баримт бичиг байхгүй, ийм оролдлогууд өнөөг хүртэл хийгдээгүй байна.

○ Цахим орчинд редакцын баримтлах бодлогыг Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс санаачлан боловсруулж, редакцуудад цахим орчинд баримтлах ёс зүйн бодлоготой байх, сэтгүүлчид цахим орчинд тэр дундаа нийгмийн мэдээллийн хэрэгсэлд биеэ зөв авч явах тухай анхааруулга, зөвлөмжийг өгсөн нь редакцын бодлоготой байхыг сануулсан анхны оролдлого болжээ.

○ Цахим орчин тэр дундаа нийгмийн мэдээллийн хэрэгсэлд баримтлах бодлоготой болсноор хэвлэл мэдээллийн байгууллагууд редакцын болон сэтгүүлчийн аюулгүй байдлаа хангах, хэрэглэгчидтэйгээ зохистой харилцаа тогтоохоос гадна цахим орчин дахь хүний эрхийг хамгаалахад томоохон хувь нэмэр оруулна.

○ Ардчилсан улс орнуудын туршлагаас харахад хүний эрхийн асуудлууд оффлайн болон онлайн орчинд нэгэн ижил мөрдөгдөж хэрэгжих учиртайг сануулж, харин хэрэгжилтэд хяналт тавих арга замуудаас эрх зүйн зохицуулалтыг бус өөрийн зохицуулалтыг илүүд үзэж байна.

○ Нийгмийн мэдээллийн хэрэгсэлд редакцын өөрийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээллийн зөвлөлүүдийн үүрэг, оролцоо өндөр байхыг судалгааны үр дүн, зөвлөмжүүдэд тэмдэглэжээ.

### 3.2. Нийгмийн хэвлэл мэдээллийн жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх редакцын чадавх, бэлэн байдлын үнэлгээ: Монгол болон бусад улс орнуудын туршлагаас

Мэдээллийг түргэн шуурхай түгээхээс илүү нягталсан баталгаатай мэдээллийг түгээх нь сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн (Journalism media) нэн тэргүүний зорилт юм. Сэтгүүл зүйн хэвлэл мэдээлэл нь дагаж мөрдөх ёс зүйн дүрэм, хариуцлага хүлээх чадвараараа нийгмийн мэдээллийн хэрэгсэлд (Social Media)-д байгаа иргэдээс эрс ялгаатай хэмээн ХМЗ-өөс боловсруулсан “Цахим орчинд редакцын баримтлах бодлого” баримт бичгийн өмнөтгөлд онцлон тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл, жирийн иргэн нийгмийн сүлжээнд юу хэлэх, хэрхэн илэрхийлэх нь тухайн хүний сонголтоос шалтгаалдаг бол сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллагсад редакцын үйл ажиллагаандаа төдийгүй нийгмийн сүлжээнд ч ёс зүйн хэм хэмжээнээсээ халихгүй байх (мэдээллийг нягтлан шалгах, эх сурвалжуудаар баталгаажуулах, баталгаагүй таамаг төдий мэдээллийг нийтэд түгээхээс түтгэлзэх, хохирогчийг хамгаалах, хувь хүний нэр төр, хувийн нууцад хүндэтгэлтэй хандах г.м) мэргэжлийн үүрэг хариуцлагыг хүлээдэг<sup>28</sup> хэмээн мөн тайланд дурджээ.

Тиймээс сэтгүүлчид нийгмийн мэдээллийн хэрэгсэлд ч хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангаж, жендэрийн мэдрэмжтэй байж, хэвшмэл ойлголтуудыг дэвэргэхгүй байх, ЖСХ-ийн асуудалд хүний эрхийн мэдрэмжтэй, мэдлэгтэй хандах нь онцгой чухал үүрэг, хариуцлага юм.

Олон улсын нэр хүндтэй, хариуцлагатай хэвлэл мэдээллийн редакцууд нь нийгмийн мэдээллийн хэрэгсэлд баримтлах бодлого, журмаа боловсруулж хэвлэл мэдээллийн ёс зүйн дүрэмтэйгээ зэрэгцүүлэн мөрдөж байна. Иймээс энэ хэсэгт олон улсын нэр хүнд бүхий хэвлэл мэдээллийн байгууллагууд нийгмийн мэдээллийн хэрэгсэлд баримтлах бодлого, дүрэм журамдаа жендэрийн мэдрэмжтэй байдал болон ЖСХ-ийн асуудлыг хэрхэн нийтэлж, нэвтрүүлэх тухай туршлагаас онцолж байна.

**Нью Йорк Таймс (New York Times):** 2017 онд редакцын нийгмийн мэдээллийн хэрэгсэлд мөрдөх журмаа боловсруулсан бөгөөд 2020 онд шинэчилжээ.<sup>29</sup> Энэхүү журмын өмнөтгөлд: Нийгмийн мэдээллийн хэрэгсэл нь сэтгүүл зүйд голлох үүргийг гүйцэтгэх боллоо. Нийгмийн мэдээллийн цахим талбар нь сэтгүүлч, редакторуудад ажлаа сурталчлах, мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт нь шинэчлэх, цуглуулах, эх сурвалжтай харилцах, уншигч, хэрэглэгчтэй харилцаатай байх боломжийг олгож байна. Энэ нь бидэнд шинэ боломжийг авчрахын сацуу биднээс шинэ ур чадварыг шаардаж байна хэмээн тэмдэглэжээ.

Нью Йорк Таймсын редакцын дүрэмд “сэтгүүлч, редакторууд нийгмийн мэдээллийн хэрэгсэлд бусадтай харилцахад учирч болох бэрхшээл, эрсдлээс хэрхэн сэргийлэх тухай” заасан бөгөөд “нэг

<sup>28</sup> “Цахим орчинд хэвлэл мэдээллийн редакцын баримтлах бодлого” редактор, сурвалжлагчдад зориулсан зөвлөмж, Хэвлэл мэдээллийн зөвлөл, 2020

<sup>29</sup> <https://www.nytimes.com/editorial-standards/social-media-guidelines.html>

талыг барьж, хэт туйлшрах алдаанаас зайлсхийж, төвийг сахисан мэргэжлийн байр суурьнаас хандах”-ыг урьтал болгохыг зөвлөжээ.

Мөн сэтгүүлчийн ашигладаг фэйсбүүк хуудас (*Facebook*), твиттер хаяг (*Twitter*), инстаграм (*Instagram*), снапчат (*Snapchat*) зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд нь таны “Таймс” дахь дүр төрхөөс тусдаа хувийн бүс тань мөн боловч таны онлайнаар нийтэлж байгаа бичвэр, реакшн (лайк, ангри гм) нь үнэндээ бол Таймсын сэтгүүлч гэдгээр олон нийтэд хүрдэг. Сэтгүүлчид олон нийтийн өмнө ажилладаг учраас таны нийгмийн мэдээллийн хэрэгсэл дэх хувийн орон зай "Таймс"-тай хамааралтай болохыг тодотгожээ. Мөн цахим орчинд хэн нэгнээс ямар нэгэн заналхийлэл ирвэл, хамт олондоо болон даргадаа мэдэгдэхийг зөвлөсөн байна. Тэд энэхүү журамдаа сэтгүүлчид намын үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн үзэл бодлыг сурталчлах, нэр дэвшигчдийг дэмжих, доромжилсон сэтгэгдэл бичих, бусад ёс бус зүйл хийхгүй байхыг сануулжээ. Харин нийгмийн бусад сэдэв болон жендэр, ЖСХ-ийн талаар тусгайлсан зөвлөмж байхгүй байна.

**БиБиСи (BBC):** Нийгмийн мэдээллийн хэрэгсэлд BBC-ийн сэтгүүлч, редактор, чөлөөт сэтгүүлч гээд бүх ажилчдын дагах мөрдлөг нь 2020 оны 10 дугаар сард шинэчлэгджээ.<sup>30</sup> Энэ нь нийгмийн мэдээллийн хэрэгслийг мэргэжлийн хүрээнд эсвэл хувийн хэрэгцээгээр ашигладаг БиБиСи-д ажилладаг бүх хүмүүст өгөх зааварчилгаа хэмээн тайлбарлажээ. Энэхүү мөрдлөгт сэтгүүлчдийнхээ цахим талбар буюу нийгмийн мэдээллийн хэрэгсэлд юу хийж болох, мөн юу хийж болохгүйг заасан байна. Тухайлбал:

- ✓ Шударга бус үйл явдал, улс төр, нийгэмд маргаантай, хэлэлцэгдэж байгаа сэдвүүд дээр сэтгүүлч хувийн үзэл бодлоо илэрхийлэхгүй байх;
- ✓ Хэрэв сэтгүүл зүйн “халуун гал тогоо”-нд ажилладаг сэтгүүлч, редактор бол таны нийгмийн мэдээллийн хэрэгслийн хувийн хаяг нь БиБиСи-гийн шударга байх зарчим дор нэгдэх учиртай;
- ✓ Нийгмийн мэдээллийн хэрэгсэлд баримтлах мөрдлөг нь БиБиСи-гийн редакцын бодлогын удирдамжийн нэг хэсэг;
- ✓ Энэхүү мөрдлөгт жендэр, ЖСХ-ийн сэдвийн талаар тусгайлсан заалтууд байхгүй байна.

Гэвч БиБиСи, Нью Йорк Таймс зэрэг дэлхийн томоохон хэвлэл мэдээллийн байгууллагууд нь редакцын бодлого, зарчмаараа дамжуулан хүний эрхийг хүндэтгэх, хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх, хүчирхийллийн асуудлыг хэрхэн сурвалжлах зөвлөмжийг өгчээ. Тиймээс хүний эрхийг дээдлэх, жендэрийн мэдрэмжтэй ажиллах, хүчирхийллийн асуудлыг хэрхэн сурвалжлах нь редакцын бодлогын удирдамжид нь туссан тул сэтгүүлч үүнийгээ онлайн болон оффлайн орчинд түүнчлэн нийгмийн мэдээллийн хэрэгсэлтэй харьцахдаа ч баримтлах ёстой аж.

---

<sup>30</sup> <https://www.bbc.com/editorialguidelines/guidance/individual-use-of-social-media>

Олон улсын сэтгүүлчдийн сүлжээ, Олон улсын сэтгүүлчдийн холбоо зэрэг байгууллагуудаас ЖСХ-ийн асуудлыг хэрхэн хөндөх тухай мэргэжлийн ур чадварын зөвлөмжийг өгч байна. Хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагууд сүүлийн жилүүдэд нийгмийн мэдээллийн хэрэгслийн талбарт эмэгтэй сэтгүүлчид рүү заналхийлэх, доромжлох явдал гаарч байгаа явдалд ихээхэн санаа зовниж буйгаа илэрхийлжээ. Монгол улсад нийгмийн мэдээллийн хэрэгсэлд эмэгтэй сэтгүүлчид рүү, эмэгтэй сэтгүүлч рүү дайрах, доромжлох, гутаах явдал нийтлэг тохиолдож буйг судалгааны тайлангууд болон үнэлгээний хүрээнд хийсэн ярилцлагуудын үеэр дурдагдсан.

Тухайлбал, эмэгтэй сэтгүүлч Б нь бөхчүүдийн допингийн асуудлыг олон жилийн өмнө хөндөж бичжээ. Гэтэл түүнийг жижиг дунд үйлдвэрлэлтэй (ЖДҮ)-тэй холбоотой шударга бус хуйвалдааныг эсэргүүцэн бичихэд бөх дэмжигчдийн зүгээс “гадаад найз залуутай”, “биеэ үнэлэгч” гэх мэтээр доромжилсон байна. Мөн тэрээр нефтийн компанийн үйл ажиллагааг шүүмжилсэн, эрэн сурвалжилсан бүтээлийг 2020 онд гаргасан. Энэ үед олны танил эрэгтэй хүмүүстэй хамт авахуулсан зургуудыг нь эвлүүлэн ашиглаж, нийгмийн мэдээллийн сүлжээнд гутаан доромжилжээ.

“Сэтгүүлчийн аюулгүй байдлын түвшин тодорхойлох судалгаа”-г 2019 онд ХМЗ-өөс хийхэд сэтгүүлчийн аюулгүй байдал алдагдах (биед ямар нэгэн байдлаар халдах, эх сурвалжаас бэлгийн дарамт үзүүлэх, секс чат бичих) тохиолдол таван эмэгтэй сэтгүүлч тутмын нэгд тохиолддог гэж байв.<sup>31</sup>

Дэлхийн нийт эмэгтэй сэтгүүлчдийн гуравны нэг нь цахим дайралт, гутаан доромжлолд өртөж байгааг ЮНЕСКО болон Олон улсын сэтгүүлчдийн төвөөс мэдээлж байв<sup>32</sup>. Тиймээс сэтгүүлчид бол хүний эрхийн хамгаалагчид байдаг тул тэдний бие махбод, сэтгэл зүйн, цахим аюулгүй байдлыг хамгаалахад онцгой анхаарал шаардлагатай бөгөөд ийм төрлийн сургалт, зөвлөгөө шаардлагатай хэвээр байна. Ялангуяа энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид нь эмэгтэй сэтгүүлчид байдгийг анхааралдаа авах нь зүйтэй.

ЖСХ-ийн асуудлаар мэргэшсэн сэтгүүлчидтэй хийсэн бүлгийн ярилцлагын үеэр эмэгтэй сэтгүүлчид жендэрийн хэвшмэл ойлголтуудтай холбоотой өөрт тохиолдсон кейсүүдээсээ хуваалцсан юм.

Кейс 1: Сэтгүүлч О ажлын байрны бэлгийн дарамтын асуудлыг хөндөж бичихдээ “эмэгтэй хүн богино банзал, улаанаар уруулаа будсан байсан” ч энэ нь түүнийг дарамтлах шалтгаан болохгүй хэмээн бичжээ. Гэтэл түүнийг өөрөө хохирогч байсан юм бишүү гэдэг асуултууд уншигчдаас нь иржээ. Мөн тэрээр хүүхдийн хүчирхийллийн асуудлыг хөндөж бичихэд “өөрөө охин хүүхэдтэй байж”, “битгий ийм юм бич” гэх зэргээр дарамтууд ирсэн аж.

<sup>31</sup> [https://www.gic.mn/public/docs/publications/MONITORING-Tailan\\_2019-MNG.pdf](https://www.gic.mn/public/docs/publications/MONITORING-Tailan_2019-MNG.pdf)

<sup>32</sup> <https://www.dw.com/en/new-research-online-attacks-on-women-journalists-lead-to-real-world-violence/a-55712872>

Кэйс 2. ЖСХ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын үеэр “ЖСХ-ийн асуудлыг эмэгтэй сэтгүүлчид түлхүү хөндөж бичдэг”, “Гэтэл эмэгтэй сэтгүүлчид рүү дайралт, доромжлол илүүтэй байдаг”, “Тэднийг “хүчирхийлэгч” гэж хүртэл цоллож байсан” хэмээн мэргэжилтнүүд онцолж байв.

Эндээс харахад, жендэр, ЖСХ-ийн асуудлыг редакцын бодлогод суулгахдаа жендэрийн эрх тэгш байдал, жендэрийн хэвшмэл хандлагыг өөрчлөхийг давхар бодолцох учиртай. ЖСХ-ийн асуудлыг эмэгтэй сэтгүүлчид ихэвчлэн хөнддөг боловч гадуурхалт, цахим доромжлолд өртөх эрсдэл тэдэнд илүү их тохиолддогийг судалгааны үр дүнгүүд харуулж байна.

**Дойчэ Вэллэ (DW):** ХБНГУ-ын “Дойчэ Вэллэ” нь нийгмийн мэдээллийн хэрэгсэлд баримтлах “Олон нийтийн стандарт”-тай ажээ.<sup>33</sup> Энэхүү дотоод зохицуулалтын журмаар нийгмийн мэдээллийн хэрэглэгч, “Дойчэ Вэллэ”-гийн хооронд нээлттэй, нөхөрсөг, хүндэтгэлтэй орон зайг бий болгохыг зорьсон бөгөөд иргэдийг ДВ-тэй холбоотой шүүмжлэл, санал хүсэлтээ илэрхийлэх нь нээлттэй гэжээ. Мөн фэйсбүүк, твиттер болон бусад нийгмийн мэдээллийн хэрэгслийн талбарт байгаа хэрэглэгчийг ямар үйлдэл хийж болохгүйг товч тодорхой тайлбарласан бөгөөд дараах зөрчлүүдийг удаа дараалан гаргасан тохиолдолд блок хийх арга хэмжээ авахаа мөн мэдэгджээ.

Эдгээр зөрчлүүдэд бусдын хувийн мэдээллийг нийтэд дэлгэхгүй байх, арьс өнгөөр болон бусад хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх, хүчирхийлэл, садар самууныг сурталчлахгүй байх, бусад хэрэглэгчдийн үндэс угсаа, шашин шүтлэг, хүйс, бэлгийн чиг баримжаагаар доромжлохгүй байх зэргийг тусгажээ. Мөн хуурамч, худал сэтгэгдлийг устгах болно гэдгээ “Дойчэ Вэллэ” ил тод хэлжээ.

Монгол улсад хэвлэл мэдээллийн байгууллагууд нь ХМЗ-өөс боловсруулан “Хэвлэл мэдээллийн ёс зүй зарчим”-ийг даган мөрдөж буй хэдий ч редакцын болон нийгмийн мэдээллийн хэрэгсэлд баримтлах бодлого, дүрэм, журам тун ховор байгаа нь редакцын дотоод зохицуулалтыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага үгүйлэгдэж байна. Ингэхдээ дээр дурдсан олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудын жишгийн дагуу цахим орчинд ялангуяа нийгмийн мэдээллийн хэрэгслийн талбарыг илүү эрүүл, зөв зохистой, ёс зүйтэй байлгахад хэвлэл мэдээллийн байгууллагуудын үүрэг, манлайлал чухал байна.

ХМЗ-өөс редактор, сурвалжлагчдад зориулан “Цахим орчинд хэвлэл мэдээллийн редакцын баримтлах бодлого”-оос дараах санал зөвлөмжүүдийг редакц өөрийн дотоод дүрэм журамдаа дэлгэрүүлэн тусгах бүрэн боломжтой.

1. **Сэтгүүлч, сурвалжлагч үзэн ядалт, гутаан доромжлолд өртсөн тохиолдолд яах вэ:** Олон нийтийн эрх ашгийн өмнөөс бэлтгэсэн нийтлэл, нэвтрүүлэгтэй нь холбоотойгоор цахим орчинд

<sup>33</sup> <https://www.dw.com/en/dw-community-guidelines/a-49879333#:~:text=Ensure%20that%20your%20tone%20is,with%20what%20is%20being%20said.>

сэтгүүлч, хүний эрхийг хамгаалагчид руу хоморголон дайрах, элдвээр доромжлох, заналхийлэх зэрэг тохиолдол цөөнгүй гарах болжээ. Энэ нь сэтгүүлчдийн болон хүний эрхийн хамгаалагчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад болж, хувь хүний сэтгэл зүйд сөргөөр нөлөөлдөг тул хэвлэл мэдээлэл болон иргэний нийгмийн байгууллагууд нь үүнийг хэрхэн даван туулах тухай мэдлэгтэй байх нь чухал юм.

**2. Сэтгүүлч, сурвалжлагч социал медиа орчинд биеэ авч явах нь:** Нийгмийн мэдээллийн хэрэгсэл нь хүний эрхийг хамгаалагчдийн үйл ажиллагааны салшгүй хэсэг бөгөөд олон нийттэй холбоо тогтоох, шуурхай чухал мэдээллийг олж авах төдийгүй, шинэ орчныг хүлээн авагчидтай холбогдох боломжийг олгож байгаа юм. Гэхдээ нэг л буруу алхам нь хувийн болоод мэргэжлийн байдлын ялгааг бүдгэрүүлж бусдад буруу ойлголт түгээх нь бий. Тиймээс фэйсбүүк, твиттер, юүтүб, инстаграм гэх мэтэд мөрдлөг болох зөвлөмжтэй байх чухал юм.

**3. Сэтгүүлч социал медиад мэдээлэл түгээхдээ хувийн болон редакцын байр суурийг ялгах:** Твиттер, фэйсбүүк, инстаграм зэрэг нийгмийн мэдээллийн хэрэгсэл нь хүний эрх хамгаалагчдын мэдээллээ түгээх, хүргэх онцгой суваг боловч хувь хүний хувьд олон нийттэй холбогдохдоо тодорхой зааг баримтлах шаардлагатай юм. Өөрийн үзэл бодлоо хувийн аккаунт, пэйжээрээ илэрхийлэх, уншигчдын сэтгэгдэлд хэрхэн хандах зэргийг редакцаас тусгайлан зөвлөх болжээ. Хувийн болон байгууллагын байр суурийг ялгаж, социал орчинд “хоёр нүүр” гаргахгүй байхыг анхааруулж байна.

**4. Сэтгүүлч хуурамч мэдээллийг ялгаж таних чадвартай байж, хуурамч мэдээллийг түгээхгүй байх:** Дижитал эрин үед технологи хөгжихийн хэрээр цахим орчинд хуурамч мэдээлэл түгэх нь элбэг болжээ. Хуурамч мэдээллийг нягтлан шалгах, ялгаж таних ур чадварт суралцах, өөрийгөө хөгжүүлэх нь чухал юм.

**5. Сэтгүүлч цахим орчинд үзэн ядалтын үг хэллэгийг ашиглахгүй байх:** “*Hate speech*” буюу үзэн ядах үг хэллэг бүхий агуулга цахим орчинд хурдтай бөгөөд өргөн хүрээг хамран тархаж байна. Хэдий тийм боловч үзэн ядах үг хэллэгийг тархааж түгээхийн эсрэг ямарваа нэг санал санаачилга, ажил хэрэг шаардлагатай байна. Тиймээс энэ талаар нарийн судлахын зэрэгцээ олон нийт болон мэргэжилтнүүдийн ойлголтыг сайжруулах, үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх чиглэлд хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай.

### **Хэсгийн дүгнэлт:**

- Монголын хэвлэл мэдээллийн байгууллагуудад нийгмийн мэдээллийн хэрэгсэлтэй редакцын түвшинд болон сэтгүүлчдийн хувьд хэрхэн харилцах тухай удирдамж байхгүй, энэ чиглэлд төлөвлөсөн зүйлгүй, төдийлөн анхаарал хандуулж ач холбогдол өгөөгүй аж.

- Монгол контент ХХК-аас эрхлэн гаргадаг өсвөр үеийнхэн болон бага насныханд зориулсан сайтуудыг эс тооцвол хэрэглэгчидтэйгээ хэрхэн харилцах, тэдний ёс бус үг хэллэг, үйлдлийг таслан зогсооход редакцын дотоод зохицуулалт бүхий хэрэглэгчийн стандартыг нэвтрүүлсэн туршлага байхгүй.

○ Хэвлэл мэдээллийн байгууллагуудад одоогоор нийгмийн хэвлэл мэдээлэл дагасан сөрөг, хэт сөрөг урсгалыг хэрхэн зохицуулах талаар туршлага, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалтгүй тул дэлхийд нэр хүндтэй хэвлэл мэдээллийн байгууллагуудын энэ талын туршлагаас суралцах өргөн боломж байна.

○ Олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудаас Нью Йорк Таймс, БиБиСи зэрэг нь сэтгүүлчийн мөрдөх редакцын дүрмээс гадна нийгмийн хэвлэл мэдээлэлд байгаа хэрэглэгчидтэйгээ харилцах дүрэм журмыг боловсруулж хэрэгжүүлж хэвшжээ.

○ ХМЗ-өөс боловсруулсан “Цахим орчинд редакцын баримтлах бодлого” нь редакцуудад энэхүү жишгийг нэвтрүүлэх, үргэлжлүүлэн хөгжүүлэхэд түлхэц болохуйц эхлэлийн алхам болжээ.

○ Сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлдэг хэвлэл мэдээллийн байгууллагууд хэрэглэгчдийнхээ коммент хэсгийг тогтмол хянах, сэтгүүлчид, ажилтнуудынхаа нийгмийн мэдээллийн хэрэгсэлд баримтлах ёс зүйн дүрэмтэй болох, улмаар хэрэглэгчдийн мөрдөх стандарттай болох, түүнийгээ ил тод байршуулж олон нийтэд сурталчлах зэрэг нь мэргэжлийн редакцын төлөвшил болон хэвлэл мэдээллийн боловсролтой иргэдийг төлөвшүүлэхэд ихээхэн үүрэгтэй байна.



### 3.3. Нийгмийн хэвлэл мэдээллийн жендэрийн мэдрэмжтэй байдлын хяналт, хариуцлага: эрх зүйн болон өөрийн зохицуулалт

Нийгмийн хэвлэл мэдээлэлд эрх зүйн болон өөрийн зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ аль ч тохиолдолд үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хязгаарлаж болохгүйг санах учиртай. Нийгмийн хэвлэл мэдээлэл нь сэтгүүлчдэд ажлын шинэ орон зай, шинэ боломжийг олгосон бөгөөд тэд энэ талбарт урьдын адил сэтгүүл зүйн мэргэжлийн ажлаа хийсээр байна. Тиймээс сэтгүүлчдийн оффлайн орчинд дагаж мөрдөж ирсэн зохицуулалтууд нь онлайн орчинд, тэр дундаа нийгмийн мэдээллийн хэрэгсэлд мөн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

Цахим орчинд “Хэвлэлийн эрх чөлөө, мэдээлэл авах эрх, мэдээллийн ил тод байдлыг хангах” болон “Нууцлал, өгөгдөл хамгаалах” асуудлын тэнцвэрийг хангах ёстойг сануулсаар байна. Энэ тэнцвэрийг хангахын тулд ЮНЕСКО-гийн боловсруулсан цахим орчины мэдлэг олгох, тогтвортой хөгжлийг хангах зарчмыг баримтлах нь зүйтэй тухай “Нийгмийн мэдээллийн хэрэгслийн өөрийн зохицуулалт” тайланд тэмдэглэжээ.<sup>34</sup>

Түүнчлэн тус тайланд дурдсанаар, Итали, Австрали, БНСУ зэрэгт нэвтрүүлсэн хуулиуд, ИБУИНВУ-ын хуулийн төсөл нь цахим орчин, нийгмийн мэдээллийн хэрэгслийн талбарт хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалахад чиглэжээ. Түүнчлэн эдгээр хуулийн зохицуулалтаар хүүхдийг цахим дарамтад өртөх, бэлгийн хүчирхийллийн хохирогч болох, бэлгийн мөлжлөгт өртөх зэрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлжээ. Мөн ёс бус бэлгийн харилцаа, хүүхдийн порнограф, садар самуун сурталчилгаа зэргийг хориглосон байна.

Манай улсын хувьд мөн адил нийгмийн хэвлэл мэдээлэлд хүүхдийг ямар нэгэн гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилсан сэргийлэх бодлого, зохицуулалтууд бий. Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) нь ekids.mn цахим хуудсаар дамжуулан цахим орчин дахь хүүхэд хамгааллын бодлого, үйл ажиллагаагаа олон нийтэд хүргэж байна.

Мөн *Internet Watch Foundation* гэх олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр монгол хэл дээрх хүүхдийн бэлгийн хүчирхийллийн зураг, видео бичлэгийг интернетээс устгах, урьдчилан сэргийлэх, мэдээлэл өгөх систем мөрдөгдөж байна.<sup>35</sup>

2019 оны зургаадугаар сараас ХХЗХ нь Фэйсбүүк компанитай хамтран “Ногоон суваг”-ийг албан ёсоор нээсэн.<sup>36</sup> Ингэснээр фэйсбүүк орчинд хүчирхийлэл, гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн мөлжлөг, садар самуун, дээрэлхэх дарамтлах, үзэн ядах үг хэллэг, худал мэдээлэл зэрэг агуулгын хувьд зохисгүй контентыг устгах, хязгаарлах боломжтой болсон.

Жендэрийн эрх тэгш байдалд халдсан үзэн ядах үг хэллэг, худал мэдээлэл, жендэрт суурилсан хүчирхийллийг хүн эрхийн мэдрэмжгүй нийтэлсэн зүй бус контентыг “Ногоон суваг”-аар

<sup>34</sup> “Нийгмийн хэвлэл мэдээллийн зохицуулалт” судалгаа, Глоб интернэшнл төв, ННХ, 2019

<sup>35</sup> <https://report.iwf.org.uk/mn/>

<sup>36</sup> <https://crc.gov.mn/k/2Zh>

дамжуулан устгуулах, хязгаарлах тухай өргөдөл гомдол ирсэн эсэх, хэрэв тийм бол түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг ХХЗХ-оос тодруулж тоо баримтыг тогтмол шинэчлэх боломж бүрдсэн юм.

2018 онд “Цахим орчинг зөв болгоё” аянг ЗГХЭГ, ХХЗХ, Цагдаагийн ерөнхий газраас төрийн бус байгууллагуудтай хамтран цахим орчинд мэдээллийн эерэг давалгааг бий болгох, цахим орчинд үйлдэгдэж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн мэдлэг олгох зорилгоор зохион байгуулжээ. Мөн 2020 онд жендэрийн тухай хэвшмэл ойлголт, хандлагыг нийгмийн мэдээллийн хэрэгсэлд эерэг болгох зорилгоор “Хүндлэлд хүйс хамаарахгүй” аянг ЖҮХ-оос Азийн Хөгжлийн Банктай хамтран “Иргэний нийгмийн оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь” техник туслалцааны төслийн хүрээнд хэрэгжүүлсэн. Эдгээр аянг жендэр, жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлаар нийгмийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээг эерэгээр өөрчлөх зорилгоор зохион байгуулжээ.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд нь нийгмийн хэвлэл мэдээллээр дамжуулан кампанит ажлуудыг идэвхтэй өрнүүлдэг. Тухайлбал, “Хүн бай”, “Нэг тэрбумаараа алхъя”, “Хаалганы цаана”, Хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аян гэх мэт олон нийтэд хүрсэн аянуудыг нэрлэж болно. Эдгээр нь нийгмийн мэдээллийг хэрэгсэл ашиглаж олон нийтэд мэдээлэл түгээхэд түлхүү төвлөрч байна. Нийгмийн мэдээллийн хэрэгсэлд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үйлдэгдэж буй гэмт хэргийг таслан зогсоох зорилгоор төрийн байгууллагууд өөрсдийн вэб сайтаар мэдээлэл өгөхийн зэрэгцээ нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж байна.

### **Нийгмийн хэвлэл мэдээлэлд редакцын өөрийн зохицуулалт**

Бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэлт, хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэгчид цахим орчинд тэр дундаа нийгмийн мэдээллийн хэрэгслийг түлхүү ашиглах болсон тухай ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч Б.Энхчимэг хэлжээ.<sup>37</sup> Ингэхдээ фэйсбүүкийн хуурамч хаяг, зарын группыг түгээмэл ашигладаг тухай мөн дурдсан байна.

Хүйсийн тэгш эрхийн төвийн “Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл” 2019 оны судалгаагаар биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан мэдээлэл, нэвтрүүлэг, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хангалтгүй гарсан” гэж дүгнэжээ. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс гадна тэдгээрийн ашигладаг албан ёсны нийгмийн мэдээллийн сувгууд урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлд чухал үүрэгтэй. Үүний тулд редакцууд өөрсдийн талбарыг илүү цэгцтэй, бодлоготой болгох шаардлага тулгарч байна.

---

<sup>37</sup> <https://police.gov.mn/a/5094>

Сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн байгууллагууд нийгмийн мэдээллийн хэрэгсэлтэй хэрхэн харьцаж буй туршлагаас дараах дөрвөн жишээгээр тайлбарлалаа.

**Кейс 1.** 2020 оны есдүгээр сард биеэ үнэлэгч авсан гэх 20 настай залуугийн ярилцлагыг зарим хэвлэл мэдээллийн хэрэгслүүд гаргаж мөн фэйсбүүк хуудсаараа цацсан нь олон нийтийн маргаан, шүүмжийг өрнүүлсэн. Олон нийт тус мэдээг бэлтгэсэн сэтгүүлчийг “хүний эрхийн мэдрэмж”-гүй хандаж, эх сурвалжтай зохисгүй харьцсанд шүүмжлэлтэй хандсан. Тус бичлэг нь фэйсбүүкээс устгагдсан боловч юүтүбт “Биеэ үнэлэгч авсан 20 настай залууг сэтгүүлч, цагдаа илрүүлжээ!!!” гэсэн гарчигтайгаар 2020 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр байршсан байна. Одоогоор тус бичлэгийг 2505 хүн үзэж, 6 хүн сэтгэгдэл бичиж, 5 хүн цааш нь хуваалцжээ.<sup>38</sup> Сэтгэгдлүүд сэтгүүлчийн үйлдлийг шүүмжилсэн байна.

**Кейс 2.** Энэхүү шөнийн сурвалжлагын дараа Ийгл ньюс телевиз<sup>39</sup>, livetv.mn<sup>40</sup> сайтаас сэтгүүлчийг хүний эрхийн мэдрэмжтэй ажиллаж, эх сурвалжтай хүндэтгэлтэй харилцаж, ёс зүйн зарчмаа дагаж мөрдөхийг уриалж мэдээ бэлтгэсэн.

**Кейс 3.** 2018 онд ТВ8 Mongolia гэсэн фэйсбүүк хуудсанд “10 биеэ үнэлэгч тутмын зургаа нь бэлгийн замын халдварт өвчинтэй”<sup>41</sup> гэсэн мэдээ нийтлэгджээ. Тус мэдээ нь 92 реакшн (лайк, ангри г.м), 12 сэтгэгдэлтэй байна. Сэтгэгдлүүдийг харахад, ихэнх нь биеэ үнэлэгчийг буруутгаж, харин охид, эмэгтэйчүүдийг хүчээр биеийг нь үнэлүүлдэг тохиолдлын талаар огт дурсаагүй байна. ТВ8 телевизийн зүгээс нэвтрүүлэг цацагдсаны дараа нийгмийн мэдээллийн сувгийн хэрэглэгчидтэйгээ огт харилцсангүй, үзэгчдийн хэвшмэл ойлголт, хандлагыг засах талаар ямар ч оролдлого хийсэнгүй.

**Кейс 4.** Хүйсийн тэгш эрхийн төвөөс 2020 оны 10 дугаар сард бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг түгээх зорилгоор хэвлэл мэдээллийн аян зохион байгуулжээ. Сэтгүүлчдийн бүтээлийг тэд өөрсдийн фэйсбүүк пэйжээрээ төлбөртэйгээр нийтэлсэн байна. Өнөөдөр сонины сэтгүүлч Ч.Болортуяа хувцаслалт нь хүчирхийлэлд өртөх бай биш болохыг хөндөж “*Охидод өнөөдөр өмд өмсгөө, маргааш нүүрийг нь халхалъя*” гарчигтай нийтлэлийг бичжээ. Тус нийтлэл нь Хүйсийн тэгш эрхийн төвийн фэйсбүүк хуудсанд цахим хэлэлцүүлэг өрнүүлэхэд хүргэсэн байна. Тус төвийн пэйжээс 668 лайк, 165 сэтгэгдэл, 240 шэйр авчээ. Харин шэйрээс дамжин 265 лайк, 193 сэтгэгдэл, 109 дахин шэйр авсан байна. Сэтгэгдэлд анализ хийхэд хүчирхийллийн шалтгааныг хохирогчийн хувцас, биеэ авч явах байдлаас болдог гэсэн хэвшмэл ойлголт давамгайлж байв. Иймд тус төвөөс эерэг ойлголтыг олон нийтэд өгөх зорилгоор сэтгэгдлүүдэд хариулт өгч эхэлжээ.

<sup>38</sup> <https://www.youtube.com/watch?v=oyAWzfl7SCQ>

<sup>39</sup> <https://www.facebook.com/eaglenewssocial/posts/2801374713428920>

<sup>40</sup> <sup>40</sup> <https://livetv.mn/p/168185>

<sup>41</sup> [https://www.facebook.com/watch/?ref=search&v=2082334318662098&external\\_log\\_id=34db8f43-9bb4-4a4f-816f-e0823785bfb8&q=%D0%B1%D0%B8%D0%B5%D1%8D%20%D2%AF%D0%BD%D1%8D%D0%BB%D1%8D%D0%B3%D1%87](https://www.facebook.com/watch/?ref=search&v=2082334318662098&external_log_id=34db8f43-9bb4-4a4f-816f-e0823785bfb8&q=%D0%B1%D0%B8%D0%B5%D1%8D%20%D2%AF%D0%BD%D1%8D%D0%BB%D1%8D%D0%B3%D1%87)

Эндээс харахад, сэтгүүлчид нийгмийн мэдээллийн хэрэгсэл ашиглаж жендэр, ЖСХ-ийн тухай ойлголт, мэдлэгийг олон нийтэд хүргэх шаардлагатай боловч уншигчдын сэтгэгдлийг хайхралгүй орхиж боломгүй. Хэрэглэгчийн хариу үйлдэл, сэтгэгдэл, бусадтай хуваалцаж буй байдал зэрэг нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх хэлбэр боловч тэднийг зөв зохистой хэрэглээнд сургах нь хэвлэл мэдээллийн бодлогын гадна үлдэх учиргүй. Иймээс хэвлэл мэдээллийн редакцууд бүтээлээ хэвлэн нийтлээд түгээгээд орхих бус түүний доорх хэрэглэгчдийн сэтгэгдэл, санал бодолтой харилцаж, шаардлагатай бол тэдний ёс зүйгүй үйлдлийг таслан зогсоох, хүний эрх, жендэрийн мэдрэмжгүй үг хэллэг, жендэрийн хэвшмэл ойлголтыг засаж залруулах үүргийг давхар хүлээх нь зүйтэй.

Цахим сайтуудын мониторингоос харахад, сайтыг сэтгэгдэл хэсэгт эсвэл нийгмийн мэдээллийн хэрэгсэлд илэрхийлсэн хэрэглэгчийн сэтгэгдэл нь редакцын байр суурь биш бөгөөд хариуцлага хүлээхгүй тухайгаа илэрхийлжээ. Хэдийгээр иргэний үзэл бодол нь редакцын байр суурийг илэрхийлэхгүй боловч сэтгэгдлийг редакц хайхрахгүй өнгөрч хэрхэвч болохгүй. Учир нь коммент буюу сэтгэгдэл бичих талбар бол тухайн редакцын үйл ажиллагааны нэг хэсэг бөгөөд тэдний өөрийн талбар тул “гэртээ орж ирсэн хүнийг зүй зохистой байх”-ыг шаардах эрх редакцад бий.

Иймээс редакц хэрэглэгчтэйгээ сэтгэгдлээр нь дамжуулан тогтмол харьцах, хяналт мониторинг хийх, зохисгүй агуулга илэрвэл модератор хийх буюу тэмдэгтийг өөрчлөх, эсвэл устгах зэрэг дотоод өөрийн зохицуулалтаа хийх шаардлагатай. Улмаар ийм төрлийн ажил үүрэг хүлээсэн “Сошиал медиа” хариуцсан мэргэжилтэнтэй болох, санхүүгийн боломжгүй бол үүрэг чиглэл ойролцоо, ачаалал арай бага хэн нэгэндээ давхар үүрэг хүлээлгэж болно. Ийм төрлийн дотоод зохицуулалтыг редакц нэвтрүүлж чадсанаар өөрийн талбараа эрүүл, цэвэр байлгах аас гадна уншигч, үзэгч, сонсогчидтойгоо тогтмол харилцаатай байж, бизнесийн нэр хүнд, итгэл үнэмшлээ дээшлүүлэх менежментийн нэг хэсгээ болгож чадна.

Одоогийн байдлаар Монгол контент ХХК-аас эрхлэн гаргадаг Yolo.mn, Maamuu.mn сайтууд редакцын бодлогодоо “олон нийтийн зарчим”-ыг тусгасныг эс тооцвол ийм практик туршлага, оролдлогууд бусад хэвлэл мэдээллийн байгууллагуудад хараахан бүрэлдээгүй байна. Тус редакцууд олон нийтийн зарчимдаа хэрэглэгчийн бусдыг доромжилсон, гутаасан, үзэн ядсан, ёс бус сэтгэгдлийг редакцын зүгээс устгах тухайгаа мэдэгджээ. Ийм зохицуулалтыг ХБНГУ-ын Дэйчэ вэллэ хэрэгжүүлдэг тухай өмнөх хэсэгт тэмдэглэсэн байгаа.

2019 оны дундуур Хэвлэл мэдээллийн зөвлөл “Гомдол хүлээн авах, барагдуулах журам”-ын 1.2-тоо нэмэлт өөрчлөлт оруулсан нь нийгмийн мэдээллийн хэрэгсэл дагасан асуудлуудаас үүдэлтэй аж. Уг нэмэлт нь ХМЗ нь *“Зөвхөн хэвлэмэл болон онлайн хэвлэл, радио, телевизийн сэтгүүлчийн бэлтгэж түгээсэн аливаа сэтгүүл зүйн бүтээл болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн албан ёсны сошиал хуудсаар түгээгдсэн сэтгүүл зүйн бүтээлтэй холбоотой гомдлыг авч хэлэлцэнэ”*<sup>42</sup> хэмээн

---

<sup>42</sup> [Гомдол хүлээж авах, барагдуулах журам \(mediacouncil.mn\)](http://mediacouncil.mn)

оруулжээ. Ингэснээр иргэн, аж ахуйн нэгжээс нийгмийн мэдээллийн хэрэгслээр түгээгдсэн редакцын контент агуулгыг ёс зүйгүй байна гэж үзвэл ХМЗ-д гомдол гаргах боломжтой болжээ.

Харин нийгмийн мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн хувь сэтгүүлчийн постын эсрэг гомдлыг одоогоор хүлээн авах зохицуулалт хийгдээгүй байна. Иймээс ХМЗ-өөс 2019 оны 5 дугаар сард Хэвлэлийн эрх чөлөөний өдөрт зориулсан хэвлэлийн бага хурлынхаа үеэр “сэтгүүлчид өөрийн социал хуудсаараа дамжуулан хувийн үзэл бодол, байр суурь, шүүмжлэл илэрхийлэхдээ “сэтгүүлч” гэдгээ байнга санаж, редакцынхаа байр суурьтай зөрчилдсөн, худал хуурмаг, баталгаажиж нягтлаагүй, хүний эрхэд халдсан мэдээллийг түгээхээс зайлсхийх ёстой. Иймээс редакцууд дотоод бодлогодоо энэ тухай тусгах шаардлагатай” гэдгийг сануулж, уриалжээ.

## Хэсгийн дүгнэлт

- Онлайн орчинд хүний эрхийг хамгаалах, жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрийн хэвшмэл ойлголтуудыг засаж залруулахад сэтгүүл зүйн болон нийгмийн хэвлэл мэдээллийн үүрэг, оролцоо чухал юм. Гэвч нийгмийн хэвлэл мэдээлэлд редакцууд өөрийн зохицуулалтаа хэрэгжүүлж хэвшээгүй байна.

- Монгол улсын хэмжээнд дөрвөн редакц олон нийтийн буюу хэрэглэгчийн дүрэмтэй бөгөөд үүнийхээ хэрэгжилтийг хэрхэн хангаж, хяналт тавьж ажилладаг нь одоогоор тодорхойгүй.

- Редакц дотооддоо эсвэл хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагаар дамжуулан нийгмийн мэдээллийн хэрэгслийг ёс зүйтэй ашиглах, үүнээс улбаалсан хуурамч, хортой мэдээлэлтэй тэмцэхэд хяналт тавих, хариуцлага тооцох механизмыг хөгжүүлэх хэрэгцээтэй байна.

- Цахим орчин дахь хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангахад улс орнууд эрх зүйн болон өөрийн зохицуулалтыг хослуулан ашиглаж байна. Ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхнийг эрсдэлтэй, хортой мэдээллээс хамгаалах зорилгоор эрх зүйн зохицуулалтуудыг хийж байгаа ч энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хаалт болох ёсгүйг олон улсын байгууллагууд сануулсаар байна.

- Харин цахим орчинд хүний эрхийг хамгаалах нэрийн дор үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халгүйгээр зохицуулах хамгийн боломжит хувилбарыг хэвлэл мэдээллийн болон нийгмийн мэдээллийн өөрийн зохицуулалт хэмээн үзэж байна.

- Хэвлэл мэдээллийн байгууллагуудад нийгмийн мэдээллийн хэрэгсэлд хяналт тавих, хэрэглэгчдийн санал сэтгэгдэлд хариулт өгөх, уншигч, үзэгч, сонсогчтойгоо харилцах “Сошиал медиа мэргэжилтэн”-тэй болох хэрэгцээ шаардлага байна.

- Одоогоор ХМЗ нь редакцын нийгмийн мэдээллийн хэрэгсэлд хаягласан гомдлыг хүлээн авч буй бөгөөд цаашид тус зөвлөлийн гомдол хүлээн авах, барагдуулах журамд сэтгүүл зүйн агуулгаас гадна сэтгүүлчийн нийгмийн мэдээллийн хэрэгслийн асуудлаар тусгайлсан заалт оруулах хэрэгцээ шаардлагыг судлах шаардлагатай.

## Дөрөв. ЗӨВЛӨМЖ

*Нэг. Сэтгүүл зүйн ба нийгмийн хэвлэл мэдээллийн жендэрийн бодлогын чиглэлээр сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг чадавхжуулах хүрээнд:*

1. Сэтгүүл зүйн ба нийгмийн хэвлэл мэдээллийн жендэрийн бодлого, жендэрийн эрх тэгш байдал, жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүй, жендэрт суурилсан хүчирхийлэл зэрэг сэдвийн хүрээнд сэтгүүлчдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг эргэн харж, нийгмийн хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг нэмж тусгах замаар системтэй, интерактив хэлбэрийн сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулахыг санал болгож байна.
2. Сэтгүүлчдийг чадавхжуулахдаа жендэр, ЖСХ-ийн чиглэлээр мэргэшсэн болон мэргэшх сонирхолтой гэсэн ангиллаар зорилтот бүлгээ ялгаатай тогтоож, тэдэнд тохирсон агуулга, ойлголтыг зохих хэлбэрээр олгох нь чухал юм.
3. Хэвлэл мэдээллийн байгууллагын редакторууд жендэр, ЖСХ-ийн чиглэлээр сэтгүүлчдээ мэргэшүүлэх сонирхолтой бөгөөд тэдэнд тогтмол сургалт, хүний эрх, ёс зүй, эрх зүйн чиглэлийн нэр томъёоны тайлбар, гарын авлагууд шаардлагатай байна.
4. Хэвлэл мэдээллийн редакцын эрхлэгч, ерөнхий редактор, албаны дарга нар хүний эрхийн мэдрэмжтэй, мэдлэгтэй байх хэрэгтэй, тэдэнд жендэрийн эрх тэгш байдал, жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг дэмждэг бодлого, соёл үгүйлэгдэж буйг сэтгүүлчид дурдсаныг анхааралдаа авах нь зүйтэй.
5. ХМЗ-ийн ёс зүйн хороогоор шийдэгдсэн хүний эрхийн зөрчилтэй, хохирогчийг хамгаалж чадаагүй сэтгүүл зүйн бүтээлүүдийг задлан шинжилж, кейс анализ хийж онол, дадлага хосолсон практик зөвлөмжийг сэтгүүл зүйн оюутнууд, сэтгүүлчдэд хүргэх нь практик ач холбогдолтой байна.
6. Эмэгтэй сэтгүүлчдийн эсрэг ялангуяа нийгмийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн сэтгэгдэл хэсэгт үзэн ядалтын үг хэллэг бүхий дайралт, ялгаварлан гадуурхал их байгаа нь тэдний жендэр, ЖСХ-ийн асуудлаар ажиллахад ноцтой саад болж байна. Тиймээс редакцуудыг сэтгүүлч эмэгтэйчүүдийг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд сэдэлжүүлэх шаардлагатай байна. Энэ хүрээнд “Эмэгтэй сэтгүүлчдийн эрх, аюулгүй байдал” хэлэлцүүлэг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн байгууллагуудад хандсан зөвлөмж гаргахыг зөвлөж байна.

***Хоёр. Жендэрийн мэдрэмжтэй ёс зүйн зарчим, редакцын бодлого, мониторинг, хяналт үнэлгээг дэмжих чиглэлээр***

1. Дижитал эрин үеийн мэдээллийн асар их урсгалд хэвлэл мэдээллийн байгууллагууд редакцын бодлогоо яаралтай боловсруулан батлах, ингэхдээ нийгмийн мэдээллийн хэрэгсэлд ажиллах зарчим, олон нийтийн дагаж мөрдөх зарчим, жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг хөгжүүлэх асуудлуудыг тусгах нь хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангахад онцгой ач холбогдолтой байна.
2. Хэвлэл мэдээллийн байгууллагын редакцын бодлогод жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих, жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг хөгжүүлэх чиглэлийг тусгаж, ийм жишиг удирдамжийг нэвтрүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг төлөвлөж, редакцуудтай хамтран ажиллахыг ЖҮХАА-д санал болгож байна.
3. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг байгууллагын үйл ажиллагаатай нийцүүлэх замаар жендэрийн мэдрэмжтэй ёс зүйн зарчим, редакцын удирдамж, бодлогыг нэвтрүүлэх талаар яриа хэлэлцүүлэг өрнүүлэх, улмаар жендэр, ЖСХ-ийн асуудлаар дотоод хяналтын хуудас боловсруулан туршиж нэвтрүүлэхийг зөвлөж байна.
4. ХМЗ-өөс боловсруулсан “Цахим орчинд редакцын баримтлах бодлого” нь редакцуудад цахим орчинд өөрийн зохицуулалт хийх жишиг болохуйц эхний алхам болсон тул үүнийг цааш хөгжүүлж, дараагийн цуврал гарын авлагыг “Жендэрийн мэдрэмжтэй редакцын бодлого” сэдвээр хийх боломжтой.
5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудад жендэрийн мэдрэмжтэй, хүний эрх, хүүхэд хамгааллын бодлоготой байхын ач холбогдлыг таниулж, эдгээр бодлогын баримт бичиг, түүний хэрэгжилт нь тухайн редакцын имидж, бизнесийн нэр хүндийн салшгүй нэг хэсэг болохыг таниулж, сэдэлжүүлэх нь чухал юм.

***Гурав. Жендэрийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн үүрэг оролцоог дээшлүүлэх***

1. Жендэрийн тэгш байдлыг дэмжсэн соёл, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх чиглэлээр ЖҮХ болон хэвлэл мэдээллийн мэргэжлийн эсвэл холбоодын хамтарсан уриалга, зөвлөмж гарган редакцуудад хүргэх, олон нийтэд мэдээлэх зэргээр түлхэц үзүүлэхийг санал болгож байна.
2. Сэтгүүлчдэд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг хөгжүүлэх чиглэлээр гадаад улс орнуудын туршлагаас суралцах, мэдлэгээ дээшлүүлэх хүсэл сонирхол бий тул туршлага солилцох талбар, боломжийг бүрдүүлэх, тогтмол мэдээллээр хангах чиглэлээр дэмжлэг үзүүлэх нь зүйтэй.
3. Жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд хувь нэмэр оруулах, тодорхой зорилтот бүлэгт чиглэсэн бүтээгдэхүүн гаргах чиглэлээр хэвлэл мэдээллийн нэг байгууллагатай хамтран ажиллаж сайн жишээ бий болгохыг зөвлөж байна.



*Дөрөв. Жендэрийн чиглэлээр ажилладаг оролцогч талуудын хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх чиглэлээр*

1. Сэтгүүлч, редакторууд жендэр, ЖСХ-ийн асуудлыг редакцын бодлогын түвшинд хөндөх, хамтран ажиллах, хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй байдлаар мэргэших сонирхол, хүсэл эрмэлзэлтэй боловч өөрсдөө бие даан хэрэгжүүлэхэд бэлэн бус тул тэдэнд туршлага солилцох, мэдлэгээ дээшлүүлэх талбарыг бүрдүүлэх, улмаар жендэр, ЖСХ-ийн чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагууд редакцуудад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж тогтвортой хамтран ажиллахыг зөвлөж байна.
2. Хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлэгт олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх хараат бус тогтолцоо нэгэнт бүрэлдсэн тул түүнийг цаашид хөгжүүлэх, төлөвшүүлэхэд жендэр, хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжилтнүүдийн дэмжлэг оролцоо, хамтын ажиллагаа чухал юм. Энэ тэргүүнд уулзалт хэлэлцүүлгүүд хийж ойлголтоо нэгтгэх, улмаар хамтарсан сэдэвчилсэн нэвтрүүлгүүдийг бэлтгэн хийх зэрэг арга хэмжээ хэрэгжүүлбэл үр дүнтэй.
3. Жендэрийн мэдрэмжгүй, ЖСХ-ийг сурвалжлахдаа ёс зүйн зөрчил гаргасан сэтгүүл зүйн бүтээлийн эсрэг ХМЗ-ийн ёс зүйн хороонд өргөдөл гаргах замаар сэтгүүлчдэд алдааг ойлгуулах, залруулах зэргээр сэтгүүл зүйн чанарыг дээшлүүлэхэд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэхийг санал болгож байна. Энэ хүрээнд жендэр, ЖСХ-ийн чиглэлээр редакцаас баримталж буй бодлого, нийтлэл нэвтрүүлэгт ТББ-ын оролцоотой мониторинг хийх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхийг зөвлөж байна
4. ЖСХ-ийн асуудлаарх сэтгүүл зүйн бүтээлийн ялгаатай байдал, хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд энэ чиглэлээр бичдэг сэтгүүлчдийг дэмжих тэтгэлэг, уралдаанд оролцох, гадны эх сурвалж бүтээлүүдээс танилцаж туршлага судлах, холбогдох кейсийн талаар мэдээлэл олж авахад нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна.

## **Тав. СЭТГҮҮЛ ЗҮЙН БА НИЙГМИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ /2021-2022 ОНД/**

НҮБ-аас тогтвортой хөгжилд хөтлөх 17 зорилгыг 2016-2030 онд дэвшүүлсэний 5 дахь зорилго нь Жендэрийн тэгш байдлыг хангах тухай билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлэх” мөн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн зорилт 3-т “Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлнэ” хэмээн тусгасан байдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Мөн оны 8-р сарын 17-нд Монгол Улсын Хөдөлмөр нийгэм хамгааллын сайдын А/132 тоот тушаалаар “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан.

Тус хөтөлбөрийн 3.3-т олон нийтийн хэвлэл мэдээлэл болон нийгмийн мэдээллийн сүлжээгээр дамжуулан жендэрийн эрх тэгш байдал, хэвшмэл хандлагын талаар ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох, сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн ажилтнуудын энэ талын ойлголт мэдлэгийг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажил хэрэгжүүлэх тухай тусгасан байдаг.

Энэхүү үнэлгээнд тулгуурлан “Сэтгүүл зүйн ба нийгмийн хэвлэл мэдээллийн жендэрийн бодлогын хэрэгжилтийг хангах /2021-2022/ төлөвлөгөөг доорх байдлаар боловсрууллаа. Ингэхдээ МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төлөвлөгөөнд уялдуулав.

**Үйл ажиллагааны чиглэл №1. Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг сэтгүүл зүйн ба нийгмийн хэвлэл мэдээллийн жендэрийн бодлого, үйл ажиллагааны чиглэлээр чадавхжуулах**

<i>№1</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>1.1. Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн асуудлаар сэтгүүлчид, ХМЗ-ийн ёс зүйн хорооны гишүүдэд чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах, сургагч багш нар бэлдэх</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	3.3.9. сэтгүүлч бэлтгэх сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгаж, сэтгүүлчдийг жендэрийн чиглэлээр үе шаттай сургалтад хамруулах;				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Хагас жил	2021 1-р хагас	2021 2-р хагас	2022 1-р хагас	2022 2-р хагас
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	----				
	<i>Хамтрах байгууллага</i>	ЖҮХ, ХМЗ болон хэвлэл мэдээллийн байгууллагууд				
	<i>Суурь түвшин</i>	Сургалтад хамрагдсан хүний тоо тодорхойгүй				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Сургалтын давтамж болон оролцогчдын тоо, хүйсээр, байгууллагын төрлөөр				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний жилд:</b> <b>2 дахийн жилийн эцэст:</b>				
Арга хэмжээний нэр, дугаар	<b>1.2. “Нийгмийн хэвлэл мэдээллийн жендэрийн бодлого ба өөрийн зохицуулалт” сэдвээр сургалт, нөлөөллийн ажил хийх</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	3.3.9. сэтгүүлч бэлтгэх сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгаж, сэтгүүлчдийг жендэрийн чиглэлээр үе шаттай сургалтад хамруулах;				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Хагас жил	2021 1-р хагас	2021 2-р хагас	2022 1-р хагас	2022 2-р хагас
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-				
	<i>Хамтрах байгууллага</i>	ЖҮХ, ХМЗ болон хэвлэл мэдээллийн байгууллагууд				
	<i>Суурь түвшин</i>	Энэ чиглэлээр сургалт хийгдээгүй				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Сургалтын давтамж болон оролцогчдын тоо, хүйсээр, байгууллагын төрлөөр				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний жилд:</b> <b>2 дахийн жилийн эцэст:</b>				

Арга хэмжээний нэр, дугаар	<b>1.3. “Эмэгтэй сэтгүүлчдийн эрх, аюулгүй байдал” хэлэлцүүлэг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн байгууллагуудад хандсан зөвлөмж гаргах</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	3.3.9. сэтгүүлч бэлтгэх сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгаж, сэтгүүлчдийг жендэрийн чиглэлээр үе шаттай сургалтад хамруулах;				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Хагас жил	2021 1-р хагас	2021 2-р хагас	2022 1-р хагас	2022 2-р хагас
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-				
	<i>Хамтрах байгууллага</i>	ЖҮХ, ХМЗ, бусад мэргэжлийн эвсэл холбоод				
	<i>Суурь түвшин</i>	Энэ чиглэлээр сургалт хийгдээгүй				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйсээр, байгууллагын төрлөөр зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлсэн байгууллагын тоо, байгууллагын төрлөөр				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний жилд:</b> <b>2 дахийн жилийн эцэст:</b>				

**Үйл ажиллагааны чиглэл №2. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын ёс зүйн зарчим, редакцын бодлого, мониторинг, хяналт үнэлгээнд жендэрийн агуулгыг нэвтрүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх**

№2	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>2.1. Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн жишиг редакцын бодлого боловсруулж хэлэлцүүлэх, нэвтрүүлэх</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	3.3.8. хэвлэл мэдээллийн байгууллагын жендэрийн мэдрэмжтэй байдалд дүн шинжилгээ хийх;				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Хагас жил	2021 1-р хагас	2021 2-р хагас	2022 1-р хагас	2022 2-р хагас
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-				
	<i>Хамтрах байгууллага</i>	ЖҮХ, ХМЗ, хэвлэл мэдээллийн байгууллагууд				
	<i>Суурь түвшин</i>	ЮНЕСКО: Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Жишиг редакцын бодлогын баримт бичиг, нэвтрүүлсэн редакцын тоо				

	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний жилд:</b>				
		<b>2 дахийн жилийн эцэст:</b>				
Арга хэмжээний нэр, дугаар	<b>2.2. Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран дотоод хяналт, үнэлгээнд ашиглах жендэрийн хяналтын хуудас боловсруулан туршиж нэвтрүүлэх</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	3.3.7. НҮБ-ын БСШУС-ын байгууллагаас Олон улсын сэтгүүлчдийн холбоо болон бусад түнш байгууллагатай хамтран боловсруулсан “Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт”-ийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах;				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Хагас жил	2021 1-р хагас	2021 2-р хагас	2022 1-р хагас	2022 2-р хагас
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-----				
	<i>Хамтрах байгууллага</i>	ЖҮХ, ХМЗ, хэвлэл мэдээллийн байгууллагууд				
	<i>Суурь түвшин</i>	ЮНЕСКО: Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Хяналтын хуудас, туршилтаар нэвтрүүлсэн редакцын тоо				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний жилд:</b>				
		<b>2 дахийн жилийн эцэст:</b>				
Арга хэмжээний нэр, дугаар	<b>2.3. Жендэрийн тэгш байдлыг хангах өөрийн зохицуулалтыг амжилттай хэрэгжүүлж буй жендэрийн мэдрэмжтэй редакцыг жил бүр тодруулж, хөхүүлэн дэмжих, сурталчлах</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	3.3.7. НҮБ-ын БСШУС-ын байгууллагаас Олон улсын сэтгүүлчдийн холбоо болон бусад түнш байгууллагатай хамтран боловсруулсан “Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт”-ийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах;				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Хагас жил	2021 1-р хагас	2021 2-р хагас	2022 1-р хагас	2022 2-р хагас
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-----				
	<i>Хамтрах байгууллага</i>	ЖҮХ, ХМЗ, бусад хэвлэл мэдээллийн мэргэжлийн байгууллагууд, эвсэл холбоод, редакцууд				
	<i>Суурь түвшин</i>	ЮНЕСКО: Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт				

	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Шалгуур үзүүлэлт, мониторинг, шагнал гардуулах ёслол
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний жилд:</b>
		<b>2 дахийн жилийн эцэст:</b>

**Үйл ажиллагааны чиглэл №3. Жендэрийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн үүрэг оролцоог дээшлүүлэх**

№3	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>3.1. Жендэрийн тэгш байдлыг дэмжсэн соёл, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудад хандсан уриалга/зөвлөмж гаргах</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	3.3.12. бүх нийтийн жендэрийн мэдлэгийг дээшлүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, жендэрийн асуудлаар тусгайлсан нийтлэл, нэвтрүүлгийг тогтмол гаргах; 3.3.13. 3.3.10. жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн шинэлэг дүр төрхийг бий болгох ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан үе шаттайгаар зохион байгуулах;				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Хагас жил	2021 1-р хагас	2021 2-р хагас	2022 1-р хагас	2022 2-р хагас
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-----				
	<i>Хамтрах байгууллага</i>	ЖҮХ, ХМЗ				
	<i>Суурь түвшин</i>	-				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Уриалга/зөвлөмжийн тоо, үндсэн мессэж				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний жилд:</b> <b>2 дахийн жилийн эцэст:</b>				
Арга хэмжээний нэр, дугаар	<b>3.2. Жендэрийн тэгш байдлыг дэмжихэд гадаад улс орнуудын хэвлэл мэдээллийн байгууллагуудын оруулж буй хувь нэмэр, ололт амжилт, сургамжийг танилцуулсан мэдээллийн хуудсыг улирал бүр гарган оролцогч галуудад хүргэх</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	3.3.7. НҮБ-ын БСШУС-ын байгууллагаас Олон улсын сэтгүүлчдийн холбоо болон бусад түнш байгууллагатай хамтран боловсруулсан “Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт”-ийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах;				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Хагас жил	2021 1-р хагас	2021 2-р хагас	2022 1-р хагас	2022 2-р хагас
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-----				

	<i>Хамтрах байгууллага</i>	ЖҮХ-оос хувь хүн эсвэл байгууллагатай гэрээлэн хэрэгжүүлэх				
	<i>Суурь түвшин</i>	-				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Улирал тутмын мэдээллийн хуудсын давтамж /ньюслеттэр/				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний жилд:</b>				
		<b>2 дахийн жилийн эцэст:</b>				
Арга хэмжээний нэр, дугаар	<b>3.3. Жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд хувь нэмэр оруулахуйц жишиг бүтээгдэхүүнийг хэвлэл мэдээллийн нэг байгууллагатай хамтран гаргах</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	3.3.10. жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн шинэлэг дүр төрхийг бий болгох ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан үе шаттайгаар зохион байгуулах; 3.3.14. нийгэм дэх манлайлагч, олны танил эрүүл амьдралын зан үйл, дадал эзэмшсэн эрэгтэйчүүдийн ололт, амжилтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Хагас жил	2021 1-р хагас	2021 2-р хагас	2022 1-р хагас	2022 2-р хагас
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-----				
	<i>Хамтрах байгууллага</i>	ЖҮХ, хэвлэл мэдээллийн байгууллагууд				
	<i>Суурь түвшин</i>	-				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жишиг нийтлэл, нэвтрүүлгийн тоо				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний жилд:</b>				
		<b>2 дахийн жилийн эцэст:</b>				

**Үйл ажиллагааны чиглэл №4. Жендэрийн чиглэлээр ажилладаг оролцогч талуудын хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх**

<i>№4</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>
	<b>4.1. Жендэрийн асуудлаар мэргэшсэн болон мэргэших сонирхолтой сэтгүүлчдийн туршлага солилцох, мэдлэгээ дээшлүүлэх талбарыг бүрдүүлэх</b>



Арга хэмжээний нэр, дугаар	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	3.3.9. сэтгүүлч бэлтгэх сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгаж, сэтгүүлчдийг жендэрийн чиглэлээр үе шаттай сургалтад хамруулах;				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Хагас жил	2021 1-р хагас	2021 2-р хагас	2022 1-р хагас	2022 2-р хагас
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-----				
	<i>Хариуцах нэгж</i>	ЖҮХ, ХМЗ болон бусад мэргэжлийн байгууллагууд				
	<i>Суурь түвшин</i>	-				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Сайн дурын клуб, цахим талбарт бүлэг, тогтмол уулзалтын давтамж болон гишүүнчлэл, хэрэгжүүлсэн ажлын тоо				
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний жилд: 2 дахийн жилийн эцэст:				
Арга хэмжээний нэр, дугаар	<b>4.2. Жендэр, ЖСХ-ийн чиглэлээр редаксаас баримталж буй бодлого, нийтлэл, нэвтрүүлэгт ТББ-ын оролцоотой мониторинг хийх</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	3.3.8. хэвлэл мэдээллийн байгууллагын жендэрийн мэдрэмжтэй байдалд дүн шинжилгээ хийх;				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Хагас жил	2021 1-р хагас	2021 2-р хагас	2022 1-р хагас	2022 2-р хагас
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-----				
	<i>Хамтрагч байгууллага</i>	ЖҮХ, ХМЗ болон бусад мэргэжлийн төрийн бус байгууллагууд				
	<i>Суурь түвшин</i>	-				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Мониторингийн тоо, үр дүнгийн тайлан				
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний жилд: 2 дахийн жилийн эцэст:				
Арга хэмжээний нэр, дугаар	<b>4.3. Сэтгүүлчид болон жендэр, ЖСХ-ийн чиглэлээр ажилладаг төрийн, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих зорилгоор хэлэлцүүлэг, хамтарсан нэвтрүүлэг бэлдэх</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	3.3.10. жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн шинэлэг дүр төрхийг бий болгох ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан үе шаттайгаар зохион байгуулах;				

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Хагас жил	2021 1-р хагас	2021 2-р хагас	2022 1-р хагас	2022 2-р хагас
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-----				
	<i>Хамтрагч байгууллага</i>	ЖҮХ, ХМЗ, ХЭҮТ, Хүйсийн эрх тэгш төв, Хөөрхөн зүрхнүүд ТББ, Гүнж төв, хэвлэл мэдээллийн мэргэжлийн байгууллагууд, эвсэл холбоод, редакцууд гм				
	<i>Суурь түвшин</i>	-				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Уулзалт, хэлэлцүүлэг, хамтарсан нэвтрүүлгийн тоо, хүртээмж				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний жилд:</b>				
	<b>2 дахийн жилийн эцэст:</b>					

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГИТ	Глоб Интернэшнл төв
ЖҮХ	Жендэрийн Үндэсний Хороо
ЖҮХАА	Жендэрийн Үндэсний Хорооны ажлын алба
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэн газар
ЛГБТ	Лебсиян, Гей, Бисексуал, Трансжендэр
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НҮБХАС	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүн амын сан
НХХЯ	Нийгэм хамгаалал хөдөлмөрийн яам
ОУСХ	Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо
ТББ	Төрийн бус байгууллага
ХЗДХЯ	Хууль зүйн дотоод хэргийн яам
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХМЗ	Хэвлэл мэдээллийн зөвлөл
ХХ	Хэвлэлийн Хүрээлэн
ХМБ	Хэвлэл мэдээллийн байгууллага
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ФЭС	Фридрих-Эбертийн сан
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ЭССТТ	Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, соёлын байгууллага

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖУУД

### Хэвлэмэл эх сурвалжууд:

1. “Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт”, ЮНЕСКО, 2014 онд ГИТ монгол хэлнээ хөрвүүлэв, УБ хот.
2. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан” ГИТ, 2017 он, УБ хот.
3. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоол, УБ хот.
4. “Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сэтгүүлчдийн ойлголт, редакцын бодлого, сэтгүүл зүйн практик” санал асуулга, контент анализын судалгаа, ХХ, НҮБХАС, 2017 он, УБ хот.
5. “Жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг хөндөх нь” сургалтын хөтөлбөр, ХХ, НҮБХАС, ШХА, 2017 он, УБ хот.
6. “Хохирогч төвтэй мэдээлэл: ажлын байрны бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийг эрэн сурвалжлах нь” гарын авлага, ЭССТТ, Хүйсийн тэгш эрхийн төв, 2018 он, УБ хот.
7. “Цахим сайтууд дахь үзэн ядалтын үг хэллэг” агуулгын судалгааг ХМЗ, ФЭС, 2018 он, УБ хот.
8. “Нийгмийн мэдээллийн сүлжээн дэх үзэн ядах үг хэллэг” фэйсбүүк талбар дахь агуулгын судалгаа, ЭССТТ, ХМЗ, ДВА, 2018 он, УБ хот.
9. “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр жендэрт суурилсан хүчирхийллийг хэрхэн хөндөж байна вэ?” агуулгын судалгаа, ХХ, НҮБХАС, 2019 он, УБ хот.
10. “Жендэрийн мэдрэмж ба жендэрт суурилсан хүчирхийлэл” удирдамж, ХХ, НҮБХАС, 2019 он, УБ хот.
11. “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторинг”, тайлан, ХМЗ, ГИТ, МХХ, 2019 он, УБ хот.
12. “Нийгмийн хэвлэл мэдээллийн зохицуулалт” судалгааны тайлан, ГИТ, ННХ, 2019 он, УБ хот.
13. “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ төсөл, 2020 оны 2-р сар, УБ хот.
14. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2020 он, УБ хот.
15. “Монголын хэвлэл мэдээлэл-Өнөөдөр” ХХ, 2020 он, УБ хот.
16. “Салбарын жендэрийн бодлогод оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал” ЖЕХ, АХБ, 2020 он, УБ хот.
17. “Цахим орчинд редакцын баримтлах бодлого” сурвалжлагч, редакторуудад зориулсан гарын авлага, ХМЗ, 2020 оны, УБ хот.

18. “Сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах бодлогын баримт бичиг” сурвалжлагч, редакторуудад зориулсан гарын авлага, ХМЗ, 2020 он, УБ хот.
19. “Сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн эрх зүйн зохицуулалт ба ёс зүй” мониторингийн тайлан, ХМЗ, 2020 он, УБ хот.
20. “Олон нийтийн хэвлэл мэдээллийг улс төрөөс хараат бус байлгах нь: хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын жишээн дээр, бодлогын судалгаа” Г.Гүнжидмаа, “Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа” тайлан, КАС, МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, 2020 он, УБ хот.
21. “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын гарын авлага” ХМЗ, ФЭС, 2020 он, УБ хот.

Цахим эх сурвалжууд:

1. Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөл [www.mediacouncil.mn](http://www.mediacouncil.mn)
2. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим, <https://www.mediacouncil.mn/p/7>
3. Гүржийн хэвлэлийн зөвлөлийн тайлан  
<https://www.qartia.ge/?option=content&view=category&id=7554>
4. Шведийн хэвлэлийн зөвлөл <https://medieombudsmannen.se/about-the-media-ombudsman/how-self-regulation-works/>
5. Дижитал Монгол 2020 <https://datareportal.com/reports/digital-2020-mongolia>
6. Монголын фэйсбүүк хэрэглэгчдийн тоо <https://napoleoncat.com/stats/facebook-users-in-mongolia/2019/09>
7. Фэйсбүүк хэрэглэгчид  
<https://www.socialbakers.com/statistics/facebook/pages/total/mongolia/media/page-1-2>
8. Инстаграм хэрэглэгчид <https://napoleoncat.com/stats/instagram-users-in-mongolia/2020/11>
9. Нийгмийн хэвлэл мэдээллийн нөлөөлөгчдийн тоо  
<https://starngage.com/app/global/influencer/ranking/mongolia>
10. Твиттер хэрэглэгчдийн тоо <https://www.socialbakers.com/statistics/twitter/profiles/mongolia>
11. Фэйсбүүк хэрэглэгчдийн дагаж мөрдөх хэм хэмжээ  
[https://www.gic.mn/public/docs/publications/FB\\_community\\_standards\\_final\\_190803.pdf](https://www.gic.mn/public/docs/publications/FB_community_standards_final_190803.pdf)
12. Фэйсбүүкийг эмэгтэйчүүдэд аюулгүй ээлтэй болгох мэдэгдэл  
<https://about.fb.com/news/2019/10/inside-feed-womens-safety/>
13. Нийгмийн хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт судалгааны тайлан  
[survey\\_result\\_social\\_media\\_regulation\\_191024.pdf](survey_result_social_media_regulation_191024.pdf) (gic.mn)
14. Нью Йорк таймс сонины редакцын бодлого, нийгмийн хэвлэл мэдээллийн стандарт  
<https://www.nytimes.com/editorial-standards/social-media-guidelines.html>
15. БиБиСи агентлагийн редакцын бодлого  
<https://www.bbc.com/editorialguidelines/guidance/individual-use-of-social-media>

16. Эмэгтэй сэтгүүлчдийн эсрэг цахим халдлага судалгааны тайлан, <https://www.dw.com/en/new-research-online-attacks-on-women-journalists-lead-to-real-world-violence/a-55712872>
17. Дойче Веллэгийн олон нийтийн стандарт <https://www.dw.com/en/dw-community-guidelines/a-49879333#:~:text=Ensure%20that%20your%20tone%20is,with%20what%20is%20being%20said.>
18. ХХЗХ <https://report.iwf.org.uk/mn/>
19. “Фэйсбүүк ба ХХЗХ-ны “Ногоон суваг” албан ёсоор нээгдлээ” мэдээ <https://crc.gov.mn/k/2Zh>
20. Цагдаагийн дэслэгч Б.Энхчимэг “Гэмт хэрэг дижитал хэлбэрт шилжиж байна” ярилцлага <https://police.gov.mn/a/5094>
21. ТВ мэдээ <https://www.youtube.com/watch?v=oyAWzfl7SCQ>
22. ТВ мэдээ <https://www.facebook.com/eaglenewssocial/posts/2801374713428920>
23. ТВ мэдээ <https://livetv.mn/p/168185>

## ХАВСРАЛТ

### **Жендэр, жендэрт суурилсан хүчирхийлэл – сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн редакцын бодлогод хэрхэн тусдаг вэ? санал асуулга**

Сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн байгууллагууд жендэр, ЖСХ-ийг редакцын бодлогодоо хэрхэн тусгасан талаарх товч санал асуулгыг ерөнхий редакторуудын түвшинд явуулж байна. Мэдээллийг зөвхөн бодлогын үнэлгээний ажилд зориулан ашиглах болно. Санал бодлоо хуваалцсан Танд баярлалаа.

#### **1. Жендэр, ЖСХ-ийн талаар танай редакц хамгийн сүүлд хэзээ нийтэлж нэвтрүүлсэн бэ?**

- Өчигдөр
- Сүүлийн 7 хоногт
- Сүүлийн нэг сард
- Сүүлийн улиралд
- Сүүлийн жилд
- Бусад \_\_\_\_\_

#### **2. Танай редаксаас хамгийн сүүлд хөндсөн жендэр, ЖСХ-ийн талаарх нийтлэл, нэвтрүүлгийн сэдэв юуны талаар байсан бэ?**

- Бэлгийн хүчирхийлэл
- Бие махбодийн хүчирхийлэл
- Сэтгэл санааны хүчирхийлэл
- Эдийн засгийн хүчирхийлэл
- Бусад \_\_\_\_\_

#### **3. Танай редаксаас хөндөж бичсэн жендэр, ЖСХ-ийн талаарх нийтлэл, нэвтрүүлгийнхээ товч агуулгаас хуваалцана уу?**

---

---

---

#### **4. Жендэр, ЖСХ-ийн талаар та болон танай редакцынхны ойлголт мэдлэг хэр хангалттай байна вэ?**

- Маш хангалттай

- Хангалттай, гэхдээ сайжруулах шаардлагатай
- Боломжийн дундаж түвшинд
- Хангалтгүй, энэ талын мэдлэг ойлголт дулимаг байна
- Маш хангалтгүй
- Бусад \_\_\_\_\_

**5. Танай редакцад жендэр, ЖСХ-ийн асуудлаар мэргэшсэн сэтгүүлч бий юу?**

- Тийм, хэд хэдэн сэтгүүлч бий
- Тийм, 1-2 сэтгүүлч бий
- Байхгүй, тиймээс мэргэшүүлэх шаардлагатай
- Байхгүй, ийм шаардлага байхгүй

**6. Сэтгүүлчдээ хамгийн сүүлд хэзээ жендэр, ЖСХ-ийн давтан сургалтад хамруулсан бэ?**

- Сүүлийн улиралд
- Сүүлийн жилд
- Хамруулаагүй

**7. Танай редакцад жендэрийн эрх тэгш байдал, ЖСХ-ийн талаар мэдрэмжтэй, ёс зүйтэй бичих бодлогын баримт бичиг эсвэл удирдамж бий юу?**

- Байгаа
- Байхгүй

**8. Тийм бол тэрийгээ хэдэн онд хэрхэн яаж боловсруулсан гол агуулгын талаар хуваалцана уу.**

---

---

---

**9. Жендэр, ЖСХ-ийн талаар бичихдээ Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын хүрээнд юуг анхаарвал зохистой хэмээн Та үзэж байна вэ?**

- Хохирогчийг хамгаалах
- Эх сурвалжийн эрх тэгш оролцоог хангах
- Хувийн нууцад хүндэтгэлтэй хандах
- Хүнлэг байж хүн чанарыг эрхэмлэх
- Бусад



**10. Жендэр, ЖСХ-ийн талаар бичих, нэвтрүүлэхдээ юунд илүү анхаарах шаардлагатай, мөн сэтгүүлчдийг мэдлэг ур чадварыг дээшлүүлэхэд юу хийх хэрэгтэй гэж Та үзэж байна вэ?**

---

---

---

**11. Та хаана ажилладаг вэ?**

- Сонин, сэтгүүл
- Цахим мэдээллийн сайт
- Телевиз радио
- Орон нутгийн хэвлэл мэдээлэл
- Бусад

**12. Таны хүйс**

- Эрэгтэй
- Эмэгтэй
- Бусад

**13. Таны албан тушаал**

- Ерөнхий эрхлэгч
- Ерөнхий редактор
- Сэтгүүлч, сурвалжлагч, тоймч гм
- Бусад

**14. Та аль хэвлэл мэдээллийн редакцад ажилладаг вэ? /нэрийг бичнэ үү/ Танд баярлалаа**

---

---